

Дâäâàéöèéí çóðâàñ

## Î Í -ËÀÉÍ ÑÝÒÃ- Ë ÁÎ ËÎ ÕÝÖËÝË

“Монголын анагаах ухаан” сэтгүүл энэ жил тав дахь арван жилийнхээ эхний онд орж буй тэмдэглэлт ой тохиож байна. Монголчууд “Дөч хурсэн эр, дөрөв дарсан ат” гэж ярьдаг нь “дөч хурсэн эр хүн амьдралын туршлага төгс болсон байдаг” гэсэн санаа гэж толь бичигт тайлбарлажээ<sup>1</sup>. Тийм ч учраас манай сэтгүүл Монголын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн дотор ахмадынх нь нэг болж, өөрийн байр суурийг баттай эзлэсэн, нэгэн цагт “эрдэм шинжилгээний хамгийн сайн сэтгүүл”<sup>2</sup> хэмээн үнэлгэдэж асан байр суурийг нь баталгаажуулсан гэж эрэлхийлж явдгийн хувьд, хоёр жилийн өмнөөс хөөцөлдөж эхэлсэн сэтгүүлээ онлайн (электрон буюу цахим) хувилбартай болгох гэсэн санаа маань энэ жил хэрэгжих боломжтой болсон бэлэгтэйгээр энэ шинэ үетэй золгуулж байгаадаа би их баяртай байна.

Электрон сонин, сэтгүүлийн түүхийг интернетээр шүүрдэж үзвэл Дэлхийн байгаль шинжлэлийн хамгийн эртний, нэр хүндтэй сэтгүүл болох “Nature” 1995 онд анх өөрийн вэбсайттай, электрон хувилбартай болсон байна<sup>3</sup>. Нийтийн сонин сэтгүүлүүд үнээс санаа авч, анх “Washington Post” хэмээх өдөр тутмын зузаан сонин 1996 онд өөрийн вэбсайт, электрон хувилбартай болжээ<sup>4</sup>. Манайд бол харин нийтийн сонин, сэтгүүлээс шүүрдэж мэдээ нийтэлдэг <http://sonin.mn> вэбсайт 2008 оны 3 дугаар сараас ажиллаж эхлээд, “Өнөөдөр”, “Өдрийн сонин” зэрэг өдөр тутмын зузаан сонинууд 2009 оноос электрон хувилбартай болсон билээ. Харамсалтай нь манай эрдэм шинжилгээний сэтгүүлүүд электрон хувилбартай болж эхлээгүй л байна. Энэ нь манай шинжлэх ухааны үнэлэмжийн нэг үзүүлэлт, нөгөө талаар эрдэмтэд бид сэтгүүлчдээс зах зээлийн овсгоо, нийтэд хүрэх, нийгэмд нөлөөлөх эрмэлзэл дутмаг байгаагийн илэрхийлэл болох буйз�а.

Интернет сүлжээгээр англи хэл дээрхи мэргэжлийн мэдээлэл ашигласан сүүлийн 20 орчим жилийнхээ туршлага дээр үндэслэн сэтгүүлийнхээ захиалгыг бүр унагачихгүйгээр мэдээллийн ашиглалтыг нь сайжруулах арга замыг бид энэ жилээс хамтдаа хайх болно. Юуны өмнө сэтгүүлийнхээ хуучин дугааруудыг 2009 оныхоос нь эхлээд арагш нь бүгдийг он-лайн

хэлбэрт оруулж, чөлөөтэй ашиглах, сонирхсон түлхүүр үгээрээ хайлт хийж, уг сэдвээр манай судлаачид хэзээ анх судлаж эхлэв, ямар үр дүнд хүрч байв, одоо хэн судлаж байна гэдгийг гадаад, дотоодын судлаачид шүүрдэн олж үзэх, ашиглах бололцоог бий болгоход гол анхаарлаа чиглүүлнэ. Одоогийн интернет хайлтын давуу талыг ашиглан манай судлаачид гадаад мэдээллийг хангалттай авч буй мөртгөө дотоод мэдээллийг шүүн олж үзэх бололцоогүй байсан хязгаарлалыг үүгээр давах бололцоотой болно гэж бодож байна. Гэвч сэтгүүлийнхээ захиалгыг бүр унагачихгүй тулд шинэ оны дугааруудаас бол зөвхөн монгол, англи товчлолыг л чөлөөтэй үзэж болохоор хийж, захиалагчид бол өөрийн код ашиглан бүрэн үзэж болох, захиалаагүй уншигч бол төлбөр хийгээд ашиглаж болохоор хийх нь зүйтэй гэж төлөвлөж байна.

Он-лайн хувилбартай болсоор сэтгүүл маань зөвхөн захиалагчдын хүрээнд байх хязгаарлалтыг давж, судлаачдын маань нийтлэл дэлхий дахинд ашиглагдах бололцоо нэмэгдэж, манай эрдэмтэн судлаачдын үнэлэмжийг нэмэгдүүлнэ гэдэгт би эргэлзэхгүй байна. Нөгөө талаар бичигчид, хянан магадлагсадын маань хариуцлагыг ч ихээхэн нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл сэтгүүл маань, түүний дугаар болгонд гарсан нийтлэл нь хэн хүссэн хүнд, зөвхөн эрдэмтдэд бус, сонирхсон бүх уншигчдад бодит хугацаанд хүрч байх болно. Бас хэвлэмэл сэтгүүлд байдаггүй нийтлэлийн ашиглалтын индексээр нь судлаачдын бүтээмжийг үнэлэх, видео-хавсралт, хэлэлцүүлэг г.м. эрдэм шинжилгээний мэдээллийн шинэ хэлбэр эргэлтэд орох бололцоо нээгдэнэ. Аливаа шинэ эхлэлийн жишгээр энэ маань амаргүй ажил байх боловч, одоогийн манай редакцийн зөвлөл, манай бичигчид болон уншигчдын хамтын хүчээр бэрхшээл болгоныг даван гарч, Монгол улсад эрдэм шинжилгээний мэдээллийн он-лайн урсгалыг эхлүүлсэн түүчээ болж чадна гэдэгт би эргэлзэхгүй байна.

Àéàââàì è÷ ï. ï ýì äââàà, Ñýòã¿ëèéí çº äéº èèéí òýðã¿ëéýâ ãéº ¿éí

2010.03.31; 2010.04.03; 2010.04.06

<sup>1</sup> Î ëí ãâ ë öëññ í Ø (2008): Î ëí ãâ ë öÿëí èé äÿéäyðý áçé ðâééââð ðí ëü, Åºí ðëéé ðââââð ð Ë.Á.ëä, II áí ðü (Å-Ë), 6.736;

<sup>2</sup> “Î ëí ãâ ëü í ëééí í ëééðééí i yâééééééí ðýðâýðé (î ëí Ø)-ëéí ðí éí , Ôââñðâëð: Î ëí Ø-ëéí î áí áæí áí ð” (2001): <sup>1</sup> 5(5):8-9: Ýðâý ñéééí áæééáýéí èé ðàí áðééí ñâééí ñýðâýðé;

<sup>3</sup> <http://www.nature.com/nature/history/timeline.html> accessed on April 6, 2010;

<sup>4</sup> [http://www.washpost.com/gen\\_info/history/timeline/index.shtml](http://www.washpost.com/gen_info/history/timeline/index.shtml) accessed on April 6, 2010;

## Ö<sup>a</sup> ÑÍ ÈÉ Ö-ÄÈÉÍ ÖÎ xì Ì Ä-ÐÝÂÑÝË ÕÓÃÃÖÃÀÍ ÀÃÑ ÕÃÌ ÀÃÐÃÒ ÁÃÉÃË Æ ÑÓÃÃËÑÃÍ Í Ü

Ö.Áóýí ááð<sup>1</sup>, Ö.Áàð -Î ðø èð<sup>1</sup>, Í.Í ãñàí ð öýà,<sup>1</sup> Í .Àëð àí öðýä<sup>1</sup> ÅÁýì áàñçðýí,<sup>1</sup> È.Öýðýý<sup>1</sup>, Å.Àëð àí ð öýà<sup>1</sup> Ø .Öýðýí èððàí<sup>2</sup>

<sup>1</sup>ÖÃÃÖÍ Ý, <sup>2</sup>×ÄÍ Ý

### TIME DEPENDING CHANGES OF ACUTE CHOLECYSTITIS

Buyanbat Ts<sup>1</sup>, Bat-Orshikh Kh<sup>1</sup>, Nasantuya N<sup>1</sup>, Altankhuyag M<sup>1</sup>, Byambasuren G<sup>1</sup>, Tsetsgee L<sup>1</sup>, Altantuya B<sup>1</sup>, SH.TSerenlham<sup>2</sup>

<sup>1</sup>Central Clinical Hospital for State Special Clerks

<sup>2</sup>Chingeltei District Hospital

#### **Background**

Acute cholecystitis is defined mostly as bacteria from intestinal inflammation to gallbladder. Sometimes the inflammation can occur when bacteria and viral can flow by blood and lymphus. Acute cholecystitis is leading the second place of acute abdomen. (1.2.3.7.8). The acute cholecystitis complication is not decreasing(4.5.6). The mortality is 0.5-0.8% (2.4.5.9). The acute cholecystitis is comparing with cholelith. Foreign scientists are recommending that first 24-48 hours to treat by drugs, and after that if inflammation is not healing to do cholecystectomy. In our country the acute cholecystitis is taking the place after acute abdomen and appendicitis. And also, acute cholecystitis morbidity is not decreasing and indication of cholecystectomy is not decided yet.

#### **Objective**

The main purpose of this survey is to study changing of acute cholecystitis depending on time

#### **Materials and Methods**

We studied 58 patients who had cholecystectomy in Surgical Department of The Central Clinical Hospital for State Special Clerks between 2005 and 2008. The result analyzed by SPSS-15.0 Program.

#### **Result and Discussion**

The patients who was studied were 14 men (24.14%) and 44 women (75.86%). For the clinical symptoms of acute cholecystitis, the result has been occurred as following: the epigastria pain is 17 (29.31±5.9), around the right rib arch is 49 (84.48±4.7), the pain spread of the right shoulder blade is 20 (34.48±6.2), and the pain spread of the right shoulder is 33 (56.89±6.5), to have a fever 6 (10.34±3.0), vomit 10 (17.24±4.9), diarrhea 7 (12.06±4.2), thirsty 16 (27.58±5.8). The pain around right rib arch, pain spread right arm and shoulder, and thirsty are the clinical features that close to the features of scientist's Alperovich B.I., Soloviev M.M., Saveliev V.S. Acute cholecystitis depending on time 0-24 hours catarrhal 5, phlegmonous 2, necrosis 1, 24-48 hours phlegmonous 4, necrosis 10, necrosis hole 2, 48-72 hours phlegmonous 10, necrosis 8, necrosis hole 3, above 72 hours phlegmonous 2, necrosis 5, necrosis hole 6. Acute cholecystitis starts above 24 hours.

#### **Conclusion**

1. The acute cholecystitis has been occurred 14 for men and 44 for women. Ate the age of 30-39. These cases were determined more than 31 percent.
2. For the clinical symptoms of acute cholesystitis, the result has been occurred as following:
  - the epigastria pain is 17, (29.31±5.9)
  - around the right rib arch is 49 (84.48±4.7)
  - the pain spread of the right shoulder blade is 20 (34.48±6.2), and
  - the pain spread of the right shoulder is 33 (56.89±6.5).
3. Under the period study of the acute cholecystitis, the pus, necrosis and perforation cases have been excessively occurred specially at 48-72 hours.
4. Under the comparison study between the acute cholecystitis and its period, the acute wall cholecystitis changes have been occurred specially at 24-48 hours.

**Key words:** cholelith, cholecystectomy, cholecystitis

Pp. 2-4, Table 1, Figures 2, References 9

### Ноён аадааийн урүүлэгчийн төслийн түүхийн хувь

Цэсний хүүдийн цочмог үрэвсэл нь ихэнх тохиолдолд гэдэснээс нян цэсний замаар өгсөний үр дүнд үүсэх ба зарим тохиолдолд халдварт, вирусээр үүсгэгдэхдээ цус тунгалаараа дамжих цэсний хүүдийн цочмог үрэвслийг үүсгэдэг.

Цэсний хүүдийн цочмог үрэвсэл нь хэвллийн хөндийн цочмог үрэвслүүдийн дунд 2-р байр эзэлж [1, 2, 3, 7, 8] хүндрэл нь төдийлэн буурахгүй байна [4, 5, 6].

Нас баралт 0.5-0.8% (2, 4, 5, 9). Цэсний хүүдийн цочмог үрэвсэл нь цэс чулуужих өвчинтэй хавсарч тохиолдох нь элбэг. Цэсний хүүдийн цочмог үрэвслийн үед эмийн эмчилгээг 24-48 цагт хийж үрэвсэл намдахгүй тохиолдолд мэс заслын эмчилгээг хийх шаардлагатай гэж гаднын эрдэмтэд үздэг байна.

Манай оронд, цэсний хүүдийн цочмог үрэвсэл нь хэвллийн хөндийн яаралтай мэс заслын өвчинүүдийн дунд мухар олгойн дараа орж байна. Цэсний хүүдийн цочмог үрэвсэл төдийлэн буурахгүй мэс заслын эмчилгээний заалт нь бүрэн шийдвэрлэгдээгүй байна.

### Ноён аадааийн урүүлэгчийн төслийн түүхийн хувь

Цэсний хүүдийн цочмог үрэвсэл хугацаанаас хэрхэн хамаарч өөрчлөлт гарч байгааг судлахад оршино.

### Ноён аадааийн урүүлэгчийн төслийн түүхийн хувь

Дээрхи зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах үндсэн зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цэсний хүүдийн цочмог үрэвслээр өвчлөгсөдийн нас, хүйсний байдлыг судлах
2. Цэсний хүүдийн цочмог үрэвслийн клиникийн шинж тэмдгүүдийг судлах
3. Цэсний хүүдийн үрэвслийн хугацааг судлах
4. Цэсний хүүдийн үрэвсэл хугацаанаас хэрхэн хамаарч өөрчлөлт гарсан байдалд судалгаа хийж судалгааны үр дүнг статистик боловсруулалтын SPSS-15.0 программ дээр боловсруулав.


### Ноён аадааийн урүүлэгчийн төслийн түүхийн хувь

ТТАХНЭ-ийн мэс заслын тасагт 2005-2008 онуудад цэсний хүүдийн цочмог үрэвслээр хэвтэж мэс засал эмчилгээ хийлгэсэн 58 өвчтөнг түүвэрлэлтийн аргаар цэсний хүүдийн цочмог үрэвсэл хугацаанаас хамаарч хэрхэн өөрчлөлт гарсан байдалд судалгаа хийж судалгааны үр дүнг статистик боловсруулалтын SPSS-15.0 программ дээр боловсруулав.

### Ноён аадааийн урүүлэгчийн төслийн түүхийн хувь

Бидний судалгаанаас үзэхэд цэсний хүүдийн цочмог үрэвслэлтэй 58 өвчтнөөс эрэгтэй 14 (24.14%), эмэгтэй 44 (75.86%).


#### Тохиолдлын хувь



Соодлаа 1. Өвчтнөөс эрэгтэй 14 наасны үрэвслийн хувь

### Ноён аадааийн урүүлэгчийн төслийн түүхийн хувь

Насны байдлаар нь авч үзвэл 30-39 наасных 31.03 ± 6, 40-49 наасных 22.41 ± 5.4, 50-59 наасных 20.60 ± 5.3, 60-69 наасных 8.62 ± 3.6, 69 дээш наасных 10.34 ± 3.9, 19-29 наасных 7 ± 3.3 байна. Бидний хийсэн судалгаанаас үзэхэд 30-39 наасных 18 буюу 31.03 ± 6, 40-49 наасных 13 буюу 22.41 ± 5.4 илүү тохиолдож байгаа нь эрдэмтэн Д.Ф.Скрипниченко., Б.А.Королева., Д.Л.Пиковский., Б.А.Петрова., Г.П.Макаренкогийнхаас зөрөөтэй байгаа нь бид хүчний байгууллагын хүмүүст үйлчилдэгтэй холбоотой. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бага өвчлөлтэй байгаа нь А.В.Каблукова., Б.А.Петров., Э.И.Гальперин., Д.Ф.Скрипниченкогийнхтай ойролцоо байна.



Соодлаа 2. Өвчтнөөс эрэгтэй 14 наасны үрэвслийн хувь

Цэсний хүүдийн цочмог үрэвслийн эмнэлэгүйн шинж тэмдэгүүдийг авч үзвэл: Аюулхай орчим өвдөх 17 (29.31 ± 5.9), баруун хавирганы нум орчмоор өвдөх 49 (84.48 ± 4.7), баруун дал мөрлүү дамжих өвдөх 20 (34.48 ± 6.29), баруун гар мөрлүү дамжих 33 (59.89 ± 6.5), халтуурах 6 (10.34 ± 3.0), бөөлжих 10 (17.24 ± 4.9), гүйлгэлт 7 (12.06 ± 4.2), ам хатах 16 (27.58 ± 5.8). Баруун хавирганы нум орчмоор өвдөх, баруун гар мөр лүү дамжих, баруун дал мөрлүү дамжих, ам хатах шинж давамгайлж байгаа нь эрдэмтэн Б.И.Альперович., М.М.Соловьев., В.С.Савельев нарынхтай ойролцоо байна.

Хүснэгт-1. Өвчтнөөс эрэгтэй 14 наасны үрэвслийн хувь

Одээлээ	Өвчтнөөс эрэгтэй			Едийнүүдэл			Өвчтнөөс эрэгтэй			Одээлээ		
	n	%	±tm	n	%	±tm	n	%	±tm	n	%	±tm
0-24 цагт	5	8.62	3.6	2	3.44	2.3	1	1.72	1.7	-	-	-
24-48 цагт	-	-	-	4	6.89	3.3	10	17.24	4.9	2	3.44	2.3
48-72 цагийн дараа	-	-	-	10	17.24	4.9	8	13.79	4.5	3	5.17	2.9
72 цагас дээш	-	-	-	2	3.44	2.3	5	8.62	3.6	6	10.34	3.9
Ажлаа										58		

1. Цэсний хүүдийн үрэвсэл хугацаатай хэрхэн холбоотой байдлыг судлахад 0-24 одээлээ улаймал 5, идээлсэн 2, үхэжсэн 1, 24-48 одээлээ идээлсэн 4, үхэжсэн 10, үхжиж цоорсон 2, 48-72 одээлээ дараа идээлсэн 10, үхэжсэн 8, үхжиж цоорсон 3, 72 одээлээ дээш идээлсэн 2, үхэжсэн 5, үхжиж цоорсон 6 байна.
2. Цэсний хүүдийн үрэвсэлийн хугацааг авч үзэхэд

### Ноён аадааийн өвчтнөөс эрэгтэй 14 наасны үрэвслийн хувь

24 цагаас дээш цөсний хүүдийн үрэвслийн өөрчлөлт ихсэж байна. Энэ нь эрдэмтэн В.С.Савельев 2003., Б.И.Альперович, М.М.Соловьев 2004 нарынхаар 24-48 цагийн дараа, Монголын эрдэмтдийн 48-72 цагийн дараа цөсний хурц үрэвсэл намжихгүй байвал хагалгаа хийх тактикийг дахин судлах шаардлагатайг харуулж байна.

#### Äžäý ýëö:

1. Цөсний хүүдийн цочмог үрэвсэл нь эрэгтэй 14 (24.14%), эмэгтэй 44 (75.86%) байна. 30-39 насанд  $31.03 \pm 6$  буюу илүү тохиолдолж байгааг тогтоов.
2. Цөсний хүүдийн цочмог үрэвслийн клиник шинж тэмдгүүдээс аюулхай орчим өвдөх 17 ( $29.31 \pm 5.9$ ), баруун хавирганы нум орчмоор өвдөх 49 ( $84.48 \pm 4.7$ ), баруун дал мөрлүү дамжих өвдөх 20 ( $34.48 \pm 6.2$ ), баруун гар мөр лүү дамжих 33 ( $56.89 \pm 6.5$ ) зэрэг шинж тэмдгүүд давамгайлж байна.
3. Цөсний хүүдийн цочмог үрэвслийн хугацааг судлахад 48-72 цагт идээлсэн, үхэжсэн, үхжиж цоорсон нь илүү тохиолдож байгааг илрүүлэв.

4. Цөсний хүүдийн цочмог үрэвслийг хугацаатай хэрхэн хамааралтайг судлахад 24-48 цагт илүү цөсний хүүдийн ханын өөрчлөлт ажиглагдлаа.

#### I i cçé

1. Альперович Б.И., Соловьев М.М. Неотложная хирургия живота. Томск 2000г. С32-34
2. Бебуримими А.Г., Савельев В.С. Острый холецистит. 5 лекции по хирургии 2003г. С206-208
3. Королев Б.А., Попов С.Д. Реконструктивные операции на желчных путях М.1999. с18-22
4. Королев Б.А., Пиковский Д.Л. Экстренная хирургия желчных путей 1990. Частная хирургия (ред Ю.Л.Жевченко) 1997-2000.с28-30
5. Тальман И.М. –Хирургия желчного пузыря и желчных протоков. Медгиз 1963г. С22-26
6. Б. Гоош . Мэс заслын өвчин 2000он сг 342-344
7. Bismuth H, Kunziger H, Corlette M.B. Cholangitis with Acute Renal Failure // Ann. Surg, 1975- 181(6).-C.881-7
8. Chang W., Lee K., Wong S.,Chuang Ch., Kuo K.,Chen J., Sheen P. Bacteriology and Antimicrobial Susceptibility in Biliary Tract Disease: An Audit of 10- Years Experience // Journal of HepatoBiliary Pancreatic Surgery- 5 th World Congress of the international Hepato-Pancreato-Biliary Association.- Tokyo, Aplir 25-29, 2002.-F-253.
9. Raughneen P.T., Kumar S.C., Pellis N.R., Rowlands B.J. Endotoxemia and Cholestasis // Surg. Gynecol. Obstet. 1988-167(9): p.205-10.

Òàì èëöààæ í èéò öýö ñàí àë °ññø í :  
Àéàäâì è÷ í .Áåâñàí ääâà

## I Í Í Ä Ë Ä ÖÝÝÆÍ ÈÉ Ä ë ÑÓÄÄÑÍ Ù ÖÐÓÖÄÄÖ ÖÝÑÄÈÉÍ Ö-ËÖÝÍ Ä ÑÓÄÄÑÍ Ä ë ÖÓÖÐÖ ÄÐÄÄÄÐ ÑÒÁ ò ÄÐÄÖÖ ÒÀÄÜÆ Ý ì ×ÈËÑÝÍ Ä ë Õ Ù Ä ë ÕÈÍ ËÄÍ Ë

Ç.Öðàäâàñ; ðýí<sup>1</sup>, Marcus Howell<sup>2</sup>, Ä.Öýäýýí æ àä<sup>3</sup>, Í .Áåâñàí æ àä<sup>3</sup>, Á.Áödi àä<sup>4</sup>

<sup>1</sup>Í .Ø àñò èí û õ ° â ÿ í yéýä, <sup>2</sup>Christian Medical & Dental Associations-USA, <sup>3</sup>Äí àäâàð ñòðàí û õ; ðýýéýí <sup>4</sup>Ý ì Ø ÖÈÑ- ÀÓÑ

## FIRST SUCCESSFUL ENDOVASCULAR REPAIR OF DESCENDING THORACIC AORTIC ANEURYSM IN MONGOLIA

Z.Lkhagvasuren<sup>1</sup>, Marcus Howell<sup>2</sup>, D.Tsegeenjav<sup>3</sup>, N.Baasanjav<sup>3</sup>, B.Burmaa<sup>4</sup>

<sup>1</sup> Shastin Central Hospital, <sup>2</sup>Christian Medical & Dental Associations-USA,  
<sup>3</sup> National Medical Institute, <sup>4</sup> Health Sciences University of Mongolia

Endovascular repair of descending thoracic aortic aneurysm is an attractive approach. Candidates for endovascular repair should have an inner aortic diameter of 23-37 mm adjacent to the aneurysm without significant thrombus or calcification in these so called landing zones. They should have at least 2 cm of normal aorta both proximal and distal to the aneurysm to ensure adequate fixation of the device.

Endografting of the descending thoracic aorta requires preoperative measurements of the diameter of the proximal and distal necks of the aneurysm, treatment length, and proximal and distal angulation. This information can be obtained from CT-ic angiography using three dimensional reconstruction.

Key words: Stent graft, Endovascular repair, Talent AAA Xcelerent Delivery-system, thoracic aortic aneurysm

Pp. 4-7, Tables 3, References 13

Цүлхэнт өөрчлөлт нь хүний биеийн гол судасны аль ч хэсэгт үүсэж болох бөгөөд судасны ханын холбогч эд коллаген ба эластин ширхэгийн бүтцэд голомтот болон тархмал хэлбэрийн өөрчлөлт орж, arterийн судасны голч хэвийн хэмжээнээс 50-иас дээш хувиар ихсэж, гол судасны хана хэсэг газарт болон тархмал байдлаар гадагш тэлэгдэн цүлхийж, товоин гарахыг цүлхэн гэж үздэг. Гол судасны цүлхэнгийн ихэнхийг хэвлэлийн гол судасны цүлхэн эзлэх бөгөөд дийлэнх нь тодорхой шинж тэмдэггүй байх боловч цүлхэн хагарч цус алдаж нас барах хүндрэл гарах аюул ихтэй байдаг.

Цээжний гол судасны цүлхэн (ЦГСЦ) төрөлхийн болон олдмол шалтгаантай байх бөгөөд төрөлхийн шалтгааны дотор Марфан, медионекроз, олдмол шалтгаанд атеросклероз, arterийн дараалт ихсэлт, гол судасны хавхлагийн дутагдал, өвөрмөц бус аортоarterиит, сифилис, гэмтэл зэрэг олон хүчин зүйл байх ба зарим тохиолдолд мэс ажилбарын дараа цүлхэн үүсдэг.

Хэвлэлийн материалыас үзэхэд ЦГСЦ үүсэхэд атеросклероз 24-31.0%, сифилис 3.2-12.2%, гэмтэл 2.2-8.0%, медионекроз 45-53.8%, марфан 12.8-26.9%-ийг эзэлдэг байна (А.И.Млашев 1996, Pitt M.P., Bonzer 1997., А.А.Спиридовон 1998.), Schepens M. (1995), Svenson L.G., Crawford E.S. (1997) Ю.В.Белов(2001) нарын судалгаагаар цүлхэнний нийт тохиолдлын дотор ЦГС-ы уруудах хэсгийн цүлхэн 19-22.0% тохиолддог байна (2,6).

Цээжний гол судасны цүлхэнгийн байрлалын Croswfod, Stanford-ын гэх мэт олон ангилал байдаг боловч сүүлийн үед 1997 онд гарсан De Bekey-ийн ангилалыг хэрэглэдэг болсон (1, 7).

ЦГСЦ АНУ-д жил бүр 15000 тохиолдол бүртгэгдэж, 47000 гаруй хүн гол судасны эмгэгийн улмаас нас барж байгаа нь хөхний хорт хавдар, ДОХ, авто ослын нас баралтаас их байгаа нь гол судасны эмгэг нь чимээгүй тахал болоод байгааг харуулж байна. Гол судасны цүлхэнний хагралыншалтгаант нас баралт нийт нас баралтын 15-рт орох шалтгаан болж цээжний гол судасны цүлхэн нь 100,000 хүн амьд 6 тохиолддог байна. Судалгаагаар гол судасны хууралт 100,000-д 3.5; цээжний гол судасны хагарал -3.5; хэвлэлийн гол судасны хагарал - 9 тохиолдол бүртгэгдэж байна. Аневризмын хагарал нь аюултай хүндрэл бөгөөд тухайн хүний амийг аврах, хүндрэлээс сэргийлэхийн тулд яяралтай хагалгаа шаардагдана. Гол судасны цүлхэнний тохиолдол буурахгүй байгаа нь дэлхийн олонхи орны хүн амын дундаж наслалт уртассан, атеросклероз ихэссэнтэй холбоотой (9,10).

Хэвлэлийн гол судасны цүлхийлт нь эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс 5-10 дахин их, тамхичидад 8 дахин их тохиолддог байна(10).

Манай оронд Д.Цэгээнжавын 1999, 2008 онуудад хийгдсэн судалгаагаар arterийн судасны мэс заслын эмгэгийн дотор гол судасны цүлхэн 13.9%-ийг эзэлж түүний дотор ЦГСЦ 47.0-51.2% эзлэх болсон байна. ЦГСЦ-ий дотор өгсөх хэсгийн цүлхэн 72%, нумынх 5.9%, уруудах хэсгийнх 9.2% тохиолдож байгаа бөгөөд цүлхэний хана хуурч урагдах хүндрэл 23.5% тохиолдожээ (3,5 ).

ЦГСЦ-ий шалтгааны дотор атеросклероз 67.8%, гэмтэл 7.1%, сифилис 3.5%, марфан 21.4%-ийг эзэлж байна (2,4).

Сүүлийн 10 гаруй жилүүдэд гол судасны цүлхэнний эмчилгээнд судсан дотуурх мэс заслын эмчилгээ

нэвтэрснээр нээлттэй хагалгааны тоо буурч, цүлхэнд стент тавих эмчилгээний арга жилээс жилд нэмэгдэх болсон байна.

1994 онд Dake болон түүний хамтрагчид цүлхэний судсан дотуурхи мэс заслын эмчилгээний эхлэлийг тавьж анхны хагалгааг амжилттай гүйцэтгэсэн байдаг.

АНУ-д 1994-2003 онд хийгдсэн судалгаагаар хэвлэлийн гол судасны цүлхэнний(ХГСЦ) үед судсан дотуурх аргаар graft стент тавих эмчилгээ бараг 50.0% эзлэх болсон байна. Нээлттэй мэс заслын аргаар цүлхэнг эмчлэх мэс заслын дараах эрсдэл нас баралт сүүлийн үед буурч байгаа хэдий ч 5.1-5.2% ийг эзэлдэг (Пеменев В.Л. 2001), харин судсан дотуур graft стент тавих эмчилгээний дараах нас баралт 1.0-2.6% байгаа нь хоёр дахь арга нь илүү эрсдэл багатай болох нь харагдаж байна.

Манай оронд цээжний өгсөх болон уруудах хэсгийн цүлхэнд хэд хэдэн удаа нээлттэй мэс заслыг амжилттай хийсэн ба судсан дотуурх мэс заслын аргаар гол судасны цүлхэнг эмчилсэн анхных нь бидний мэдээлж байгаа энэ тохиолдол юм.

#### 1. УАУҮӨӨӨЕИ СИДӨӨАА:

- Цээжний гол судасны уруудах хэсгийн цүлхэнг судсан дотуурх аргаар эмчилсэн үр дүнг мэдээлэх
- Гол судасны цүлхэнг цусгүй шинжилгээний аргуудаар эрт илрүүлэн оношлож, судсан дотуурх мэс заслын аргаар Stent Graft, Talent AAA Xcelerent Delivery системээр эмчлэх боломжийг судлан EVAR системийг тавих арга барилд гаршин суралцан, захиалан олж хэрэглэдэг болох.

#### 2. ИҮҮСҮҮЛЭЛТ:

Өвчтөн А, 45 настай эрэгтэй. 2009-04-19 нд ШТЭ-ийн Зүрх судасны мэс заслын тасагт (өвчний түүх 04865) цээжний гол судасны уруудах хэсгийн цүлхэн оношоор хэвтсэн. Ирэх үед цээжээр өвдөх, зүүн далны араар нэвт хүндэрч өвдөх зовиуртай. Үзлэгээр: Зүрхний авиа тод жигд шуугиангүй, далны араар агшилтын шуугиантай. Артерийн дараалт 130/80 мм. муб.


ЭхоКГ-ийн шинжилгээнд зүүн ховдлын хэмжээ томроогүй Ao-2.8, EF-60%, FS-30 E/A-1.2 IVRT-80m/s Цээжний гол судасны уруудах хэсэгт цүлхэн үүссэн гэсэн дүгнэлт өгсөн.

Компьютертомографи: Шинжилгээгээр цээжний гол судасны уруудах хэсэгт 3.0x3.2 мм хэмжээний цүлхэн үүссэн болохыг тогтоосон (Зураг 1).

MRI-ангиографи: Гол судасны цүлхэнний байрлал, хэмжээ хана, цүлхэнний дээд ба доод хүзүүвчийн байдлыг нарийвчлан тогтоосон нь СДМЗ-ын эмчилгээний аргаар эмчлэх боломжтой болсон (Зураг 2).

Аортографи: Хэдийгээр компьютерт томографийн шинжилгээгээр цээжний гол судасны уруудах хэсгийн цүлхэн байгаа нь тогтоогдсон боловч цүлхэн дахь цусны урсгал, эмгэг хаялтын байдал, уг цүлхэн гол судасны салаа судсыг хамарсан эсэхийг тодорхойлох зорилгоор аортографийн шинжилгээ хийсэн юм. Аортографийн шинжилгээнд цээжний гол судасны уруудах хэсгийн дээд урд хажуу ханын гадна хэсэгт гол судасны интим гэмтэж гадагшаагаа 30.0 x 30.0 мм хэмжээний хэсэг газрын цүлхэн үүссэн, тэр хэсэгт цусны хуйларсан урсгал орж байгаа нь тогтоогдсон юм (Зураг 3).

Эмч нарын зөвөлгөөнөөр: “Цээжний гол судасны уруудах хэсгийн цүлхэн, хүндрээгүй хэлбэр” гэсэн онош тавьж цүлхэнг арилгах мэс засал эмчилгээ хийх нь зүйтэй гэж шийдсэн. Тухайн тохиолдолд эмчлүүлэгчийн биеийн байдал хөнгөн, цүлхэний хэмжээ их том биш 50.0 мм хүрээгүй байсан учраас нээлттэй мэс засал хийхгүйгээр судсан дотуурхи аргаар цүлхэнийг цаашид хагарахаас сэргийлж, графт стент тавих эмчилгээ хийх боломжтой гэж үзсэн. Иймээс сарын дараа Монголд ирэх Америкийн эмчийг хүлээх нь зүйтэй гэж үзээд эмчлүүлэгчийн материалыг M.Howell докторт илгээнээр өөрийн оронд анх удаа гол судасны цүлхэнд “Graft-Stent” тавих боломж нээгдсэн юм.



Çöðää 1. Èí i üþ o åðò o i i ãðåô èéí ø èí æèëäýäýööýäýæ èé aï ë ñóðàñí û óððóäàð öýñâèéí öððööýí aï o i àð i i ññ i i ü (21.03.2009)



Çöðää 2. Öýýæ èé aï ë ñóðàñí û óððóäàð öýñâèéí öððööýí èé i RL-àð aï ãðåô èéí çöðääæäé (27.03.2009)



Çöðää 3. Öýýæ èé aï ë ñóðàñí û óððóäàð öýñâèéí 30.0 x 30.0 i i öððööýí èé aï ðò i ãðåô èéí çöðääæäé (2009-04-23)

### Öððööýí aï “Graft-Stent” åðåüñàí åððä åððí èé:

Гол судасны цүлхэн түүний дотор цээжний гол судасны цүлхэнд графт стент тавих арга нь нээлттэй мэс заслын аргатай харьцуулахад эрсдэл хүндрэл багатай, эмчлүүлэгчид хөнгөн, хүний биед хагалгааны шарх сорви үүсгэхгүй, ор хоног цөөн зэрэг олон давуу талтай эмчилгээний арга юм. Судсан дотуурх аргаар гол судасны цүлхэнд стент тавих энэхүү эмчилгээг олон улсад баримталдаг аргачлалын дагуу хийсэн болно.




a




Çöðää 4-a.” Graft stent”-û í o ððööýí  
4-á.” Graft-Sten”-èéä ñóðàñí û åððí èé

Çöðää



Çöðää 5. Aï ë ñóðàñí û öððööýí aï “Graft stent” ñèñò åi èéä  
o åâèöö çàâåâàð-éäé

Судсан дотуурх мэс заслыг өвчтөнд унтуулга хэрэглэхгүйгээр хэсгийн мэдээ алдуулалтын дор баруун талын цавини хэсэгт жижиг зүслэг хийж, a.common femoralis болон a.femoralis superficialis and profundus-ыг тус бүрд нь ялган турникетенд оосорлон авч цусны урсгалыг түр хаагаад гуяны ерөнхий артерийн урд ханыг дагуу нээж ( өмсгөлтэй стент ) буюу (Graft stent) системыг оруулан хэвллийн гол судсаар дамжуулан цээжний гол судасны цүлхэнтэй хэсэгт аваачин, цүлхэний дээд ба доод хязгаараас дээш ба доош 15-20 мм зайнд байрлахаар тохируулан цүлхэний дотор тэлэгдэх метал дэгээгээ стентийн оёдоловс дээр байрлуулан дэлгэц дээр хянаад стентийг тэлж тавив (Зураг 6.a.b).




a

b.

Çöðää 6. a.”Graft stent”-èéä aï ë ñóðàñí û öððööýí èé  
ððí åèéä åâéððööñàí åâéäåäé aï.”Graft stent”-èéä  
öððööýí èé äýýä åâ aï i ä öýñâð öððööñàí åâéäåäé

Графт стентийн системийг ухраан стент бүрэн суусан эсэхийг хянахаар хяналтын ангиографийн зураг авахад цүлхэн бүрэн хаагдсан ямарч эмгэг хаялт байхгүй байв (Зураг7.а). Графт стентийн системийг сугалан авч ажилбарыг дуусган arterийн судсаа prolene № 6.0 утсаар үргэлжилсэн оёдлоор оёж, шархыг үечлэн хааж ариун боолт хийв.

Эмчлүүлэгч судсан дотуурх мэс заслын эмчилгээний дараа ямар нэгэн хүндрэлгүй төгс эдгэрч 7 хоногийн дараа эмнэлгээс гарсан.



а б

Соодлал 7. а. Ойг аёёд үйгээд өдөр 1 ахадад өөртэй соодлалын өдөртэй

а. Үйгээд 15 хоногийн дараа авахад байрлал хэвийн байв (Зураг 7. б).

Графт стентийн байрлалыг цээжний рентген зургаар хянах тогтоосон зургийг 15 хоногийн дараа авахад байрлал хэвийн байв (Зураг 7. б).

**Ø Үзүүлэлт:** Манай орны зүрх судасны мэс засал, ангиографийн шинжилгээний 40 жилийн түүхэнд анх удаа цээжний гол судасны уруудах хэсгийн 3.0 см цүлхэнг сүүлийн үеийн дэвшилтээ технологи болох дурс оношлогоо аргуудаар төгс оношлон, судсан дотуурх аргаар цээжний гол судасны цүлхэнд анх удаа графт стент тавих эмчилгээг амжилттай хийсэн нь ангиологийн салбарын дэвшлийг харуулсан үйл явдал болсон юм.

Цүлхэнгийн хэмжээ их том биш ойролцоогоор 30 мм, шохойжилтгүй, тромбо суугаагүй, цүлхений дээд хязгаар a.subclavia-g хамраагүй, доод хязгаар нь тодорхой байсан зэрэг нь графт стент тавихад тохиromжтой ийм ч учраас гол судасныцүлхений тухайн тохиолдолд хамгийн зөв сонголт байсан юм.

Цаашид ангиографи болон дурс оношлогоо өнөөгийн хүрсэн түвшинд тулгуурлан уг салбарт сүүлийн үеийн шинэ технологи нэвтрүүлэн, мэргэжилтэн давтан сургаснаар судсан дотуурх мэс ажилбарын нэр

терлийг олшруулах, түүний дотор гол судасны цүлхэнд графт стент тавих бүрэн бололцоотой гэж үзэж байна. Үүний тулд судсан дотуурх мэс ажилбарт хэрэглэгдэх өндөр өртөгтэй орчин үеийн багаж, хэрэгсэлээр хангах шаардлагатай байгаа юм.

#### Индикицийн:

- Н.Баасанжав., 3.Лхагвасүрэн., Ц.Бадамсэд., Б.Содгэрэл."Зүрхний төрөлхийн гажиг, судасны эмгэгийг судсан дотуур оношлон, эмчлэх" 2006, бүлэг -7, Судасны эмгэгийн ангиографийн оношлогоо эмчилгээ. х. 87-92
- Д.Цэгээнжав. Артерийн судасны өвчний онош, мэс заслын эмчилгээ. 1999. Цээжний гол судасны цүлхэн х.116-123, Хэвлэлийн гол судасны цүлхэн х.127-136
- Д.Цэгээнжав., Н.Баасанжав., Ц.Даваацэрэн, Ж.Эрдэнэсүрэн, Ц.Энхбат."Цээжний болон хэвлэлийн гол судасны зарим эмгэгийн онош мэс засал эмчилгээний асуудал". МАУ.2007.№2(140) х. 6-11
- Д.Цэгээнжав."Зүрхний титэм, том ба захын arterийн эмгэгийн нөхөн сэргээх мэс заслын эмчилгээг боловсронгуй болгох" ШУ-ы докторын диссертаци. 2008.
- Д.Цэгээнжав., Н.Баасанжав., Ц.Даваацэрэн., Ч.Золжаргал., Ж.Эрдэнэсүрэн, Н.Доржсүрэн. "Цээжний гол судасны өгсөх болон уруудах хэсгийн цүлхэнд мэс засал амжилттай хийсэн анхны тохиолдол". МАУ. 2008. №4. х. 55-61
- Белов.Ю.В., Хамитов Ф.Ф Диагностика аневризмы торакоабдоминального отдела аорты. Грудная и сердечно сосудистая хирургия 2011. Зстр 72-75.
- Kumar GVP; Mathew L. "Effects of Stent Design Parameters on the Aortic Endothelium". 13 th International Conference on Biomedical Engineering, Singapore, 3–6 December 2008. 23. pp. 15-42.
- Kumar GVP; Mathew L. "New Stent Design for Percutaneous Aortic Valve Replacement". International Journal of Cardiovascular Revascularization. Medicine 10 (2): 121-4
- Endovascular Repair of Complicated Type B Aortic Dissection Following Coronary Artery Bypass Grafting• LETTERS TO THE EDITOR In Press Corrected Proof ,Available online 22 January 2010
- Image Quality of Virtual Noncontrast Images Derived from Dual-energy CT Angiography after Endovascular Aneurysm Repair • CLINICAL STUDIES
- Journal of Vascular and Interventional Radiology  
DOI:10.1016/j.jvir.2009.10.040  
Abstract | Full Text | Full-Text PDF (3677 KB)
- Endovascular stent-graft repair of thoracic aortic aneurysms. Mitchell RS, Dake MD, Sembra CP, Fogarty TJ, Zarins CK, Liddel RP, Miller DC. Department of Radiology, Stanford University School of Medicine, CA 94305-5247, USA.
- Siavosh Khonsari MA, Colleen Flint Sintek, Abbas Ardehali at all. Cardiac surgery Safeguards and Pitfalls in Operative Technique. 2007.

Ойг ахадад өдөртэй соодлалын өдөртэй

І .Аи ձայсээлт<sup>1</sup>, А.Аодын ձаэр<sup>2</sup>, А.Өдий օөр<sup>1</sup>, А.Аи ձаёөлт<sup>1</sup>, А.Аадааёөлт<sup>1</sup>, І .А.б ой Ձөнгөө<sup>1</sup>  
<sup>1</sup>И өөрөө ձаёөлт<sup>1</sup> Ү.Дээдээл<sup>2</sup> Й.Дээдээл<sup>1</sup> Ө.Дүүгээн<sup>1</sup>  
<sup>2</sup>Ү.Дээдээл<sup>1</sup> Й.Дээдээл<sup>1</sup> Ө.Дүүгээн<sup>1</sup>

## THE HYGIENIC ASSESSMENT OF SECONDARY SCHOOL OF ORGANIZATION OF TEACHING AND EDUCATIONAL ACTIVITY, CHEMICAL AND BACTERIAL CONTAMINATION ON TEACHING ENVIRONMENT

N.Amardulam<sup>1</sup>, B.Burmaa<sup>2</sup>, J.Kupul<sup>1</sup>,  
G.Angalan<sup>1</sup>, O.Baigali<sup>1</sup>, M.Oyunchimeg<sup>1</sup>  
<sup>1</sup>PHI, <sup>2</sup>MOH

### Need for study and goal:

There is no data available on pupil's health with relation to the school environmental condition and organization of educational activities in Mongolia. Therefore, the goal of the study was to assess organization of the educational activities and conduct hygienic assessment of chemical and bacteriological contamination in the school environment.

### Materials and Methods:

A total of 1440 children were surveyed in this cross sectional study from the 6 secondary schools of UB city, Uvurhangai and Dornod aimags.

Hygiene conditions of school was assessed and organization of educational activities evaluated by class timetable and pupil's notes of daily regime.

### Result:

Timetable of lessons: It was observed that in some cases teachers' taught to primary pupils Mathematics and Mongolian language for 2 sequential hours, depending on some indexes such as lesson content, capacity and student's activity.

According to timetable of lessons of the secondary schools, pupils have lessons for 32-34 hours in a week. It was revealed that most schools have 2-3 hours more than standard timetable and heavy lessons were taught for 2-3 sequential hours. For the secondary classes, average length of classes was 32-34 hours in a week which indicates 2-3 hours longer timetable. There was no special place for physical training and movement games etc where pupil can do physical exercise, relax and enjoy school life.

Daily regime: pupils have been spending most of their time watching TV and listening music and spending few hours to help housework, to read a book and to prepare meal.

Urban pupils spent total of 0.5-1 hour for coming to school and going to home but rural pupils spent 20-30 minutes approximately.

### Result of the laboratory analysis

The bacteriological analysis of 36 classes in schools showed that before lesson, 94.4% of classes were clean while 5.6% was contaminated in first season of school year. After the lesson, percentage of classes without contamination had been dropped to 88.8% and classes with contamination had been increased to 11.2%.

In the 4<sup>th</sup> season of school year, before lesson 61.6% of classes was clean and 16.6% was contaminated and 22.3% was highly contaminated. Moreover, after the lesson, classes without contamination had been dropped to 27.7% while 72.3% was at high level contamination.

### Nonillusion:

1. Time table of lessons and break time management is inadequate in the schools and 32-39.1% of pupils do not follow the daily regime.
2. In the end of day, chemical and bacteriological contamination increased in the classes.

**Key words:** learning environment, chemical, biological threats, hygienic assessment, pupils, school

Pp.8-11, Tables 3, References 5

**—Í ÁÝÑÉÉ:**

Сургуулийн эрүүл орчин нь хүүхдийн эрүүл мэндийт хамгаалах сурах чадварыг дэмжих чухал ач холбогдолтой. Хүүхдүүд өдөр бүр 8 хүртэл цагаар жилийн 9 сарыг сургууль дээр, анги танхим, лаборатори, сургуулийн орчинд өнгөрүүлдэг. Сургуулийн гадна, дотно орчинд тэдний эрүүл мэндэд нөлөөлөх физик, хими, биологийн хүчин зүйлс бий [1].

Дасан зохицох нь хүүхдийн удамшил, нас, хүйс зэрэг биологийн хүчин зүйлсээс гадна хооллолтын байдал, хөдөлгөөний идэвхи, амьдралын чанар, өдрийн дэглэм, сургалтын орчин зэрэг орчны хүчин зүйлсээс хамаардаг [2]

Хүүхдийн эрүүл мэндэд эрсдэлтэй хүчин зүйлүүдийг өрөнхийд нь 2 үндсэн бүлэгт хуваан үздэг бөгөөд 1-р бүлэгт өрөнхий хүчин зүйлс тухайлбал, экологи, нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийг хамааруулдаг байна. Сургалтын талаарх судалгаанд эдгээр хүчин зүйлсэд чухал ач холбогдол өгөхгүй байгаа бөгөөд сургалтын байгууллагууд дээрх хүчин зүйлсэд ямар нэгэн хэлбэрээр нөлөөлөх боломжгүй байдаг.

2-р бүлэгт сургуулийн орчноос хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлт хүчин зүйлүүд багтдаг. Үүнд:

1. Сургалтын орчны эрүүл ахуйн шаардлага хангаагүйгээс эрсдэл үзүүлэх хүчин зүйлс
2. Сурган хүмүүжүүлэх ба сургалтын ажлын зохион байгуулалттай холбоотой эрсдэлт хүчин зүйлс
3. Хувийн шинж чанартай эрсдэл хүчин зүйлс багтдаг.

Орчны хүчин зүйлүүдэд сургуулийн дотоод орчны бичил цаг уур, 1 хүүхдэд ногдох талбай, ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ зэрэг үзүүлэлтүүд хамаарах бөгөөд хэдийгээр боловсролын байгууллагууд нь эрүүл ахуйн байнгын хяналт шалгалтад хамрагдаж байдаг хэдий ч зарим зөрчил байсаар байна.

Сурган хүмүүжүүлэх ба сургалтын ажлын зохион байгуулалттай холбоотой эрсдэлт хүчин зүйлсэд хичээлийн хуваарийг буруу зохион байгуулах, сургуулийн эмчийн үйл ажиллагаа хангалтгүй байх, сурагчдыг эрүүлжүүлэх, эрүүл мэндийн боловсрол, мэдлэг олгох, сургалтын үйл ажиллагааг үнэлэх, хяналт ажил хангалтгүй байх, сурагчдын эрүүл мэндийн бүртгэл, хөтлөлт хангалтгүй байх, сургалтын арга барил хүүхдийн наасны онцлогт тохирохгүй байх, сургалтын хөтөлбөрийн ачаалал нь интенсив ба экстенсив шинж чанартай бөгөөд хичээлийн явцад сургалтын явцыг эрчимжүүлэх талаар дүрэм, журам байхгүйгээс сургалтын ачааллыг ихэвчлэн экстенсив үзүүлэлтээр үнэлдэг зэрэг нь хамаардаг [3].

Манай орны боловсролын тогтолцоонд гарч байгаа өөрчлөлтүүд, тухайлбал сургалтын хөтөлбөрийг эрчимжүүлсэн, гүнзгийрүүлсэн, сургалтын дэглэмд өөрчлөлт оруулсан, хичээлийн болон хичээлийн бус цагийн ачааллыг нэмэгдүүлсэн сургуулиуд (гүнзгийрүүлсэн сургалттай төрийн бус сургууль) бий болж байгаатай холбогдуулан сурагчдын нас, бие маходын онцлог, эрүүл мэнд, суралцах (ажиллах) чадварт хэрхэн нөлөөлж байгааг судлах шаардлага гарч байгаа юм.

Иймээс сургалт хүмүүжлийн ажлын зохион байгуулалт, сургалтын орчны нөхцлийг судалж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулан, практикт нэвтрүүлэх шаардлага зүйлсээр тавигдаж байна.

**СИ ӨӨЕЭА:** Сургалт хүмүүжлийн ажлын зохион байгуулалт, сургалтын орчны бохирдолтыг судалж, эрүүл ахуйн үнэлгээ өгөх

**СИ ӨӨЕӨ:**

1. Хичээлийн хуваарь, сурагчдын өдрийн дэглэмийг судалж, эрүүл ахуйн үнэлгээ өгөх
2. Сургалтын орчны бохирдолтод эрүүл ахуйн үнэлгээ өгөх

**І АДААДӨӨ, АДАА ҪҮЭ:**

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 45, Баянгол дүүргийн 42, Чингэлтэй дүүргийн 39, Сонгинохайрхан дүүргийн 46, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 1, Дорнод аймгийн Чойбалсан хотын 8-р сургууль зэрэг 11 жилийн сургалттай нийт 6 сургуулийн 7-18 наасны нийт 1440 сурагчдыг бага (2 ба 4-р анги), дунд (6 ба 8-р анги), ахлах (9 ба 11-р анги) ангийг хамруулан санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгон авч нэгэн агшны судалгаанд хамрууллаа.

Сурагчдын өдрийн дэглэм хөтлөлтийн байдлаар сурагчдын хичнээн хувь нь өдрийн дэглэм хөтлөн мөрддөг, хичээлийн хуваарийн зохион байгуулалт, хичээлийн ачаалал, тухайлбал хичээлд зарцуулах, гэрийн даалгавар хийх, чөлөөт цаг, нойрсох хугацаа гэх мэт сургалт, хүмүүжлийн ажлын зохион байгуулалттай холбоотой зарим үзүүлэлтийг эрүүл ахуйн шаардлагатай [4, 5] харьцуулан үнэлгээ өглөө.

Түүнчлэн сурагчдын гар, үзэг, зарим эд зүйлээс 441 арчдасны, хичээлийн анги, танхимын агаараас хими, нянгийн шинжилгээнд 432 дээж тус тус авч бохирдолтыг тодорхойллоо (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. ЁАÁДААДӨӨ ӨӨИ ҪҮЭЭАЙҮИ ӨӨИ АДАА,**  
**ҪҮЭЭҮҮӨ, АҮҮЧҮҮЭИ ӨӨИ**

ЁАÁДААДӨӨ ӨӨИ ҪҮЭЭАЙҮИ	ӨӨИ ҪҮЭҮҮӨ	АҮҮЧҮҮЭИ ӨӨИ
Хими	Ангийн агаар	Исэлдэх чанар Тоосны хэмжээ
Нян судлал	Ангийн агаар	- Титрийн арга - Жингийн арга
	Арчдас: - Багшийн ширээ - Сурагчийн ширээ - Сурагчийн гар - Сурагчийн үзэг - Гар угаагур	- Цус задлагч коккийн тоо - Хөгц, мөөгнөнцийн тоо - Гэдэсний бүлгийн савханцар

Лабораторийн шинжилгээг хичээлийн жилийн 1, 4-р улиралд 7 хоногт 1 удаа хичээлийн эхний ба сүүлийн цагуудад хийлээ.

### Ñóäàëääàí û äçí , õýööýí æ:

**Öè ÿëëéí ööäääöö:** Бага ангийн хичээлийн хуваариас үзэхэд 7 хоногийн хичээлийн ачаалал дунджаар 21-22 цаг байгаа нь хэвийн хэмжээнд байна.

Бага ангийн сурагчдын хувьд хүнд ба хөнгөн хичээл нь 7 хоногийн хичээлийн бүх өдөр ээлжлэн орохоор төлөвлөсөн байсан ба хичээлийн хуваарьт хүнд хичээлүүдийг аль ч өдөр дараалан оруулсан тохиолдол байхгүй байлаа.

Харин хичээлийн агуулга, багтаамж, сурагчдын идэвх зэрэг үзүүлэлтээс хамаарч багш нар зарим тохиолдолд тоо, монгол хэлний хичээлийг 2 цаг дараалан оруулах нь ажиглагдаж байлаа.

Дунд ангийн хичээлийн хуваариас үзэхэд 7 хоногт дунджаар 32-35 цагийн хичээлтэй байсан нь ихэнх сургуульд хэвийн хэмжээнээс 2-3 цагаар илүү байна.

Хот, хөдөөгийн аль ч сургуульд хичээлийн хуваарьт байгалийн ухааны хичээлүүд буюу хүнд хичээлүүдийг 7 хоногийн эхний өдөр оруулахгүй байх зарчим мөрдөгдөхгүй байна. Хичээлийн хуваариас харахад ихэнх сургуульд хүнд хичээлүүд нь 2-3 цагаар дараалан орж байна.

Ахлах ангийн хичээлийн хуваариас үзэхэд 7 хоногт дунджаар 32-34 цагийн хичээлтэй байсан нь ихэнх сургуульд хэвийн хэмжээнээс 2-3 цагаар илүү байна. Хот, хөдөөгийн аль ч сургуулиар авч үзэхэд хичээлийн хуваарьт байгалийн ухааны хичээл буюу хүнд хичээлийг 7 хоногийн эхний өдөр оруулахгүй байх зарчим мөрдөгдөхгүй байна.

Судалгаанд хамрагдсан аль ч сургуулийн дунд, ахлах ангиудын хувьд завсарлагааны үргэлжлэх хугацаа 5 минут, зөвхөн их завсарлага нь 10 минут үргэлжилж байлаа. Завсарлагааг тодорхой чиглэлээр зохион байгуулах, тухайлбал биеийн тамирын дасгал хийх, хөдөлгөөнт тоглоомоор тоглох зэрэг ажлуудыг ямар ч сургуульд хийхгүй байлаа.

Бага ангийн сурагчдын хувьд “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбогдуулан их завсарлага нь 15-30 минут үргэлжилж байлаа. Түүнчлэн бага ангийн сурагчдын алжаалыг тайлах, сэргээх, идэвхжүүлэх зорилгоор зарим сургуулийн багш нар хичээлийн дундуур 2-3 минутын хугацаагаар гарын дасгал хийлгэж байлаа.

Ахлах ангиуд нь кабинетийн системээр хичээллэдэг тул сурагчид нэг ангиас нөгөө ангид шилжихэд завсарлагааны хугацаа нь зарцуулагдаж байсан ба гадаа агаарт гарах, биеийн тамирын дасгал хийх, хөдөлгөөнт тоглоомоор тоглох боломжгүй байлаа.

### ² äðèéí äýæùí :

Судалгаанд хамрагдсан 2-р ангийн нийт сурагчдын 42,7%, 4-р ангийн сурагчдын 79,1%, 6-р ангийн сурагчдын 57,8%, 8-р ангийн сурагчдын 78,2%, 9-р ангийн сурагчдын 64,4%, 11-р ангийн сурагчдын 63,8% тус тус өдрийн дэглэмийг мөрддөг байна.

Сурагчдын өдрийн дэглэм хөтлөлтийн талаарх судалгааны дунг доорх хүснэгтээр харуулав.

### Хүснэгт 2. ² äðèéí äýæùí èéé çàðèì զëëëë զëëëéí չðäýëæýö ööääöäà

Д/д	Үйлдлийн төрөл	Анги	2-р анги	4-р анги	6-р анги	8-р анги	9-р анги	11-р анги
1	Хичээл, сургалтын үргэлжлэх хугацаа	3-4	4-5	5-6	5-6	5-6	5-6	5-6
2	Гэрийн даалгавар хийхэд зарцуулж буй хугацаа	2-3	1.5-2	1-2	1.5-2	1-1.5	2-2.10	
3	Гадаа агаарт тоглоход зарцуулж байгаа хугацаа	2.5-3	1-1.5	1 ц	1-1.5	1-2	1-1.30	
4	Өглөөний дасгал хийдэг сурагчдын эзлэх хувь	5%	22.9%	15.3%	17.7%	10%	11.7%	
	Өглөөний дасгал зарцуулах хугацаа	5-10 минут	10-25 минут	15-20 минут	10-30 минут	10-15 минут	10-15 минут	
6	Нойрсолтод зарцуулах хугацаа	9-10	8-9	9-10	8-10	7-8	7-8 цаг	

Сурагчид телевиз үзэх, хөгжим сонсох зэрэгт харьцангуй их цаг зарцуулж байсан бол гэрийн ажилд туслах, ном унших, хоол ундаа идэх, бэлтгэх зэрэгт харьцангуй бага хугацаа зарцуулж байна.

### Ëàáî ðàöï ðééí ø èí æèëäýú èéé äçí :

Судалгаанд хамрагдсан сургуулиудын нийт 36 ангид хичээлийн жилийн 1 дүгээр улиралд хичээл эхлэхийн өмнө хийсэн агаарын нянгийн бохирдолтын шинжилгээгээр 34 буюу 94.4% нь цэвэр, 5,6% нь их бохирдолтой байлаа. Харин хичээлийн сүүлд бохирдолгүй буюу цэвэр ангийн тоо 88.8% болж буурсан бол бохирдолтой гарсан ангийн тоо 11,2% болж нэмэгдсэн байлаа.

Хичээлийн жилийн 4 дүгээр улиралд хичээлийн эхэнд 61,1% нь бохирдолгүй буюу цэвэр, 16,6% нь бохирдолтой, 22,3% анги нь тус тус их бохирдолтой байсан бол хичээлийн сүүлд бохирдолгүй буюу цэвэр ангийн тоо 27,7% болтлоо буурч, бохирдолтой ба их бохирдолтой ангийн тоо нийт 72,3% болж нэмэгдсэн байлаа.

Шинжилгээний дүнгээр хичээлийн эхэнд болон сүүлд судалгаанд хамрагдсан бүх ангиудын дотоод орчны агаарт цус задлагч коккууд илрээгүй (<50).

Хөгц, мөөгөнцрийн шинжилгээгээр 1 дүгээр улирлын хичээлийн эхний цагт нийт ангийн агаарт бохирдолт илрээгүй бол хичээлийн сүүлийн цагт 4 анги буюу 11,2% харин 4 дүгээр улиралд хичээлийн эхэнд нийт ангийн 11,1% хөгц, мөөгөнцрийн бохирдолтой байснаа, хичээлийн сүүлд бохирдолтой ангийн тоо 16,6% болж нэмэгдсэн байлаа.

Сурагчдын гар, үзэг болон зарим эд зүйлээс авсан арчдасны нянгийн шинжилгээний дүнгээр гэдэсний бүлгийн савханцар илрээгүй.

Судалгаанд хамрагдсан сургуулийн хичээлийн анги, танхимиын агаарын химийн шинжилгээний дүнг дараах хүснэгтэд харууллаа (Хүснэгт 3).

**Хүснэгт 3. Àí æ, ðàí ðèí û í àäààðû í èñýëäýö ÷àí àð, ðí î ñæèéðû í áàéäàë**  
(улирлаар, хичээл эхлэхийн өмнө ба хичээлийн дараа)

№	Сургууль	Намар				Хавар			
		Хичээлийн өмнө		Хичээлийн дараа		Хичээлийн өмнө		Хичээлийн дараа	
		исэлдэх чанар (мг/м³)	тоосжилт (мг/м³)	исэлдэх чанар (мг/м³)	тоосжилт (мг/м³)	исэлдэх чанар (мг/м³)	тоосжилт (мг/м³)	исэлдэх чанар (мг/м³)	тоосжилт (мг/м³)
1.	УБ хотын 39-р сургууль	15.45-23.6	1.74-3.45	18.45-23.7	1.84-3.32	16.1-22.6	1.5-3.1	17.5-23.5	1.8-2.7
2.	УБ хотын 42-р сургууль	13.4-18.1	1.2-2.1	15.7-23.5	1.85-2.2	12.1-17.2	1-2	15.1-19.2	1.5-2.0
3.	УБ хотын 45-р сургууль	19.45-20.41	0.87-1.24	18.5-21.4	1.02-1.3	18.9-20.6	0.9-1.3	19.4-21.5	1.1-1.5
4.	УБ хотын 46-р сургууль	11.17-21.2	0.86-1.3	12.2-20.65	1-1.4	11.2-20.6	0.81-1.1	11.9-21.0	1-1.4
5.	Өвөрхангай аймгийн 1-р сургууль	8.5-11.75	2.39-6.19	16.5-18.78	2.1-7.2	8.75-12.75	1.06-2.09	12.7-19.2	3.6-8.1
6.	Дорnod аймгийн 8-р сургууль	7.67-14.24	3-8	14.24-18.6	3.5-10.2	5.3-9.1	1.7-2.9	9.2-18.1	2.5-4.2

Дээрхи шинжилгээний дүнгээр судалгаанд хамрагдсан анги танхимын агаарын исэлдэх чанар, тоосны хэмжээ нь эрүүл ахуйн нормоос их байна.

#### Àjää ýëò:

- Судалгаанд хамрагдсан бага ангийн сурагчдын 60.9%, дунд ангийн сурагчдын 68%, ахлах ангийн сурагчдын 64.1% нь тус тус өдрийн дэглэм мөрдөж байна.
- Хичээлийн хуваарь, завсралагааны зохион байгуулалт эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна.
- Анги, танхимын агаарын бохирдолт хичээлийн сүүлийн цагуудад нэмэгдэж байна.

#### Çøâë® i æ:

- Одоо мөрдөж байгаа “Хүүхэд, өсвөр үеийнхний сургалт хүмүүжлийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрэм” (1995)-ийг холбогдох байгууллагууттай хамтран шинэчлэн боловсруулах
- Ерөнхий боловсролын сургуулийн эмчийн ажлын байрны тодорхойлолтыг батлуулан, хэрэгжүүлэх
- Сургалтын хөтөлбөрийг хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэл зүй, нийгэмшихүйн хөгжил, тэдний хэрэгцээ, боловсролын стандартад, тулгуурлан боловсруулах

- Эрүүл ахуйн шаардлага хангасан сургалтын орчныг бүрдүүлэх (сургуулийн гадаад, дотоод орчны эрүүл ахуйн шаардлагууд)
- Хичээлийн хуваарь болон цагийн хуваарилалтыг сурагчдын насны онцлогт тохицуулж, хичээлийн болон завсралагааны үргэлжлэх хугацааг эрүүл ахуйн шаардлагын дагуу зөв зохион байгуулах

#### Í ì ççé:

- J.Pronczuk. Where the child learns. Children's health and the environment. A Global perspective. WHO, Geneva, 2005, pp.41-45
- Sukharev AG. The forming of child and adolescent adaptability. Vest.Ros.Akad. Med.Nauk. 2006; (8): 15-8, PMID: 17002020 [Pub Med-Inxed for MEDLINE].
- Проблемы здоровьесберегающего обучения школьные факторы риска, материалы семинара ПИЭР №3 от 28.11.2003 г.
- БНБД П-66-88 Сургалт хүмүүжлийн байгууллагын барилгын эрүүл ахуйн норм
- “Хүүхэд, өсвөр үеийнхний сургалт хүмүүжлийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрэм” 1995 он

Òàí èëööàæ í èéò öýö ñàí àé °âñø í :  
Àí àäààðó óöààí û äî êò í ð Ø .Ýí ööýöýá

## Ì Ì Í Ä Ë Ü Í ÑÓÐÀÃ× ÄÜ Í ÑÓÐÀËÖÀÕ (ÀÆÈËËÀÕ) ×ÀÄÀÀÐÛ Ä ÑÓÄÀËÑÀÍ Ä-Í ÄÝÝÑ

ÄÀì ààëàí 1, Á.Áóði àà2, Ä.Êóï öè1, Í.Àì àðäóóëàí 1,  
Î .Áaéäëü1, Ì .Î þ óí -èì ýál  
IÍ Ýl Ô, 2Ýl ß

### RESULTS OF STUDY OF MONGOLIAN PUPIL'S LEARNING ABILITIES

G.Amgalan1, B.Burmaa2, J.Kupull, N.Amardulam1,  
O.Baigal1, M.Oyunchimeg1  
IPHI, 2MOH

#### **Introduction:**

There have been limited research studies done in Mongolia on health status of children in relation to density of children in school classrooms.

#### **Goal:**

This study aims to evaluate learning ability of children in Mongolia and develop recommendations for next intervention measures.

**Materials and Methods:** A total of 1440 children were surveyed in a cross sectional study that included 6 classes from 6 secondary schools of UB city, Uvurhangai and Dornod aimags. The test of letter drawing created by V.Ya.Anfimova was used to evaluate the pupil's learning skills. This test was performed at the first and last classes in each day of which was tested at the beginning (I quarter or September) and end (IV quarter or May) of the academic year.

For each tests we accounted the mean of drawing letter, mean of mistake for 500 letter and standard deviation.

**Results:** The results of pupil's letter drawing tests were compared by quarter for first and last classes in each day.

Pupil's learning ability of class 4 was enough while other classes were not enough (P index <1) on the first and last tests.

#### **Nonillusion:**

Pupil's learning ability has been changed by the same way of physiological adaptation process of child.

Pupil's learning ability had been decreased in last tests of each day and on Friday which was revealed by letter drawing test.

Pupil's learning ability of classes between 4 to 9 were not enough on the first term while 4th class was good enough on the forth term (P index<1).

#### **Key words:**

Learning ability, letter drawing test, mean of drawing letter, pupils

Pp. 12-16, Tables 2, References 7

**-í áýñéé:** Сүүлийн жилүүдэд хүүхдийн оюуны ажиллах (суралцах) чадварыг олон салбарт гүнзгийрүүлэн судалж байна [4]. Эрүүл ахуйн судалгаануудад хүүхдийн ажиллах чадварыг үнэлэхийн тулд анхаарал ба ой тогтоолтыг үнэлж байгаа бөгөөд тодорхой хугацаанд гүйцэтгэж байгаа ажлыг өөрчлөх ба нэмэгдүүлэхэд сурагчдын ой тогтоолт, анхаарал хэрхэн өөрчлөгдж байгааг үсэг зурах сорилын янз бүрийн хэлбэрүүдийг ашиглан судлаж байна [3, 4].

ОХУ-д 1990-ээд оны үеэс эдийн засаг, экологийн тааламжгүй байдал бий болж, мөн төрийн бус буюу гүнзгийрүүлсэн сургалттай сургуулиуд олноор байгуулагдах болсон нь сургуулийн болон өсвөр насын хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын өсөлт хөгжилт, тэдний суралцах чадварт сөрөг нөлөө үзүүлэх гол хүчин зүйл болж, судлаачдын анхаарлыг татаж

эхэлжээ.

Оросын судлаач А.Г.Хрипков (1990) хүүхдийн эрүүл мэндийн байдлыг судлаад, сурагчдын эрүүл мэндийн түвшин нь сургалтын ачааллаас хамаардаг, сурагчид нь удаан хугацаагаар хөдөлгөөнийг хязгаарласан, хөдөлгөөн дутагдалтай байснаас ядаргаанд ордог болохыг тогтоосон байна [5]. Ядаргааны үед сэтгэн бодох үйлдлийн чанар, хурд буурч, ядралын далд үе ихэссэнээс улмаар сурагчид тайван бус болж хөдөлгөөнд орох, биенийн байршлаа өөрчлөх, хоорондоо ярих, шуугих зэрэг, өөрөөр хэлбэл сурагчдын хичээлийн идэвх буурах шинжүүд илрэдэг байна [1].

Н.Н.Корсакова нарын 2001 онд Москва хотын сурагчдын дунд хийсэн судалгаагаар сурагчдын тогтоо чадвар харьцангуй муу, ой тогтоолт, сэтгэл хөдлөлийн байдал нь хоорондоо хамааралтай болохыг тогтоогоод

үүний үндсэн дээр сурагчдын ажиллах чадварыг тодорхойлсон байна.

М.В.Антропова (1998) нарын Москва хотын сурагчдын дунд хийсэн судалгаагаар нийт сурагчдын 47%-д нь ажиллах чадвар 7 хоногийн сүүлийн өдрүүдэд буурч байгааг [7], мөн Т.О.Чернякина (1990) нарын Санктпетербург хотын сурагчдын дунд хийсэн судалгаагаар (6) сурагчдын ажиллах чадвар нь 7 хоногийн Мягмар, Лхагва гарагуудад хамгийн өндөр байсан бол Баасан гарагт буурч байгааг тогтоожээ.

Манай улсад ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээлийн ачаалал, дэглэмийн хамаарлын талаарх судалгааг 2003 онд судлаач З.Баяараа “Монгени” цогцолбор сургуулийн 1-5-р ангийн сурагчдыг хамруулан хийсэн байна. Судалгаагаар сурагчдын ажиллах чадварын түвшин нийт сурагчдын 51,8%д нь сайн, сурагчдын 53,5%-д ядаргааны эхний шинж тэмдэг илэрч, 12,2 % нь ядаргаанд бүрэн орсон, сурагчид хичээлийн ачаалал бүрэн аваагүй, идэвхгүй нөхцөлд хуурамч ядаргаанд орж байгаа нь тогтоогдсон байна [1].

Сургуулийн сурагчдын эрүүл мэнд, орчны талаар судалгаа шинжилгээний ажил хийгдэж байгаа хэдий ч суралцах чадварыг судлан үнэлгээ өгсөн ажил дутмаг байна. Иймээс манай орны ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын оюуны суралцах (ажиллах) чадварыг судлан тогтоосны үндсэн дээр бага, дунд боловсрол олгох үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн сургуулиудын хичээл, хүмүүжлийн ажлын зохион байгуулалтад үнэлгээ өгч, цаашид авах арга хэмжээний үндэслэлийг боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

#### Ноён ажиллахын үзүүлэлт:

Сурагчдын оюуны ажиллах чадварыг судалж, эрүүл ахуйн үнэлгээ өгөхөд судалгааны ажлын зорилго оршино.

#### Ноён ажиллахын үзүүлэлт:

1. Сурагчдын оюуны ажиллах чадварыг судалж үнэлгээ өгөх
2. Сурагчдын оюуны ажиллах чадвар нь хичээлийн өдрүүд ба хичээлийн цагуудад ялгаатай эсэхийг судлаж, зөвлөмж боловсруулах

#### Их ажиллахын үзүүлэлт:

Ts.Jaal1, B.Munguntsetseg1, J.Batkhuu1\*

1Laboratory of Pharmacognosy, Department of Biochemistry and Bioorganic chemistry, Faculty of Biology, National University of Mongolia

\*Contact address: batkhuu@biology.num.edu.mn

Acetylcholinesterase (AChE) inhibitors have been used in the treatment of Alzheimer's disease (AD). Currently, the only effective treatment for AD disease targets the cholinergic system using anti-cholinesterase compounds. AD is progressive, degenerative disease characterized by memory loss, language deterioration, poor judgment, impaired visuospatial skills etc.

There are a few synthetic medicines, e.g. tacrine, donepezil and the natural product-based rivastigmine and galantamine to treat cognitive dysfunction and memory loss associated with AD. These approved drugs are limited in use due to their adverse side effects such as gastrointestinal disturbance and bioavailability problems. There still is great interest in finding better AchE inhibitors.

We have screened in this study the anti-acetylcholinesterase effects of 87 samples, which prepared from different parts of 43 plant species. Methanolic extracts of nine plants, namely *Patrinia rupestris*, *Numpaea candida*, *Lespedeza hedysaroides*, *Pachypfeurum alpinum*, *Leontopodium Leontopodioides*, *Nonea pulla*, *Leontopodium compestre*, *Gypsophilea patrinii* and *Abies sibirica* showed potent effect, their inhibition ratios were 39.65%, 42.22%, 38.06%, 40.55%, 38.82%, 35.1%, 35.85%, 35.3 % and 53.01%, respectively.

Our research shows that some Mongolian medicinal plants have anti-acetylcholinesterase activity, furthermore investigations needed to isolate pure bio-active compounds from these active plants and determine their chemical structures.

**Keywords:** Acetylcholinesterase inhibitor, Alzheimer's disease, medicinal plants

Рп. 26-28, Table 1, References 10

### Í ðø èë

Организмд холинэргийн системийн гажуудлын үед Alzheimer-ийн өвчин үүсдэг (1) ба нас ахисан хүн амын дунд ихэвчлэн тохиолддог. Энэ өвчин ой санамжaa алдах анхны шинж тэмдгээр илрэч (2) улмаар хэл яриа, сэтгэх чадвар муудах, орон зайд баримжаалах чадвараа алдах зэРРргээр оюун ухааны хомсдолд хүргэдэг (3). Ацетилхолинэстераза ферментийн идэвхийг дарангуйлах үйлчлэлтэй эмийн бэлдмэлийг Alzheimer-ийн өвчиний эмчилгээнд хэрэглэж байна. Такрин (tacrine), Донепезил (donepezil) зэрэг цөөн тооны синтетик эм, байгалийн гаралтай Ривастигмин (rivastigmine), Галантамин (galanthamine) зэрэг эмийг Alzheimer-ийн өвчинтэй холбоотойгоор ой санамжaa алдах зэрэг мэдрэлийн эсийн хэвийн үйл ажиллагаанаа алдагдлыг эмчлэхэд хэрэглэж байна. Гэвч эдгээр эмүүд гаж нөлөө ихтэй тул хэрэглээ нь хязгаарлагдмал байдаг (4). Физостигмин (physostigmine), такрин зэрэг ацетилхолинэстераза ферментийн ингибиторууд элэг хордуулах гаж нөлөөтэй болох нь тогтоогдсон (5). Харин галантамин илүү сонгомол үйлчилгээтэй бөгөөд одоогийн байдлаар Австри улсад эмчилгээнд хэрэглэхийг зөвшөөрсөн эм юм (6).

Зүүн өмнөд азийн орнуудад олон мянган жилийн өмнөөс ой санамж сайжруулах зорилгоор эмийн ургамлыг хэрэглэсээр иржээ. Зарим фармакологийн

судалгаагаар ургамлаас ацетилхолинэстераза ферментийн идэвхийг дарангуйлах үйлчилгээтэй шинэ бодисыг нээж илрүүлэх судалгааны ажил хийгдсээр байна. Жишээлбэл: Солонгосын хүн орходой (*Panax gensing*) нь ой ухаан сайжруулах үйлчлэлтэй, *Hyperzia serrata*-аас ялгасан гиперзин A (hyperzinA) (7), *Riniera saria*-аас ялгасан зарим алкилпиридиний полимерууд (alkylpiridinium polymers), *Eudia rutaecarpa*-аас ялгасан дегидроеводиамин (dehydroevodiamin) болон *Corydalis ternate*-аас гаргасан протопин (protopin) (8) зэрэг ацетилхолинэстераза ферментийн ингибиторуудыг судалгаагаар илрүүлсэн боловч эдгээр нь биозохицол бага, гаж нөлөө ихтэй (9) тул хэрэглээнд өргөн нэвтрэхгүй байна. Иймд эдгээрээс илүү сайн үйлчлэлтэй ацетилхолинэстераза ферментийн ингибиторыг байгалийн гаралтай түүхий эд, ялангуяа ургамлаас илрүүлэх чиглэлийн судалгаа нэлээд сонирхол татах боллоо. Бид энэ скрининг судалгаагаар манай оронд ургадаг зарим эмийн ургамлын ацетилхолинэстераза ферментийн идэвхийг дарангуйлах үйлчилгээг судаллаа.

### Ì àðåðèëæ, àðæà çéé

Бодис урвалж:

Тризма буфер, ацетилхолинэстераза фермент - AChE, ацетилхолин иодид-Ach, DTNB (5.5'- Dithiobis-

(2-nitrobenzoic acid)) зэргийг Sigma-Aldrich Chemie GmbH, анализын цэвэр метанол болон бусад урвалжийг дотоодын ханганд нийлүүлэгч компаниудаас тус тус худалдан авсан болно.

Багаж, шилт сав: Гэрлийн шингээлтийг UV-VIS Spectrometer-160 (Shimadzu, Japan) багажаар хэмжив.

Эмийн ургамлыг түүж, бэлтгэх: Судалгаанд авсан ургамлуудыг хангай, хээр, говийн бүслүүрээс 2008 онд түүж сүүдэр газар агаарт хатааж бэлтгэсэн. Ургамлыг ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Ч.Санчир тодорхойлсон.

#### Ургамлын ханд бэлтгэх:

Ургамлыг эрхтэн бүрээр нь ялгаж жижиглэн метанолоор 1:10 (гр/мл) гурван удаа, хандлах бүрдээ 4 хоног тавьж хандлан нийлбэр хандыг вакум нэрэгчээр 42-45°C-д нэрж хуурай ётгэн ханд гарган авсан.

#### Ацетилхолинэстераза ферментийн эсрэг идэвхийг тодорхойлох.

Эллманы боловсруулсан колориметрийн аргаар тодорхойлсон (10). 0.0020гр ургамлын дээжийг 2мл DMSO-д уусгаж 1000мкг/мл концентрацитай дээж уусмал бэлтгэнэ. 1.9мл буфер уусмал руу дээж уусмалаас 20 мкл, AchE 40мкл-ийг авч нэмнэ. 30 минутын турш хөргөгчинд (40°C) урьдчилсан өсгөвөрлөлт хийнсний дараа DTNB 20мкл, ACh 20мкл –ийг нэмсэнээр фермент субстратыг задлах урвал эхэнлэ. Субстратын задралаар үүссэн бүтээгдэхүүн нь DTNB-тэй өнгөт нэгдэл үүсгэнэ. Шинжилж байгаа дээж Ацетилхолинэстеразийг дарангуйлах идэвхитэй бол субстратын задрал бага байх ба тэр хэмжээгээр өнгөт нэгдэл бага үүснэ. Дээжийн гэрлийн шингээлтийг 412нм-ийн долгионы уртад 0, 5, 10 дахь минутад хэмжинэ. Ацетилхолинэстераза ферментийг дарангуйлах идэвхийг дараах томъёогоор тооцож гаргана.

#### Үр дүнг тооцоолох:

$$\text{Дарангуйлах \%} = 100 \times (A_{10\text{хяналт}} - \Delta A_{\text{дээж}}) / A_{10\text{хяналт}}$$

А-шингээлт

$$\Delta A = A_{10\text{хяналт}} - A_{00 \text{ мин}}$$

#### Ноёнхон олон ургамлын хандыг харахад олон нийттэй тодорхойлжүүлэхэд

Бид энэхүү судалгаагаар 15 овгийн 43 зүйл ургамлын 87 дээжинд Ацетилхолинэстераза ферментийг дарангуйлах идэвхийг шалгасан. Үр дүнг Хүснэгт 1-д үзүүлэв.

#### Хүснэгт 1. Алоётээшийн эхийн үндэлдэгчадаа олон нийттэй тодорхойлжүүлэхэд

Овог	Зүйл	Эрхтэн	Дарангуйлах идэвхи(%)
Boraginaceae	<i>Cynoglossum divaricatum</i> Steph.	иш	16.66
		үр	27.7
	<i>Lappula consanguinea</i> (Fisch. et Mex.) Gurke.	иш	-
		навч	24.16
Chenopodiaceae	<i>Nonea pulla</i> L. DC.	иш	35.01
	<i>Axyris prostrata</i> L.	иш	-
		цэцэг, навч	-
		үндэс	-

Compositae	<i>Cirsium esculentum</i> L.	навч	-
	<i>Cirsium incanum</i>	цэцэг	-
		иш	-
	<i>Erigeron acer</i> L.	навч	23.0
		үр	-
		үндэс	-
	<i>Galatella dahurica</i> (DC.)	навч, цэцэг	25.26
		иш	-
	<i>Leontopodium campestre</i> (Ldb.) Beauvd.	навч	15.5
		цэцэг	35.85
		иш	11.9
		үндэс	35.09
Cruciferae	<i>Leontopodium leontopodioides</i> (Willd.) Beauvd.	цэцэг, үр	38.82
		иш	-
	<i>Senecio ambraceus</i> (Takcz.)	иш	-
		үндэс	-
Gramineae	<i>Senecio nemorensis</i> L.	иш	-
	<i>Solidago dahurica</i> Kitag.	иш	21.0
		цэцэг	22.2
	<i>Sonchus arvensis</i> L.	навч	-
Labiateae		цэцэг	28.7
		иш	-
		үндэс	29.2
	<i>Thanacetum vulgare</i> L.	навч	-
Cruciferae		цэцэг	27.3
		иш	-
		навч	-
	<i>Arabis pendula</i> L.	иш	-
Gramineae		навч	-
	<i>Ptilotrichum ternuifolium</i> (Steph.) C.A.Meg.	үндэс	-
		навч, цэцэг	-
	<i>Sisymbrium loeselii</i> L.	цэцэг	22.5
Labiateae		иш	-
		навч	25.3
	<i>Achnaterum splendens</i> (Trin.) Nevski.	навч	-
		иш	-
Gramineae	<i>Gypsophylla patrinii</i> Ser.	үндэс	35.3
		иш	-
	<i>Elymus chinensis</i> (Trin.) Keng.	навч	-
		цэцэг	-
Labiateae	<i>Stachys palustris</i> L.	иш, үндэс	-
		навч	-
	<i>Dracocephalum ruyschiana</i> L.	цэцэг, навч	28.24
		иш	-
Gramineae	<i>Lagopsis supina</i> (Steph.) ik-Gal.	үндэс	-
		иш	-
		навч,	-
		цэцэг	-
Labiateae	<i>Leonurus deminutus</i> Krecz.	иш	-
		навч, цэцэг	-
Gramineae	<i>Mentha arvensis</i> L.	навч, цэцэг	-
		иш	-
	<i>Amethystea coerulea</i> L.	навч	-
		цэцэг	-
Labiateae	<i>Galeopsis bifida</i> L.	иш	-
		навч, цэцэг	-

Leguminosae	<i>Lespedeza hedsaroides</i> (Pall) Kitag.	навч	-
		иш	-
		үндэс	38.06
Nymphaeaceae	<i>Nymphaea candida</i>	газрын дээд хэсэг	42.22
Papaveraceae	<i>Corydalis sibirica</i> (L.F.) Pers.	газрын дээд хэсэг	22.6
Pinaceae	<i>Abies sibirica</i>	газрын дээд хэсэг	53.01
Ranunculaceae	<i>Leptopyrum fumaroides</i> L.	навч	31.1
Rosaceae	<i>Agrimonia pilosa</i> (Ldb.)	үндэс	19
		цэцэг, навч	23.94
		иш	14.49
	<i>Cotoneaster melanocarpa</i> Lodd.	иш	-
	<i>Filipendula ulmaria</i> (L.) Maxim.	иш	-
		навч, цэцэг	-
	<i>Potentilla astragalifolia</i> Bge.	газрын дээд хэсэг	28.57
Rubiaceae	<i>Rubia cordifolia</i> L.	навч	17.1
Umbelliferae	<i>Angelica decurrens</i> (Ldb) B. Fedtsch.	навч	18.75
		үр	21.9
		иш	-
	<i>Carum buriaticum</i> Turc.	иш	-
	<i>Heracleum dissectum</i> (Ldb.)	цэцэг, навч	16.66
		иш	28.31
Valerianaceae	<i>Patrinia rupestris</i> (Pall.)	үндэс	40.55
		иш, навч	-
		навч	39.65
			32.41

- ИДЭВХИГҮЙ

Хүснэгтээс харахад *Patrinia rupestris* -ийн навч 32.41%, иш үндэс 39.65%, *Nymphaea Candida*-ийн газрын дээд хэсэг 42.22%, *Lespedeza hedsaroides* -ийн үндэс 38.06%, *Pachypfeurum alpinum*-ийн үндэс 40.55%, *Leontopodium Leontopodioides*-ийн цэцэг үр 38.82 %, *Nonea pulla*-ийн иш 35.1%, *Leontopodium compestre*-ийн цэцэг 35.85%, үндэс 35.05%, *Gypsophilea patrinii*-ийн үндэс 35.3%, *Abies sibirica*-ийн газрын дээд хэсэг 53.01%-ийн идэвхтэй байгаа нь сонирхол татаж байна. Мөн *Tanacetum vulgare* – ийн цэцэг 27.3%, *Galatella dagurica*-ийн цэцэг-навч 25.26%, *Sonchus arvensis*-ийн цэцэг 28.7%, *Dracocephalum ruischiana*-ийн цэцэг-навч 28.24%, *Heracleum dissectum*-ийн иш 28.31%, *Gynoglossum divaricatum*-ийн үр 27.7%, *Leptopyrum fumaroides*-ийн навч 31.1%-иар тус тус ацетилхолинэстераза ферментийн идэвхийг

дарангуйлж байлаа. 11 дээжинд идэвхи сул илэрсэн ба бусад дээжинд огт илрээгүй.

Монгол орны зарим эмийн ургамлын Ацетилхолинэстераза ферментийн идэвхийг дарангуйлах үйлчилгээг судалсан дүнгээр 35%-иас дээш идэвхитэй 9 ургамал байгааг тогтоосон бөгөөд цаашид эдгээр ургамлуудаас идэвхтэй нэгдлийг цэврээр ялган авч химиин бүтцийг тогтоох, улмаар хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэх судалгааг үргэлжлүүлэн хийж байна.

#### Òàéäðòäåë:

Уг судалгааг явуулахад үнэтэй зөвлөгөө өгч зарим урвалж бодисоор тусалсан Австрали Улсын Грацын Их Сургуулийн профессор А.Н.Brantner-т талархал илэрхийлж байна. Судалгааны ажлын зарим хэсгийг Японы Хонда Сан (Honda foundation)-аас санхүүжүүлсэн болно.

#### Í î í ççé

1. Oh.M.H., Houghton.P.J., Wang.W.K., Cho.J.H. Screening of Korean herbal medicine used to improve cognitive function for anticholinesterase activity. *Phytomedicine*.11 (2004) 544-548
2. Gummings.B.J., Pike.C.J., Shankle.R., Cotman.C.W.  $\beta$ -Amyloid deposition and other measures of neurophathology predict cognitive status in AD. *Neurobiol.Aging*. 17 (1996) 921-933.
3. Vinutha.B., Prashanth.D., Salma.K., Sreeja.S.L., Pratiti.D., Padmaja.R., Radhika.S., Amit.A., Venkateshwarlu.K., Deepak.M. Screening of selected Indian medicinal plants for acetylcholinesterase inhibitory activity. *Journal of Ethnopharmacology*. 109 (2007) 359-363
4. Shulz. V., Ginkgo extract or cholinesterase inhibitors in dementia: what trials and fail to consider *Phytomedicine*. 10(2003) 74-79
5. Adem.A., *Acta neurol.scand.*149(suppl) (1993) 10
6. Bores.G.M., Huger.F.P., Petro.W., Matlib.A.E., Camacho.f., Rush.D.K., Selk.D.E., Wolf.V., Koslea.R.W., Davis.Jr.L., Vargas.H.M., *Jour. pharmacol. Exp. Ther.* 277 (1996) 728
7. Ma.T.C., Yu., Pharmacological studies on the effect of Panax gensing in learning and memory. *Clin. Tradit. Herbal Drugs* 21 (1990) 38-40
8. Sepcik.K., Marcel.V., Riebe.A., Turk.T., Suput.D. Fourneir. D. Inhibition of acetylcholinesterase by an alkylpyridinium polymer from the marine sponge Riniera *Biochim. Biophys Acta* 1387 (1998) 217-225
9. In Kyung Rhee, Michiel van de Meent, Kornkanok Ingkaninan, Robert verpoorte. Screening for acetylcholinesterase inhibitors from Amaryllidaceae using silica gel thin-layer chromatography in combination with bioactivity staining. *Journal of Chromatography A*, 915(2001) 217-223
10. Perry.N.S.L., Hoyghton.P.J., Theolad.A., Jenner.P., Perry.E., In vitro inhibition of human erythrocyte acetylcholinesterase by *Salvia lavandulaefolia* essential oil and constituent terpenes. *J.Pharm. Pharmacol.* 52(2000) 895-902

Òàéèööàæ ì èéó ëýó ñàí àë °ãñºí :  
Àí àääààò óóààà û äî èò î ð, î ðî ô åññî ð Åxî éæàì ö

# Ì ÌÍ Ä Ë ÖENÜ Í ÀÍ ÕÍ Ú ÄÓÍ ÄÈÉÍ ÑÓÖÄÄÖÌ ÝÑ ÇÀÑËÜ Í ÕÍ .. Ð Ä-Í

À. "ëçèéäðýð<sup>1</sup>, È.Áyì áðñ;ðýt<sup>2</sup>, " .Àççàýð<sup>3</sup>, Ä.Àðððt ð ñððt<sup>4</sup>, Á.Ì èø ýýð<sup>5</sup>, Á.Í áððt ð ñððt<sup>6</sup>

<sup>1</sup> "Ýéä" ÿ í ýéýä, Ñí i ñä ëü í ñóðéäðöü í ð "ä

<sup>2</sup>ÖÉÖÝ-ëéí -ðð ñð ñð ð ñð ëéí ð áññä

<sup>3</sup>Ý ò ÖÉN-ëéí Í ÁN-ú í Ñðððöü

<sup>4</sup>Ý ò ÖÉN-ëéí ÁL ì ñðð

<sup>5</sup>Ý ò ÖÉN, ÖÉÖÝ-ëéí ÿ i ñä ë ñóðéäðü í ñðððt ð ñððt

<sup>6</sup>Ý ò ÖÉN, "Ø ñð ñð" ÿ í ýéýä

## REPORT ON THE FIRST TWO CASES OF COCHLEAR IMPLANTATION IN MONGOLIA

Ulzibayar<sup>1</sup>, L.Byambasuren<sup>2</sup>, U.Azzaya<sup>3</sup>, G.Ariuntuul<sup>4</sup>, B.Misheel<sup>5</sup>, Á.Narantuya<sup>6</sup>

<sup>1</sup> "AID" ENT clinic, Hearing implant center, <sup>2</sup>ENT Department of CCH      <sup>3</sup>School of Dentistry, HSUM, <sup>4</sup>Graduate Training Center, HSUM  
<sup>5</sup>HSUM, Audiology cabinet of CCH, <sup>6</sup>HSUM, "Shagshaa", ENT clinic

We present the first 2 cases of cochlear implantation in Mongolia using "SONATA" type implant of "MED-EL" Company, Austria.

### Case 1.

A six years old, female had been diagnosed with bilateral congenital profound hearing loss and had been fitted with hearing aids for 5 years and received little benefit from her hearing aids and developed very poor speech and language, used lip reading and have had vocabulary of approximately 10 words. A radiological evaluation showed normal cochlea and auditory nerve. Cochlear implant team including speech therapists and audiologists based on the informed consent of patient's parent decided that family able to participate in follow-up, speech habilitation programme.

Patient implanted with SONATA of MED-EL on 4 August, 2009. Electrodes were inserted fully.

After 10 days of switch on of the speech processor the patient showed signs of initial hearing of loud sounds. After 5 months of Auditory Verbal Therapy the vocabulary increased up to 50 words. Hearing, cognition and responses are increasing simultaneously.

### Case 2.

A 2 years old female. Congenitally deaf in both ears. Fitted with hearing aid for 3 months before the surgery and there was no benefit from hearing aid. Physically and mentally healthy.

Patient implanted with SONATA of MED-EL on 4 August, 2009. Electrodes were inserted fully.

On 25<sup>th</sup> days of switching on of speech processor the patient showed initial hearing of loud sounds. Currently, after 5months of treatment her vocabulary is 2 short words and can recognize 4 syllables. She is very active, repeats actions and has open nature, feels comfortable with CI.

Pp. 29-32, Figures 2

### Òáí èë öööéä

Дүлий нь тахир дутуу болох явдлын зонхилох шалтгаануудын нэг бөгөөд нуугдмал тахир дутууд тооцогддог.

ДЭМБ-ын тооцоолсноор 2005 оны байдлаар дэлхийд 278 сая хүн сонсгол бууралтын улмаас тахир дутууд тооцогдож (сайн сонсдог чих нь дунд болон хүнд хэлбэрийн сонсголын бууралттай) байна. Дүлий хүмүүсийн гуравны хоёр нь хөгжих буй орнуудад амьдарч байгаа бөгөөд энэ тоо 1986 онд анх тогтоогдоноос хойш хэлбэрлтгүй өсч байгаа билээ (Чих сонсохуйн анхан шатны тусламж, үйлчилгээний гарын авлага, Ms.S.Harvest, 2006, [http://www.who.int/pbd/deafness/activities/hearing\\_care/en/index.html](http://www.who.int/pbd/deafness/activities/hearing_care/en/index.html)).

Манай оронд 1998 оны байдлаар сонсгол муу хүний тоо 198 000 байгаа болно (Л.Шагдар 1998).

2001 оноос ДЭМБ нь насанд хүрэгсдэд тохиолдох дүлий болон хүнд хэлбэрийн сонсгол бууралтыг Дэлхийн Эрүүл Мэндийн тайландаа хүнд өвчлөлт тооцсон юм. Хүмүүсийн дүлийгээс үүдсэн бэрхшээл, хүндэрэл нь зарим тохиолдолд амь насанд аюултай байдалд ч хүргэж болох ба эмчлээгүй тохиолдолд насан турш үргэлжилж: тэдний бусадтай харьцах

харьцаа, боловсрол эзэмших, ажилд орох, ажилтай байх боломж болон нийгмийн харьцаанд гадуурхагдах зэрэг байдалд нь нөлөөлдөг. Эдгээр асуудалууд нь мён нийгэмд бүхэлд нь эдийн засгийн томоохон гайхалтай дарамтыг үүсгэдэг байна([http://www.who.int/pbd/deafness/activities/hearing\\_care/en/index.html](http://www.who.int/pbd/deafness/activities/hearing_care/en/index.html)).

Дүлий хүмүүст сонсгол оруулан эрүүл хүмүүсийн адил ажиллаж, амьдрах боломж олгох цорын ганц эмчилгээ нь **äóí äééí ñóðéäðöü í ï ýñ çàñäé** юм (Djourno, Eyrus ба бусад 1957, [http://www.who.int/pbd/deafness/activities/hearing\\_care/en/index.html](http://www.who.int/pbd/deafness/activities/hearing_care/en/index.html)).

2009 оны 4 сарын байдлаар дэлхий даяар 188 000 хүн дунгийн суулгац мэс заслыг хийлгэж сонсголтой болсон бөгөөд АНУ-д 30 000 насанд хүрэгсэд болон 30 000 хүүхэд уг мэс заслыг хийлгэж сонсгол оржээ. Эдгээр хүмүүсийн 150 000 нь дунгийн суулгац мэс заслыг 2 чихэндээ хийлгэсэн байна (<http://www.pjstar.com/features/x876590686/> Peoria-s-first-cochlear-implant-surgery-has-grandfather-rediscovering-life, Paul Oginni (2009-11-16). "UCI Research with Cochlear Implants No Longer Falling on Deaf Ears").

Манай оронд бидний хийсэн мэс заслаас өмнө төрөлхийн болон олдмол дүлийг эмчлэх мэс заслын

эмчилгээ хийгдэж байгаагүй бөгөөд бид Монголын анхны дунгийн суулгацын 2 мэс заслынхаа үр дүнг танилцуулж байна.

### Äöí ãeéí ñóóëäöö ãýæþ ó âý?

Дунгийн суулгац нь сонсголын аппаратаас ялгаатай юм. Сонсголын аппарат нь дуу авиааг өсгөдөг. Дунгийн нь суулгац нь гэмтэлтэй болон ажиллагаагүй байгаа дотор чихний үйл ажиллагааг нөхөх үүрэгтэй. Энэ хэрэгсэл нь дууны долгиноыг хулээн аваад маш нарийн цахилгаан утсаар гадна ба дунд чихийг алгасан дотор чихэнд шууд дамжуулж, сонсголын мэдрэлийг цочроон сонсох боломжийг бурдуулдэг. Мэс заслыг ерөнхий мэдээ алдуулалттайгаар хийж, нарийн бүтэцтэй цахилгаан электродыг чамархайн ясаар нэвт оруулан дотор чихний дунд суулгадаг (Зураг 1a, 1b, 2a, 2b).



Зураг 1a.  
Зураг 1b.

Äöí ãeéí ñóóëäöö ãi ãaäí à ãi õi í áçðöëéí ñoåi , ñóóëäöö ãaäöé õjí èéé ãaäöääö ãaäéääé



Зураг 2a.  
Зураг 2b.

Wright CG, Roland PS. xàì àðöäéí ÿñi ú áè÷èë ç÷ñéúáÿð äöí ãeéí ñóóëäöö ãi ãoí àí ãi ãöö yéäéöö ãi ú áàéöëäé ã ãaäööëñi áàéääé (Cochlear Implants International ñyðäçé, 2005;6(4):159-168. Copyright John Wiley & Sons Limited).

### Äöí ãeéí ñóóëäöö í ü yì àð õjì ïjñò ðóñòäé áý?

Гүнзгий сонсголын бууралттай болон дүлий хүүхэд ба олдмөл дүлий насанд хүрэгсэд нь дунгийн суулгац хийлгэхэд тохиомжтой өвчтөнүүд юм. Дунгийн суулгац нь хүндээс гүнзгий хэлбэрээр хожуу дүлийрсэн насанд хүрэгчид, дүлий хүүхдүүдийн харилцааны чадварыг сайжруулан, тэдний амьдралын чанарыг дээшлүүлж, нийгэмд үр өгөөжтэй иргэн болгон хувиргана. Дунгийн суулгац нь хүнд болон гүнзгий сонсгол бууралттай насанд хүрэгсэд нь дохионы хэл ашиглах, уруул харах (leap reading) шаардлагагүйгээр яриаг ойлгоход туслана.

Төрөлхийн дүлий хүүхдэд 2 наснаас эрт үед мэс заслыг хийлгэсэн тохиолдолд мэс заслын дараах хэл ярианы сэргээн заслын үр дүнд эрүүл хүнтэй ижил

төстэй хэмжээнд сонсож ярих боломжтой болох ба үүнээс хожуу тохиолдолд дуу авианы гарч буй зүг чигийг тогтоох чадвар болон ярих чадвар муу хөгждөг. Олон орны чихний мэс засалчид хэл яриаг аль болох сайн хөгжүүлэх зорилгоор дүлий болон хүнд хэлбэрийн сонсгол бууралттай хүүхдүүдэд дунгийн суулгацыг аль болох эрт үед хийхийг зорьдог байна.

Гэвч сонсголын аппарат тохиromжгүй хүн бүрт дунгийн суулгац тохиомжтой гэсэн уг биш бөгөөд мэс заслын заалт гаргахад дотор чихний бүтэц, хүүхдийн оюун ухааны хөгжлийн байдал, бусад эрхтэн системийн эмгэг, ерөнхий мэдээ алдуулалтыг даах байдал зэргийг харгалzan үздэг.

### Ì ýñ çàñéû í ääðäàò í ⁰ õð í ñýðäýüéò

Дунгийн суулгац хийлгэсэн хүмүүс нь дуу авиааг хэрхэн утга төгөлдөр яриа болгон ойлгож сурхыг заалгах шаардлагатай. Суулгацыг мэс заслаас хойш ойролцоогоор 1 сарын дараа буюу мэс заслын шарх бүрэн эдгэсний дараа хэл ярианы процессорыг тохируулж асаан (switch on and first mapping) ажиллуулж эхэлдэг. Суулгацыг асаангут эдгээр хүмүүст хэл заслын эрчимтэй эмчилгээ шаардлагатай бөгөөд мөн зөвлөгөө, сургалт, эмнэлгийн болон техникийн дэмжлэг шаардлагатай.

Дүлий, хүнд хэлбэрийн сонсгол бууралттай хүүхдүүдэд уг мэс заслын дараах хэл ярианы сэргээн засал нь 2-5 жил хүртэл үргэлжлэх ба үүнд хүүхдийн гэр бүл эцэг эх, асран хүмүүжүүлэгч нар болон хэл засалч эмч, сонсгол судлаач эмч, хүүхдийн багш, сурган хүмүүжүүлэгч нар онцгой үүрэгтэй. Дунгийн суулгацын мэс заслыг хийлгэсэн хүүхдүүдэд түүнтэй харьцааг хүн бүр багш байж тэдгээр хүүхдийн хэл яриаг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргадаг.

Хэрэв шаардлагатай хэмжээний эмнэлгийн боловсрол, сургалтын, техникийн, сэтгэл зүй болон хэл заслын тусламж, үйлчилгээ үгүй бол дунгийн суулгацыг хийх ёсгүй. Дээрхи тусламж, үйлчилгээний бүтэцгүй газар дунгийн суулгацын үр ашгийг өвчтөн хүртэхгүй юм.

### Ì i í ã ë Öññää àí õi ú “Äöí ãeéí ñóóëäöö “ ì ýñ çàñéû ã òééó áýéðäýé àäéé ì óðäé

2008 оны 11 сард Австрийн Зальцбург хотын Нэгдсэн Эмнэлгийн Чих хамар хоолойн тасагт Эмч А.Өлзийбаяр нь мэргэжил дээшлүүлэх явцдаа Äöí ãeéí ñóóëäöö (cochlear implant) хэмээх дүлий хүмүүст сонсгол оруулах болон Äöö àäéäí û ãçð (sound bridge) хэмээх дунд чихний сонсгол сайжруулах суулгацыг үйлдвэрлэн, дэлхийн 80 гаруй оронд нийлүүлдэг Австри Улсын MED-EL компанийн төлөөлөг нойён Роберто Зоберинг болон Зальцбург хотын Нэгдсэн Эмнэлгийн Чих хамар хоолойн тасгийн эрхлэгч, Профессор Жерд Расп нартай хамтран ажиллаж, Монгол улсад дээрхи сонсголын суулгацын мэс заслуудыг нэвтрүүлэхэд цаашид хамтран ажиллах аман тохиолцоонд хүрч иржээ.

Энэ тохиолцооны дагуу 2009 оны 1 сарын 5-7 нд "Эйд" эмнэлгэг дээр MED-EL компанийн Ази Номхон Далайн орнуудыг хариуцсан бүсийн захирал нойён Томас Муллер болон тус компанийн клиникийн тоног төхөөрөмжийн мэргэжилтэн сонсгол судлаач, хэл засалч нойён Адриан Фуенте нар хүрэлцэн ирж дотор ба дунд чихний суулгацын талаар Монгол Улсад анхны сургалт зохион байгуулсан байна. Энэ сургалтын дараа MED-EL компанийн төлөөлөг нартай хэлэлцэж "Дунгийн

суулгацын баг"-ийг үүсгэсэн ба энэ багт мэс засалч эмч нараар: А. Өлзийбаяр, (АУ-ны доктор, клиникийн профессор, "ЭЙД" эмнэлгийн захирал), Л.Бямбасүрэн, (АУ-ны доктор, УКТЭ-ийн чих хамар хоолойн тасгийн эрхлэгч) нар орсон ба сонгол судлаач эмчээр Б.Мишээл (УКТЭ-ийн сонгол судлаач эмч), хэл засалч нараар Г.Ариунтуул (АУ-ны доктор, хэл засалч эмч, ЭМШУИС-ийн ДМА-ны дарга), Ө.Азаяа (ЭМШУИС-ийн докторант, хэл засалч эмч), зөвлөх эмч нараар Ё. Намжилмаа (АУ-ны доктор, Монгол Улсын хүний гавьяат эмч), О.Сэргэлэн (АШУ-ны доктор, ЭМШУИС-ийн мэс заслын тэнхимийн эрхлэгч) нар ажиллахаар болжээ. Уг сургалтын явцад **ME-DEL** компанийн мэргэжилтнүүд нь дунгийн суулгацын мэс заслыг "ЭЙД" эмнэлэгт хийх бүрэн бололцоотой гэж үзэн манай мэс засалчдыг эцсийн шатны давтан сургалтанд хамруулахаар тохиолдсон байна.

Манай багийн гишүүд дараах сургалтуудад хамрагдан дотор чихний суулгацын мэс засал түүний дараах нахан сэргээлтэнд бэлджээ.

2009 оны 2 сарын 23-27-нд **MED-EL**-ийн Ази Номхон Далайн орнуудыг хариуцсан бүсийн Гонконг дахь төв дээр хөхөнцрийн мэс заслын лабораториид мэс засалч А.Өлзийбаяр, Л.Бямбасүрэн нар сорилго, сургалтанд хамрагдаж дотор болон дунд чихний суулгацын мэс заслыг хийх чадвартай гэж үнэлэгдэн гэрчилгээ авч тус 2 төрлийн имплантыг суулгах мэс заслыг хийх болон имплантыг Монголд нийлүүлэх гэрээнд "Доктор тун" компанийг төлөөлөн А. Өлзийбаяр гарын үсэг зурсан байна.

Монголд анхны өвчтөн сонголт болон мэс заслыг Австрийн мэс засалч профессор Герд Расп, Италийн мэс засалч профессор Кристиан Стрейтбергер нартай хамтран хийхээр тохиолцжээ.

2009 оны 5 сарын 4-29-нд чихний мэс засалч эмч А. Өлзийбаярыг Австри Улсын Зальцбург хотноо Профессор Герд Распын удирдлага дор гүнзгийрүүлэн сургасан ба энэ хугацаанд эмч А.Өлзийбаяр нь Профессор Жерд Распын хяналтан дор анхны 2 өвчтөндөө кохлеостоми ( дотор чихний дунг өрөмдөн нээх) хийжээ.

Мөн эмч А. Өлзийбаяр нь 2009 -ны 5 сард мөн Австри Улсын Инзбург дэх **MED-EL** компанийн төвд очиж, дотор чихний суулгацыг ўйлдвэрлэх явцтай танилцаж компанийн удирдлагуудтай уулзсан байна.

Г.Ариунтуул нь хэл яриа заслын нарийн мэргэжлээр Япон Улсын Айчи-Гакуин Их Сургуулийн Хэл Яриа Заслын Тэнхимд З жилийн хугацаагаар суралцсан бөгөөд АНУ-ы Висконсоны Их Сургуульд дотор чихний суулгацын дараах хэл заслын эмчилгээгээр 2009 оны 6-7 сард 45 хоног мэргэжил дээшлүүлсэн. Эмч Ө.Азаяа нь хэл яриа заслын нарийн мэргэжлээр 2 жилийн хугацаанд ЭМШУИС-ийн НАСС-ийн Хэл, яриа заслын кабинетад эмч Г.Ариунтуулыг дагалдан ажиллаж, суралцсан ба Япон Улсын Айчи-Гакуин Их Сургуулийн Хэл Яриа Заслын Тэнхимд богино хугацааны сургалтанд хамрагдсан ажээ.

Сонгол судлаач эмч Б.Мишээл нь 2009 оны 5-8 сард Бээжин хотын "Chinese pla", Шанхай хотын "Xinhua", Сингапурын "Tang Tokc Seng" эмнэлэгт тус бүр нэг сар, нийт 3 сарын хугацаанд дунгийн суулгацын мэс заслын дараах аппарат тохируулгаар мэргэжил дээшлүүлжээ.

Дунгийн суулгац мэс заслыг Монгол Улсад нэвтрүүлэн хийх арга аргачлалыг дараах эрдэм

шинжилгээ, ёс зүйн хорооны хурлаар хэлэлцэн баталсан болно:

- УКТЭ-ийн Эрдмийн зөвлөлөөр, 2009 оны 4 сарын 28
- ЭМШУИС-ийн Эрдмийн Зөвлөл, 2009 оны 4 сарын 30
- ЭМЯ-ны Ёс Зүйн Хорооны Хурал, 2009 оны 5 сарын 8
- Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын зөвлөлөөр, 2009 оны 6 сарын 11.

Дунгийн суулгацын анхны мэс заслуудыг 2009 оны 8 сарын 3, 4-нд "ЭЙД" эмнэлэгт хийсэн ба анхны 2 тохиолдлын тухай танилцуулъя:

#### 1-д Өөр өөр өөр өөр

Зургаан настай эмэгтэй. Төрөлхийн баруун талын гүнзгий зэргийн сонголтын бууралттай, зүүн талын чих дүлий. Уруул, тагнайн төрөлхийн сэтэрхийтэй ба 9 сартайд мэс заслын эмчилгээг хийлгэсэн. Удамшлын асуулааар гэр бүлд дүлий хүмүүс үгүй болохыг удамшлын эмч тодорхойлсон. Оюун ухааны болон ерөнхий биеийн хөгжил хэвийн. Өвчтөн 1,6 нааснаасаа 5 жилийн турш сонголтын аппарат зүүсэн боловч хэл яриа муу хөгжсөн ба үгийн баялаг 10 орчим байсан. Уруулын хөдөлгөөн харж ойролцоогоор 10 үгийг ойлгож хэлдэг, уруул харалгүй нэг үтэй үг, өгүүлбэр ойлгох чадваргүй. Хүүхэд сэтгээцийн эмгэг үгүй, хэл яриа сайн хөгжөөгүйн улмаас бүрэг ичимхий, орчиндоо идэвхи мутай.

Хоёр талын чих үрэвсэлгүй. Дүрс оношлогоонд дунгийн хөндий болон сонголтын мэдрэлүүд хэвийн харагдаж байсан.

Сонгол шалгахад зүүн чих аппаратгүй болон аппаратуртай сонсохгүй. Баруун чих аппараттай дунджаар 95 дб сонсно.

Гэр бүлийнхэн нь дунгийн суулгац мэс заслын үр дүнгийн тухай сайн судалсан бөгөөд уг мэс заслын явц үр дүнг хүлээн авах болон мэс заслын дараах нөхөн сэргээх эмчилгээнд сэтгэл зүйн бэлтгэлтэй байв. Мэс заслын өмнө багийн эмч нар хамтран ярилцаж өвчтөний гэр бүлийг мэс заслын дараах урт хугацааны нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдах бүрэн боломжтой гэж үзсэн.

Мэс засалд 2009 оны 8 сарын 3-нд орж, **MED-EL** компанийн стандарт электродтой SONATA суулгацыг ашигласан ба дугариг цонх орчмын хүрцээр дунг өрөмдөн цоолов. Электрод дун дотор бүрэн орсон. Мэс заслын үед хийсэн телеметрид электродууд хэвийн ажиллагаатай байв. Мэс заслын хүндрэл үгүй.

#### 2-д Өөр

Дунгийн суулгацын дараах Auditory-Verbal Therapy (AVT) буюу Сонгол-хэл, ярианы эмчилгээг төрөлхийн уруул тагнайн сэтэрхийн мэс заслын дараах Velopharyngeal Incompetency (VPI) буюу Хүүхэн хэл залгиурын дутмагшлын үеийн хэл заслын эмчилгээтэй хослуулан хүүхдийн онцлогт тохируулан явуулж байна.

Мэс заслаас хойш 5 сарын хугацаанд хэл ярианы процессорын тохируулгыг (cochlear implant fitting) нийт 8 удаа хийсэн.

Дунгийн суулгацтай талаар чанга дуу, авиааг сонсч байгаа анхны шинж тэмдэг хэл ярианы процессорыг асаасны 10 дахь хоногоос ажиглагдсан бөгөөд асаалтаас хойш 1 сарын дараа гэхэд үг хэлэхэд дунгийн суулгацтай талаар дангаар сонсч, дагаж хэлж байв. Анхны сонгол-хэл, яриа заслын хичээлээс хойш

2 сар болоход хэвийн ярианы өнгөөр ярихад сайн сонсон дуурайж хэлэх бөгөөд 7 эгшиг, 3 гийгүүлэгч авиааг сонсголоор ялгаж, 2 үйл үг ойлгодог болсон. Гурван сарын дараах байдааар үгийн баялаг 15 орчим үгээр нэмэгдсэн ба 4 сарын дараа үгийн баялаг 30 орчим болж ганц үгээр өөрийн зарим хүсэл, шаардлагыг илэрхийлдэг болов. Хэл ярианы процессорыг асааснаас 5 сарын дараах буюу одоогийн үр дүнгээр үгийн баялаг 50 орчим, 1-2 үгээр зарим бодол, санаагаа илэрхийлдэг, ярианы чанга, сул, дууны өнгө, аялгыг сайн ялгадаг болсон.

## 2-ð õðéé ëäéé ëé

Хоёр настай эмэгтэй. Төрөлхийн дүлий. Мэс заслын өмнө 3 сар сонсголын аппарат хэрэглэхэд үр дүнгүй болох нь тодорхойлогдсон. Оюун ухааны болон ерөнхий биеийн хөгжил хэвийн. Хэл, яриа хөгжөөгүй. Бусад хавсарсан гажиг үгүй.

2 чих үрэвсэлгүй. Дүрс оношлогоонд дунгийн хөндий болон сонсголын мэдрэлүүд хэвийн харагдана.

Гэр бүлийнхэнд нь дунгийн суулгац мэс заслын үр дүнгийн тухай болон мэс заслын дараах нөхөн сэргээх эмчилгээнд удаан хугацаагаар явж, үр дүн нь гарна гэдгийг удаа дараагийн уулзалтаар тайлбарлан ойлгуулсан. Мэс заслын өмнө багийн эмч нар хамтран ярилцаж өвчтөний асран хамгаалагчдаас таниулсан зөвшөөрөл авсан ба мэс заслын дараах нөхөн сэргээх урт хугацааны эмчилгээнд хамрагдах бүрэн боломжтой хэмээн үзлээ.

Мэс засалд 2009 оны 8 сарын 4-нд орж, **MED-EL** компанийн стандарт электродтой SONATA суулгацыг ашигласан ба кохлеостомиг дугариг цонхоор хийв.

Электрод дун дотор бүрэн орсон. Мэс заслын үед хийсэн телеметрид электродууд хэвийн ажиллагаатай байлаа. Мэс заслын хүндрэл үгүй.

## -ð äéí

Дунгийн суулгацын дараах Auditory-Verbal Therapy (AVT) буюу Сонсгол-хэл, ярианы эмчилгээг хүүхдийн насны онцлогт тохируулан явуулж байна.

Мэс заслаас хойш 5 сарын хугацаанд хэл ярианы процессорын тохируулгыг (cochlear implant fitting) нийт 10 удаа хийсэн.

Хүүхэд мэс заслаас өмнө дуу, авиа гаргадаггүй байсан бол хэл ярианы процессорыг асаасан эхний сард үйл хөдлөл хийх үедээ янз бүрийн дуу, авиа гаргадаг болсон. Чанга дуу, авиа сонсч байгаа анхны шинж тэмдэг хэл ярианы процессорыг асааснаас 25 хоногийн дараагаас ажиглагдсан бөгөөд асаалтаас хойш 1 сарын дараа анхны авиаагаа хэлсэн ба 2 сарын дараа 2 авиааг сонсголоор ялгаж, хэлдэг болов. Анхны сонсгол-хэл, яриа заслын хичээлээс хойш 3 сараас 2 авиа хэлдэг, чанга чимээг сонсоод эргэж харах, өөр өрөөнөөс чанга дууг сонсох чадвартай болсон. Анхны үгээ асаалтаас хойш 3.5 сарын дараа хэлсэн ба 4 сарын дараа гэхэд 3 авиа, 1 үгийг сонсголоор ялгаж, дуурайн хэлдэг болов. Хэл ярианы процессорыг асааснаас 5 сарын дараах буюу одоогийн үр дүнгээр 4 авиааг сонсголоор ялгаж, 2 үг хэлдэг, дууны чанга сул, урт богиных сайн ялгаж дуурайх чадвартай болсон байна.

## ÓÝÐÝÖ<sup>a</sup> ÂxÈÍ ÁÀ ÓÝÐÝÖÈÉÍ ØÀËÖÃÀÁÍ ÒÀÉ ÇÐÖÍ ÈÉ ÝÍ ÁÝÃÈÉÍ ÎÍ ÏØËÍ ÁÍ Î

ӰÁí ëí ðí áàI, Ä. Çœäýðyë<sup>2</sup>, x. Öí áò -Î -ëð<sup>2</sup>  
<sup>1</sup>ÝðÍ yéöñü í Ýðäýí Ø èí æ èëäýí èé Öá  
<sup>2</sup>Ýðëëé i yí áæéí ø èí æ ýðö öðâáí û èð ñóðâóðéü

### THE DIAGNOSIS OF RHEUMATIC FEVER AND RHEUMATIC HEART DISEASE

T.Bolormaa<sup>1</sup>, D.Zulgerel<sup>2</sup>, Ch.Tsogt-Ochir<sup>2</sup>

<sup>1</sup>Maternal and Child Research Medical Center

<sup>2</sup>Health Science University

The Jones criteria is a clinical guideline for the diagnosis of rheumatic fever(RF) and carditis. The clinical features were divided into major and minor categories. Major manifestations include carditis, joint symptoms, subcutaneous nodules, erythema marginatum and chorea. The minor manifestations comprised clinical findings(fever, artralgia, cardialgia,abdominal pain, nose bleeding ) and laboratory markers(Leukocytosis, elevated erythrocyte sedimentation rate and C-reactive protein, prolonged PR on ECG). It was proposed that the presence of two major, or one major and two minor manifestations offered reasonable clinical evidence of rheumatic activity.

Carditis is the single most important prognostic factor in RF; only valvulitis leads to permanent damage and its presence determines the prophylactic strategy. The clinical diagnosis of carditis in an index attack of RF is based on the presence of significant murmurs (suggestive of mitral and aortic regurgitation), pericardial rub, or unexplained cardiomegaly with congestive heart failure.

Myocarditis(alone) in the absence of valvulitis is unlikely to be of rheumatic origin and by itself should not be used as a basis for such a diagnosis.

Two dimentional echo-Doppler and colour flow Doppler echocardiography are most sensitive for detecting structural abnormality, abnormal blood flow and valvular regurgitation. This method can detect all audible valvular regurgitations to be dThe use of 2D echo-Doppler and colour flow Doppler echocardiography may prevent the overdiagnosis of a functional murmur as a valvular heart disease. Similarly, the overinterpretation of physiological or trivial valvular regurgitation may result in misdiagnosis of iatrogenic valvular disease. Accurate interpretation of the echocardiographic signals is therefore important.

**Key words:** Jones criteria, rheumatic carditis, valvulitis, echocardiography, subclinical carditis, valvular regurgitation.

Pp. 33-36, Table 1, References 53

Хэрэх өвчин нь А бүлгийн бетта цус задлагч стрептококкийн шалгаантай үүсдэг холбогч эд нэн ялангуяа зүрх судасны тогтолцоог гэмтээдэг халдвар харшлын өвчин юм [1].

Хэрэх өвчний оношлогоо нь Джонсоны шалгуурт тулгуурах ба уг шалгуураар хэрэх өвчний шинжүүдийг үндсэн(их) ба туслах(бага) гэж 2 хуваасан байдаг [1-6]. Их шалгуур нь оношийг тавихад тэрүүлэх үүрэгтэй бөгөөд үүнд кардит, үений үрэвсэл, арьсан доорхи зангилаа, цагираг улайлт, хорея багтдаг. Дахилтат хэрэх өвчний шалгуурт хэрэх өвчнөөр өвчилсөн өгүүлэмж, хэрэхийн зүрхний өвчин ордог. Бага шалгуур нь оношийг таамаглахад тустай боловч дангаараа хангалттай бус юм. Оношлогооны бага шалгуурт эмнэлзүйн (халууралт, үеэр өвдэх, зүрхээр өвдэх) ба лабораторийн (цагаан эсийн тоо ихсэх, С урвалжит уураг илрэх, ЗЦБ-т PQ уртсах) үзүүлэлтүүд багтана. Оношлогооны их шалгуураас 2, эсвэл их шалгуураас 1 ба бага шалгуураас 2 шинж байвал хэрэх өвчин гэж оношилно (Хүснэгт 1).

Дээрхээс үзэхэд хэрэх өвчний оношлогоо нь гол төлөв эмнэлзүйн шинжүүд дээр тулгуурлан тавигдах ба лабораторийн шинжүүд нь зөвхөн туслах шинжтэй

бөгөөд эмгэг процессын идэвхжил, эмчилгээний үр дүнг үнэлэхэд тустай юм [7].

Хэрэх өвчний оношлогооны шалгуурт саяхан (сүүлийн 45 хоногийн дотор) илэрсэн стрептококкийн халдвар нь оношиг батлах чухал үүрэгтэй

[2,3] боловч уг халдвар хэдийн намдсан (тухайлбал, архаг кардит) эсвэл хожимдсон эмнэлзүйн тохиолдолд стрептококкийн халдвартыг батлах шаардлагагүй гэж үзжээ [4, 5].

Кардит нь хавхлагийн эргэшгүй гэмтэлд хүргэдэг, хэрэх өвчнөөс сэргийлэхийг зайлшгүй шаарддаг, цаашдын тавиланг илтгэгч хамгийн чухал ганц хүчин зүйл мэн [8]. Зүрхний оройд I авиа бүдгэрэх, агшилтын шуугиан сонсодох (хоёр хавтаст хавхлага эсвэл гол судасны регургитац (цусны эргэх урсгал), үнхэлцгийн үрэлтийн чимээ эсвэл зүрхний томрол зэрэг шинжүүд илэрвэл хэрэхийн кардит гэж оношилно. Хэрэх өвчний анхны дайралтаар зүрхийг гэмтээж болох ч дахилтын үед зүрхийг хэдийнээ хамарсан байх болно [9, 10]. Өвчин дахижад хавхлагийн гэмтэл зайлшгүй тодорхойлогдох ба үнхэлцэг болон булчингийн гэмтэл харилцан адилгүй илэрнэ [11]. Зүрхний хэмжээ рентгенд томрох, өмнөх шуугиан өөрчлөгдэх, шинэ шуугиан нэмэгдэх, үнхэлцгийн үрэлтийн чимээ илрэх

зэрэг шинжүүд нь дахилтат хэрэх өвчин гэх үндэслэл болно [9, 12, 13].

**Хүснэгт 1. Хүдүү ө аа дүйүүдээ үүдээ ө аа дүйүүдээ Үүдээ ө аа дүйүүдээ (АҮА А, 2002-2003)**

Оношлогоо	Шалгуур
Их шалгуур	<ul style="list-style-type: none"> <li>- кардит</li> <li>- полиартрит</li> <li>- хорея</li> <li>- цагираг улайлт</li> <li>- арьсан доорх зангилаа</li> </ul>
Бага шалгуур	<ul style="list-style-type: none"> <li>- ю́ / ю́цю́: халуурах, үеэр өвдөх, зүрхээр өвдөх, хэвлүүгээр өвдөх, хамраас цус гарах</li> <li>- ёё́ / дэ́дэ́: УЭТХ ихсэх, цагаан эсийн тоо олшрох, Цидэвхит уураг ихсэх</li> </ul>
Сүүлийн 45 хоногийн дотор илэрсэн Стрептококкийн халдвэр	<ul style="list-style-type: none"> <li>- ЗЦБ-т: PR хугацаа уртсах</li> <li>- ASO эсвэл бусад АТ ихсэх</li> <li>- Залгиурын арчдас эрэг илрэх</li> <li>- Залгиурын стрептококкт үрэвсэлийг илрүүлэх түргэвчилсэн сорил эерэг байх</li> </ul>
Хэрэх өвчний анхны дайралт	Их шалгуураас 2 эсвэл их шалгуураас 1 ба бага шалгуураас 2, дээр нь А булгийн стрептококк илэрвэл
Хэрэхийн кардит үүдээ өвчтөнд хэрэх өвчний дахилт	Их шалгуураас 2 эсвэл их шалгуураас 1 ба бага шалгуураас 2 байвал
Хэрэхийн кардит үүдээ өвчтөнд хэрэх өвчний дахилт	Их шалгуураас 2 эсвэл их шалгуураас 1 ба бага шалгуураас 2 байвал
Хэрэхийн хорея	Их шалгуураас аль нэг нь байх, А булгийн стрептококкийн баталгаа шаардлагагүй
Хэрэхийн хавхлагийн гэмтэл (хоёр хавтаст хавхлагийн нүхний нарийсал, эсвэл дутагдал; хоёр хавтаст хавхлагийн хавсарсан гажиг эсвэл гол судасны хавхлагийн гажигтай хавсрах)	Хэрэхийн зүрхний өвчний тодорхойлох бусад шалгуур шаардлагагүй

**Оүдүүдээ ө аа дүйүүдээ үүдээ ө аа дүйүүдээ**

Хэрэхийн шалтгаант өвчинд зүрхний дотор давхарга, булчин, үнхэлцэг зэрэг нь аажмаар нэрвэгдэн ихэнхдээ хавхлагийн шуугиан зонхилдог боловч зүрхний булчин, үнхэлцэг анхдагчаар үрэвсэх үед шуугиан үүссэн байхыг үгүйсгэхгүй.

**Оаа дүйүүдээ, үүдээ ө аа дүйүүдээ үүдээ ө аа дүйүүдээ (Valvulitis/ endocarditis)**

Өгүүлэмжиндээ хэрэх өвчин ба хэрэхийн шалтгаант зүрхний өвчинөөр өвчлөөгүй хүмүүст зүрхний оройд хоёр хавтаст хавхлагийн дутагдлын улмаас үүссэн систолын шуугиан (оройн цэгт диастолын дунд үеэс сонсогдох

шуугиантай эсвэл шуугиангүй) эсвэл гол судасны хавхлагийн дутагдлын улмаас үүссэн диастолын шуугиан илэрсэн бол хэрэхийн кардитыг таамаглах нь зүйтэй юм. Түүнчлэн өмнөх шуугианд өөрчлөлт орсон тохиолдолд кардит гэж үзнэ.

**Үүдээ ө аа дүйүүдээ үүдээ ө дүйүүдээ (Myocarditis)**

Зүрхний хавхлага гэмтээгүй миокардит дангаараа байх нь хэрэх өвчинд тохиорхгүй ба дан ганц миокардитыг оношлогоонд суурь болгож болохгүй [14]. Миокардит нь зүрхний оройн агшилтын эсвэл суурь хэсгийн суралын шуугиантай хавсарсан байх учиртай. Хэрэв эмнэлзүйд зүрхний дутагдал, рентгенд зүрхний томрол илэрвэл зүрхний булчинт давхрага гэмтсэн гэж үзэж болно. Халдварт эндокардит нь хэрэх өвчиний дахилтны үед мөн л нуугдмал байж болдог [15].

Хэрэх өвчиний үед зүрхний дутагдал үүсэх нь хүнд хэлбэрийн кардитаар өвчилснийг гэрчлэх ба зүрхний булчин гэмтсэнтэй холбоотой байдаг. Хавхлагийн дутагдал үүсээгүй үед зүүн ховдлын агшилтын үйл ажиллагаа алдагдах нь хэрэх өвчин гэх үндэслэл болохгүй. Ерөнхийдөө зүрхний дутагдлын хам шинж хавхлага хүнд хэлбэрээр гэмтсэнд нотолдог [16, 17].

**Үүдээ ө аа дүйүүдээ үүдээ ө дүйүүдээ (Pericarditis)**

Хэрэх өвчиний үед үнхэлцэг хальс гэмтвэл шүргэлцэх чимээ, цээжний өвдөлт илэрч болно. Үрэлтийн чимээ нь магадгүй хоёр хавтаст хавхлагийн дутагдлын шуугианыг далдан нуугдуулж болох ч, үүнийг үнхэлцэг хальсны үрэвсэлийг баталсны дараал мэддэг. Хавхлагийн дутагдлын шуугиан илрээгүй дан ганц үнхэлцэг хальсны үрэвсэл байх нь хангалтгүй, тиймээс зүрхний хэт авиан шинжилгээгээр хоёр хавтаст хавхлагийн дутагдлыг батална. Зүрхний хэт авиан шинжилгээ нь үнхэлцэг хальсны үрэвслийн хэлбэрийг тодорхойлох, үнхэлцэг хөндийд шингэн байгаа эсэхийг шалгахад тустай байдаг. Хэрэхийн үнхэлцэг хальсны үрэвслийн үед их хэмжээний шингэн эсвэл тампонад маш ховор байдаг [18]. Үнхэлцэг хальсны үрэвслийн үед ЗЦБ-т QRS бурдэлийн далайц намсах, ST-T өөрчлөгдөх, рентгенд зүрхний томрол илрэнэ. Үнхэлцэг хальсны үрэвслийн аль ч хэлбэрийг хүнд кардиттай адилтгаж эмчилгээг хийнэ.

**Оүдүү ө аа дүйүүдээ үүдээ ө аа дүйүүдээ үүдээ ө дүйүүдээ**

Орчин үед зүрхний хэт авиан шинжилгээ нь зүрхний өвчиний оношлогоонд гол үүрэг гүйцэтгэж байна. Үүнд цээжний гаднаас, улаан хоолойгоор ба зүрхэн дотроос харах гэсэн аргуудыг ашигладаг [19-21]. Мөн түүнчлэн 3 хэмжээст болон 4 хэмжээст хэт авиан шинжилгээний аргууд гарч ирлээ

[22]. Хэрэхийн кардит болон хавхлагийн өвчиний оношлогоод М-горим, 2 хэмжээст Эхо-допплер ба өнгөт-допплер Эхо тустай байдаг. 2 хэмжээст Эхо шинжилгээгээр бодит дүрслэлд зүрхний анатомийн бүтцийн зураглалыг харж оношлох боломжтой. 2 хэмжээст Эхо-допплер ба өнгөт допплер зүрхний хэт авиан шинжилгээ нь зүрхний хэвийн бус цусны урсгал ба хавхлагийн дутагдлыг илрүүлэхэд хамгийн мэрэг шинжилгээ юм. 2 хэмжээст эхо-допплер болон өнгөт допплер зүрхний хэт авиан шинжилгээг

ашигласнаар зүрхний үйл ажиллагааны шуугианыг хавхлагийн гажгийн шуугиан гэж хэт оношлооос сэргийлэх [23] эсвэл эмнэлзүйн илрэлгүй хавхлагийн гажгийг эрт үед нь оношлох ач холбогдолтой [24, 25]. Хоёр хэмжээст зүрхний хэт авиан шинжилгээгээр хоёр хавтаст, гол судас, гурван хавтаст болон уушгины arterийн хавхлагуудын бүтэц, эмгэг байдал, хавхлагийн цагирагыг үнэлэх боломжтой. Өнгөт допплер хэт авиа нь хавхлагараар урсац цусны урсгалд чанарын болон тооны үзүүлэлтийг гаргах, урсгалын зэргийг тодорхойлох боломжтой [29, 37, 40, 41]. Бусад шалтгаантай хавхлагийн эмгэгүүдийг ялган оношлох ба хавхлага шилжүүлэн суулгах хагалгааны хугацааг тодорхойлох боломжтой [41].

### Ý í ýéçééí èëðýé áðöéé õýðééýééí èëðäéò

Зүрхний хэт авиан шинжилгээ нь тосгур, ховдлын хэмжээ, хавхлагийн зузаарал, пролапс, хавтасны хөдөлгөөн, ховдлын үйл ажиллагааны алдагдал зэргийг мэдээлдэг [26, 31, 32]. Зүрхний дутагдал үүсэх нь хоёр хавтаст болон гол судасны хавхлагийн дутагдлын зэргээс хамааралтай байдаг [33]. Зүрхний булчингийн үйл ажиллагааны алдагдал нь зүрхний дутагдад хүргэдэг хэдий ч зүүн ховдлын агшилтын үзүүлэлт хэвийн байх нь элбэг бөгөөд мэс заслын эмчилгээний дараа эргэн сайжирдаг [34]. Хоёр хавтаст хавхлагийн үрэвсэл, хавхлагийн цагирагийн өргөсөлт, пролапс, шөрмөсөн хөвч уртсах нь хавхлагийн дутагдлын зэрэгт нөлөөлдөг [33, 35].

### Öââðëàæéí äóðåæé ï ýóí èëðäéí àðâðò èéí áí àééæéí çýðæéí

Уламжлалт ангиллааар хавхлагийн дутагдлыг 5 зэрэгээр үнэлдэг байсан бол орчин үед өнгөт допплер шинжилгээнд үндэслэн хоёр хавтаст хавхлага болон гол судасны хавхлагийн дутагдлыг 6 зэрэгт ангилж байна [36-39].

- 0: үйл ажиллагааны эсвэл ялимгүй эргэх урсгал, 1.0 см-ээс бага, нарийн, жижиг, үргэлжлэх хугацаа нь богино
- 0+: маш бага эргэх урсгал 1.0 см-аас их, өргөн, хавхлага дээр эсвэл доор байрлах, эмнэлзүйд илрэлгүй
- 1+: бага хэмжээтэй эргэх урсгал
- 2+: дунд хэмжээтэй эргэх урсгал
- 3+: дунд хэмжээнээс эргэх урсгал нэмэгдэх, тухайлбал урсгал нь хоёр хавтаст хавхлагийн дутагдлын үед зүүн тосгурт хүрэх, гол судасны хавхлагийн дутагдлын үед зүүн ховдолд хүрэх
- 4+: их хэмжээтэй эргэх урсгал, зүүн тосгурт тархсан урсгал, хоёр хавтаст хавхлагийн дутагдлын үед агшилтын эргэх урсгал уушгины венүүд рүү орох, гол судасны хавхлагийн дутагдлын үед илэрхий томорсон зүүн ховдол эргэх урсалаар дүүрэх

### Öââðëàæéí í àðèéñéí í í í øéí áí

Хоёр хавтаст хавхлагийн нарийсал нь хэрэх өвчний үед элбэг тохиолдох ба ихэнхи тохиолдолд зүрхний мэс заслын заалт болдог. Нарийслын зэрэг нь хавхлагийн онгойлтын талбайгаар тодорхойлогдоно.

Бага зэргийн нарийсал-хоёр хавтаст хавхлагийн онгойлтын талбай 1,6-2,0 см<sup>2</sup>

Дунд зэргийн нарийсал- хоёр хавтаст хавхлагийн онгойлтын талбай 1,1-1,5 см<sup>2</sup>

Хүнд зэргийн нарийсал- хоёр хавтаст хавхлагийн онгойлтын талбай <1,0 см<sup>2</sup>

Гол судасны хавхлагийн нарийслыг хавхлагийн нээлтийн зэргээр тодорхойлно.

Хавхлагийн нарийсал нь дутагдалтай хавсарч илэрч болно.

### Äæä ÿâöðæé õýðóøééí èæðæèøééí í í øéí õ

Хэрэхийн кардитын оношлогоог хоёр хавтаст болон гол судасны хавхлагийн шуугианыг чагналтаар илрүүлэх уламжлалт аргад үндэслэдэг. Хоёр хэмжээст эхо допплер болон өнгөт допплер нь эмнэлзүйн илрэлгүй хавхлагийн дутагдлыг илрүүлдгэрээ ач холбогдолтой юм [42-48].

Орчин үед хэрэхийн оношлогоонд хавхлагийн үрэвслийг цаг алдалгүй оношлох нь нэн чухал ба үүнд зүрхний хэт авиан шинжилгээ нь чухал үүрэг гүйцэтгэж байна [49].

### Çððí èé õýð àâèàí øéí æèéáýí èé äââóó ðâéóóä

Зүрхний хэт авиан шинжилгээ нь хэрэхийн кардитыг илрүүлэхэд мэдрэг бөгөөд үүний үр дүнд өвчтөн буруу оношлогодох, улмаар хэрэхийн хоёрдогч урьдчилан сэргийллэлтийг дутуу хийх, тавиланг дутуу үнэлэхээс сэргийлэх боломжтой [50, 51]. Хавхлагийн дутагдал нь үзлэгээр тэр бүр илрүүлэх боломжгүй байдаг ба анхдагч хэрэхийн үед зүрхэнд шуугиан илрэхгүй байснаа хяналтын явцад хэрэхийн гаралтай хавхлагийн гажиг үүсэх тохиолдол цөөнгүй байна. Энэ нь чагнах үзлэгийг хэдий сайн хийсэн ч гэсэн кардитыг оношлохгүй үлдээх боломж байгааг илтгэж байна [52, 53].

Хоёр дахь давуу тал нь зүрхний хэт авиан шинжилгээгээр хавхлагийн бүтцийг бүрэн илрүүлэх боломжтой бөгөөд хэрэхийн бус бусад эмгэгүүдийг (хавхлагийн пролапс, гол судас, хоёр хавтаст хавхлагийн төрөлхийн гажиг) ялган оношлох давуу талтай [53]. Нөгөө талаас зүрхний хэт авиан шинжилгээнд үндэслэн хэвийн хавхлагад гарч болох шинж тэмдгийг хэрэхийн кардит гэж хэт оношлооос сэргийлнэ [53].

### Í í çéé

1. Jones TD. Diagnosis of rheumatic fever. Journal of the American Medical Association, 1944, 126:481-484.
2. Rutstein DD et al. Report of the Committee on Standards and Criteria for Programs of Care of the Council of Rheumatic Fever and Congenital Heart Disease of American Heart Association. Jones Criteria(modified) for guidance in the diagnosis of rheumatic fever.Circulation, 1956, 13:617-620.
3. Stollerman GN et al. Report of the ad hoc Committee on Rheumatic fever and Congenital Heart Disease of American Heart Association: Jones Criteria(revised) for guidance in the diagnosis of rheumatic fever. Circulation, 1965,32:664-668.
4. Shulman ST et al. Committee on Rheumatic Fever, Endocarditis and Kawasaki disease of the American Heart Association. Jones Criteria (Revised) for guidance in the diagnosis of rheumatic fever.Circulation,1984,70:204A-208A.
5. Dajani AS et al. Special writing group of the Committee on Rheumatic Fever,Endocarditis and Kawasaki disease of the Council of Cardiovascular Disease in the young of the American Heart Association. Guidelines for the diagnosis of rheumatic fever: Jones Criteria 1992 Update. Journal of the American Medical Association, 1992, 268:2069-2073.
6. Rheumatic fever and rheumatic heart disease.Report og WHO study group.Geneva, World Health Organization, 1988 (Technical Report Series,No. 764).
7. Okuni M. Problems in clinical application of revised Jones

- dagnostic criteria for rheumatic fever. Japanese Heart Journal, 1971, 12:436-441.
8. Massell BF, Narula J. Rheumatic fever and rheumatic carditis. In: Braunwald E, Abelman WH, eds. The atlas of heart diseases. Philadelphia, Current Medicine, 1994:10.1-10.20.
  9. Feinstein AR, Stern EK. Clinical effects of recurrent attacks of acute rheumatic fever: a prospective epidemiologic study of 105 episodes. Journal of Chronic Diseases, 1967, 20:13-27.
  10. Kuttner AG, Meyer FE. Carditis during second attack of rheumatic fever: its incidence in patients without clinical evidence of cardiac involvement in their initial rheumatic fever episode. New England Journal of Medicine, 1963, 268:1259-1262.
  11. Narula J et al. Can Antimyosin scintigraphy supplement the Jones Criteria in the diagnosis of active rheumatic carditis? American Journal of Cardiology, 1999, 84:746-750.
  12. Feinstein AR, Spagnuolo M. Mimetic features of rheumatic fever recurrences. New England Journal of Medicine, 1960, 262:533-540.
  13. Markowitz M. Evolution and critique of changes in Jones criteria for diagnosis of acute rheumatic fever. New Zealand Medical Journal, 1988, 101:392-394.
  14. KrishnaKumar R et al. Epidemiology of streptococcal pharyngitis, rheumatic fever and rheumatic heart disease. In: Narula J et al., eds. Rheumatic fever. Washington, DC, American Registry of Pathology, 1999:41-68.
  15. Kaplan EL, Narula J. Echocardiographic diagnosis of rheumatic fever. Lancet, 2001, 358(9297):2000.
  16. Essop MR, Wisenbaugh T, Sareli P. Evidence against a myocardial factor as the cause of left ventricular dilation in active rheumatic carditis. Journal of the American College of Cardiology, 1993, 22:826-829.
  17. Edwards BS, Edwards JE. Congestive heart failure in rheumatic carditis: valvular or myocardial origin. Journal of the American College of Cardiology, 1993, 22:830-831.
  18. Tan AT, Mah PK, Chia BL. Cardiac tamponade in acute rheumatic carditis. Annals of the Rheumatic Diseases, 1983, 42:699-701.
  19. Feigenbaum H, Zaky A, Waldhausen JA. Use of ultrasound in the diagnosis of pericardial effusion. Annals of Internal Medicine, 1966, 65:443-452.
  20. Seward JB et al. Transesophageal echocardiography: technique, anatomic correlations, implementation and clinical applications. Mayo Clinic Proceedings, 1988, 63:649-680.
  21. Minich LL et al. Role of echocardiography in the diagnosis and follow-up Evaluation of rheumatic carditis. In: Narula et al., eds. Rheumatic fever. Washington, DC, American Registry of Pathology, 1994:307-318.
  22. Sahn DJ. Directions for the use of intracardiac high-frequency ultrasound scanning for monitoring pediatric interventional catheterization procedures. Echocardiography, 1990, 7:465-468.
  23. Pandian NG et al. Three-dimensional and four-dimensional transesophageal echocardiographic imaging of the heart and aorta in humans using a computed tomographic imaging probe. Echocardiography, 1992, 9:677-687.
  24. Regmi PR, Pandey MR. Prevalence of rheumatic fever and rheumatic heart disease in school children of Kathmandu city. Indian Heart Journal, 1997, 49:518-520.
  25. Shah PM. Quantitative assessment of mitral regurgitation. Journal of the American College of Cardiology, 1989, 13:591-593.
  26. Yoshida K et al. Colour Doppler evaluation of valvular regurgitation in normal subjects. Circulation, 1988, 78:840-847.
  27. Lembo NJ et al. Mitral valve prolapse in patients with prior rheumatic fever. Circulation, 1988, 77:830-836.
  28. Brand A, Dollberg S, Keren A. The prevalence of valvular regurgitation in children with structurally normal hearts: a colour Doppler echocardiographic study. American Heart Journal, 1992, 123:177-180.
  29. Narula J, Chandrasekhar Y, Rohimtoola S. Diagnosis of acute rheumatic carditis: the echoes of change. Circulation, 1999, 100:1576-1581.
  30. Jae K.O, James BS, A.Jamil Tajik. The Echo Manual. Lippincott Williams & Wilkins, 2007, 206-218.
Үүнээс гадна судалгаа үргэлжлэх хугацааг тодорхойлох хэрэгтэй. Судалгааны асуултанд хариулт авахад хугацаа хангалттай байх ёстой. Жишээ нь, тархины танин мэдэх үйл ажиллагааг сайжруулдаг бэлдмэлийн судалгааг 2-4 долоо хоногт хийж дуусгах боломжгүй. Нөгөө талаас, эмнэлзүйн судалгаа бүр анагаахын туршилт байдаг тул судалгаанд оролцож буй өвчтөн эсвэл сайн дурын эрүүл хүмүүсийг нэмэлт эрсдэлд оруулахгүйн тулд судалгааны үргэлжлэх хугацаа хэт урт байж болохгүй.

Мөн судалгааг зогсох нөхцөлийг (stopping rules) тодорхой заасан байх ёстой. Энэ нь судалгааг явуулах хугацааг богиносгон цаг хугацаа, нөөцийг хэмнэх ач холбогдолтой. Мөн түүнчлэн хэрвээ судалгаагаар шинэ бэлдмэлийн сайн талууд батлагдсан бол зорилгот популяцийн өвчтөнд түүнийг аль болох хурдан хэрэглэх боломж олгох зорилго агуулдаг. Хэрэв судлагдаж буй эм үр дүнгүй эсвэл олон тооны гаж нөлөө үүсгэж байвал судалгааны субъектэд үргэлжлүүлэн хэрэглэх нь зүйд нийцэхгүй. Ийм нөхцөл үүсэхийг хянах зорилгоор эмнэлзүйн туршилтын явцад завсрын анализ хийхээр төлөвлөдөг [5].

### I àò áðéàééü í áí àèò í é ááééäéü á èöúñäüò áðåóóä

Francis Bacon 1620 онд: “Quod enim mavult homo verum est, id potius credit”-“хүн үнэн байгаасай гэж хүссэн зүйлдээ илүү дуртай итгэдэг” гэж хэлж байжээ. Хамгийн шударга судлаачид хүртэл тэр бүр хийж буй судалгааны үр дүнд нь зориудын бус хүчин зүйлс нөлөөлөхөөс тэр бүр зайлсхийж чаддаггүй [12]. Магадгүй, хэргийн учир хүний мөн чанарт байж болох юм. Paul Simon: “хүн сонсохыг хүссэнээ л сонсдог, бусад зүйлсийг үл тоодог” гэж бичсэн байдаг. Ийм зориудын бус нөлөөг будлиан буюу тогтмол гардаг алдаа гэдэг (bias) [9]. Энэ нөлөөг устгахын тулд харьцуулсан судалгаанд шинж чанарын хувьд нэг төрлийн хяналтын бүлэг бүрдүүлэхийн тулд, хэрэглэгдэж буй статистик сорилын зөв зүйтэй байдлыг хангахын тулд рандомизацийн (randomization) ба хаалттай судалгааны аргыг (blinding) хэрэглэдэг. Эдгээр аргуудыг хэрэглэснээр өвчтөнүүд бүлгүүдэд санамсаргүй хуваарилагдана (судлаач дараагийн өвчтөн ямар бүлэгт орохыг урьдчилан тааж чадахгүй). Үүнээс гадна судлаач ч тэр, өвчтөн ч тэр ямар бүлэгт орсноо, ямар эмчилгээ авч байгаагаа мэдэхгүй [9].

Статистик анализын бүх аргуудын үндсэнд санамсаргүй хуваарилалтын зарчим байдаг. Эмнэлзүйн судалгааны санамсаргүй хуваарилалт хийх арга анагаахын бус судалгаанаас (социологийн судалгаа, санал асуулга г.м.) зарчмын хувьд ялгаатай байна. Социологийн судалгаанд популяцийн бүлгийг хүн амын бэлэн нэрсээс санамсаргүй түүвэрлэх хэлбэрээр хийдэг. Эмнэлзүйн судалгаанд хүмүүсийг санамсаргүй сонгох

зарчмын оронд эмийг санамсаргүй заан хэрэглүүлэх зарчмыг ашигладаг.

Заримдаа судлаачид рандомизацийн мөн чанарын талаар буруу төсөөлөлтэй байдаг ба түүнийг харьцуулж буй бэлдмэлүүдийг хэрэглэх, өвчтөнг эмчилгээнээс бүлгүүдэд хуваарилах явцад санамсаргүй сонголтыг оруулах арга мэтээр ойлгодог. Энэ нь, магадгүй, "random" гэдэг уг "санамсаргүй" гэдэг утгыг агуулдагтай холбоотой байж болно. "Санамсаргүй" гэдэг нэр томъёо нь рандомизацийн хувьд статистикийн "унэн магадтай" гэсэн нэр томъёотой нягт холбоотой байдаг ба ямар нэгэн эмх замбараагүй, урьдчилан таах боломжгүй үйлдлийг илтгэдэгүй.

Рандомизацийг явуулахад гардаг хамгийн түгээмэл алдаа бол ямар нэгэн хүчин зүйлүүдээс, тухайлбал долоо хоногийн тэгш, сондгой өдөр, төрсөн он тэгш, сондгой байх, нэрийн эхний үсэг эгшиг эсвэл гийгүүлэгч байх г.м.-ээс хамааран эм хэрэглэх рандомизацийн дарааллыг тогтоодог. Хуваарилалтын энэ жишээ нь рандомизацийн арга биш юм. Жишээ нь, хэрэв долоо хоногийн тэгш өдөр байвал өвчтөн А бэлдмэллийг хэрэглэх 100% боломжтой, харин Б бэлдмэллийг хэрэглэх 0% боломжтой байна гэсэн уг. Энэ нь эмийг хэрэглэх боломж тэнцүү байх нөхцөлд харшилж байна.

Санамсаргүй, гэхдээ рандомизациилаагүй сонголтын жишээнд цагаан ба хар бөмбөлөг гарган авах сонгодог туршилтыг дурьдаж болно. Бид 10 өвчтөн А бэлдмэлээр (цагаан бөмбөлөг) болон Б бэлдмэлээр (хар бөмбөлөг) эмчлэхээр хоёр бүлэг болгох шаардлагатай гэж үзье. Хайрцганд 5 хар, 5 цагаан бөмбөлөг хийж, дараа нь хайрцгийг сэгсөрч, бөмбөлөгүүдийг нэг нэгээр нь гаргаж ээлжит өвчтөнд гаргасан бөмбөлөгийн өнгөнд тохиорох эмийг уухаар заана. Энэ үйл явц санамсаргүй гэдэгт эргэлзэх зүйлгүй боловч энэ нь рандомизаци биш юм. Хайрцагт цагаан ба хар бөмбөлөгийн тоо тэнцүү байх тохиодолд өвчтөнд аль нэг эмийг хэрэглэх боломж адил байсан. Бид хайрцагнаас, жишээ нь, нэг хар бөмбөлөг авсны дараа хайрцагт цагаан бөмбөлөг илүү олон үлдсэн тул Б бэлдмэллийг хэрэглэх боломж А бэлдмэллийг хэрэглэх боломжоос бага болно. Ийм учраас, бөмбөлөгийг санамсаргүй гарган авах явцад өвчтөнүүдэд судлагдаж буй эмийг хэрэглэх боломж өөр болно.

Рандомизацийн аргыг зөв хэрэгжүүлэх арга зам бол санамсаргүй тооны дарааллын үндсэн дээр рандомизацийн кодын дарааллыг гаргах явдал юм. Дурын санамсаргүй тоо өмнөх эсвэл дараагийн санамсаргүй тоонос үл хамааран энэ дарааллын аль нэг байранд орох адил боломжтой байна. Өнөө үед санамсаргүй тооны компьютерын үүсгүүр (генератор)-н тусламжтай санамсаргүй тооны хүснэгт зохиогджээ. Тэдээрийг өвчтөнг эмчилгээний бүлэгт хуваарилах рандомизацийн кодын нэрсийг бэлтгэхэд ашигладаг.

Зарим эрдэмтэд "рандомизаци" ба "хаалттай судалгаа" гэсэн үгүүдийг хийгдсэн эсвэл төлөвлөж буй шинжлэх ухааны ажлын нэрэнд оруулахдаа тэдгээрийг "жинхэнэ шинжлэх ухаан"-д замыг нээх шидэг үгс мэт ашигладаг. Харамсалтай нь, судлаачид өөрсдөө хүртэл эдгээр аргуудыг яах гэж хэрэглэж байгаа, хэрхэн зөв хэрэглэх вэ гэдгийг тэр бүр мэддэггүй. Иймээс анагаахын сэтгүүлд хэвлэгдсэн шинжлэх ухааны өгүүллийн зөвхөн 9-15%-д л рандомизацийн аргыг зөв зүйтэй бичсэн байдаг [10]. Энэхүү өгүүллийн хүрээнд рандомизаци болон хаалттай судалгааг бэлтгэх болон хэрэглэх талаар дэлгэрэнгүй зөвлөмж өгөх боломжгүй

юм. Харин тэдгээр нь их чухал бөгөөд боломжтой бол тэдгээрийг үргэлж хэрэглэж байхыг бид шургуу зөвлөж чадна. Рандомизациилаагүй, хяналтгүй, нээлттэй судалгааны үр дүнг зөвхөн хязгаарлагдмал тооны тохиодолд л авч үзэж болох ба үүнд сүрхий үндэслэл байх хэрэгтэй. FDA-аас 70-аад оноос рандомизаци болон хаалттай судалгааны аргыг эмийн бэлдмэлийн үр дүн ба аюулгүй байдлыг судлах эмнэлзүйн харьцуулсан судалгаанд зайлшгүй хэрэглэхийг шаардах болсон байна.

### Ñóäàëääà ã õàì õääääö õçí èé ó îî

Эмнэлзүйн ямар ч судалгаа үнэ цэнэтэй байх гол асуудал бол бүхий л популяцийн хувьд үнэн зөв байхад оршино. Дүгнэлтийг механик байдлаар зөөж болохгүй. Учир нь хэрвээ яг ийм судалгааг өөр бүлэг дээр явуулахад бага ялгаатай боловч өөр тоо гарна.

Янз бүрийн бүлэг өвчтөнд судалгаа хийснээр бид ерөнхий хэсгийн үнэлгээг олж авч чадна. Статистик анализын зорилго бол эмнэлзүйн судалгааны явцад гарсан үр дүн нийт популяцийн өвчтөний хувьд зөв зүйтэй гэдгийг батлахад оршино, өөрөөр хэлбэл, энэ судалгааны үр дүн ерөнхий үзүүлэлтийн үнэлгээ болно.

Судалгааны үр дүнг нийт зорилгот популяцид зөв зүйтэй шилжүүлэн үзэхэд хэдэн өвчтөн байх шаардлагатай вэ? Энэ нь "дүүрэн аз жаргалтай амьдрахад хэдэн төгрөг хэрэгтэй вэ?" гэсэн асуулттай төрөл нэг юм. Зарчмын хувьд их л байх тусам сайнхүмүүсийн тоо хэдийчинээ олон байна тэдийчинээ үр дүн зөв болно. Гэвч хэдийчинээ олон өвчтөн төлөвлөгднө, тэдийчинээ судалгаа үнэтэй, хугацаа нь урт, судалгааг удирдаж, цугласан материалд анализ хийхэд төвөгтэй болно.

Ийнхүү, нэг талаас судалгааны дүгнэлт үнэн магадтай байхыг хангахын тулд судалгаанд хангалттай олон тооны өвчтөн хамрагдах ёстой. Нөгөө талаас, энэ тоо хамгийн цөөн хангалттай байх ёстой. Энэ нь дээр өгүүлсэн зүйлүүдтэй ч холбоотой, мөн түүнчлэн өвчтөнд туршилтын шинэ эмчилгээ хэрэглэж байгаа бол ёс суртахуны ч асуудалтай холбоотой юм. Энэ тоог математик томъёо ашиглан олж болно. Түүний үзүүлэлтууд нь:

1. Аль нэг харьцуулж буй эмчилгээний аргуудын анхдагч сонирхож буй үзүүлэлтийн хүлээгдэж буй утга (primary or target variable, primary or target end-point)-P<sub>1</sub>
2. Харьцуулж буй эмчилгээний өөр аргын анхдагч сонирхож буй үзүүлэлтийн хүлээгдэж буй утга P<sub>2</sub>
3. I төрлийн алдааны утга (type I error) - α
4. II төрлийн алдааны утга (type II error) – β

### Óàðööööéé áóé ýì -ééäýüí èé áàðäööäüí áí õääääà ÷í õééööéé õççééüööé öö áá ÷ééööéé õééüööé öö áá

Эмнэлзүйн судалгаа хийхээр шийдвэрлэсэн эрдэмтдийн урмыг хамгийн их хугалдаг зүйл бол судалгааны хүлээгдэж буй үр дүн урьдчилан тодорхойлогдсон байдаг явдал юм. Судалгааны зорилго үүнийг батлах эсвэл үгүйсгэхэд оршдог боловч тоглоомын дүрэм ийм л байдаг.

Урьд өмнө хийгдсэн эмнэлзүйн болон эпидемиологийн судалгааны үндсэн дээр хяналтын бүлгийн эмчилгээний үр дүнг аль болох нарийн урьдчилан тооцсон байх ёстой. Зүрхний шигдээсээр өвдсэн хүмүүст антураны үр ашгийг плацеботай

харьцуулсан давхар хаалттай (double blind) судалгааг жишээ болгон авч үзье [13]. Судалгааны гол зорилго нь зүрхний шигдээстэй өвчтөнд нас барагт буурч байгаа нь эмнэлзүйн ач холбогдолтой эсэхийг тодорхойлоход оршиж байв. Сонирхож буй анхдагч үзүүлэлт нь зүрхний шигдээс болсноос нэг жил өнгөрсний дараа амьд үлдсэн хүмүүсийн тоо байв. Байсан мэдээллийг үндэслэн зүрхний шигдээсээр өвдсөн плацебо хэрэглэж байгаа хүмүүсийн 90% нь эхний 1 жилийн төгсгөлд амьд үлдэнэ гэсэн таамаглал байв.

Хяналтын бүлгийн хувьд анхдагч сонирхож буй үзүүлэлтийн утгыг урьдчилан тооцоход төвөггүй байдаг. Учир нь хяналтын бүлэгт хэрэглэж заншсан, эсвэл нэгэнт судлагдсан эмчилгээг хэрэглэж байгаа, эсвэл идэвхитэй эмчилгээ хэрэглэхгүй байгаа (плацебо бүлэг) өвчтөн ордог тул үр дүнг эрүүл мэндийн статистик мэдээллээс олж болно. Судалж буй эмийн хувьд сонирхох анхдагч үзүүлэлтийн утгыг урьдчилан олоход хамаагүй илүү төвөгтэй байдаг. Үүнийг олохын тулд хайгуулын судалгааны үр дүнг ашигладаг. Хайгуулын судалгааг бататгах судалгааг амжилттай төлөвлөх зорилгоор шинэ бэлдмэлийн шинж чанарыг урьдчилан мэдэх зорилгоор хийдэг. Үүнээс гадна тухайн судалгаанд олохыг таамаглаж байгаа эмнэлзүйн ач холбогдол бүхий ялгааны хэмжээг (effect size) олж болно. Энэ ялгаа үнэхээр эмнэлзүйн ач холбогдол бүхий байх ёстой. Жишээ нь, цусан дахь холестерины хэмжээг бууруулах чадварын 0,1%-ийн зөрөөг олохын тулд өргөн хүрээний судалгаа хийх нь утгагүй юм. Stuart Rostock-н бичсэнээр “олохгүй байхад маш харамсалтай байх тийм л эмнэлзүйн ач холбогдол бүхий хамгийн бага ялгааг тогтоо шаардлагатай” [4]. Дээр дурьдсан судалгааг төлөвлөхдөө хэрэв антуран үхлийг 2 дахин бууруулж байвал (өөрөөр хэлбэл, өвчтөний 95% нь судалгааны эхний нэг жилийн дараа амьд үлдэх ёстой) үр дүнг эмнэлзүйн ач холбогдолтой гэж үзэхээр тогтжээ.

#### I áà II ô °ðéééí áéäàà

Ямар ч хүн, тэр байтугай шүүгч, алдаа гаргаж болно. Хэрэв гэрчүүд олон байгаад тэдний мэдүүлгэнд зөрөө бага байвал сайн бөгөөд зөв шийдвэр гаргах магадлал өснө. Гэвч шүүгч хоёр төрлийн алдаа гаргаж болно: буруугүй хүнийг буруутанд тооцох, эсвэл буруутанг буруугүйд тооцох.

Буруугүй хүнийг буруутанд тооцох эхний төрлийн алдаа нь хэрэгтэнд эрсдэл авчирдаг. Гэмт хэрэгтэнг суплаж гаргах хоёрдугаар төрлийн алдаа нь нийгэмд эрсдэл авчирна. Эмнэлзүйн судалгаанд мөн л хоёр төрлийн алдааг авч үздэг. I төрлийн алдаа өвчтөний хувьд эрсдэлтэй: эмүүд хоорондоо ялгаатай гэсэн дүгнэлт хийх нь нийт өвчтөний зорилгот популяцийн хувьд буруу байна. Ийм алдаа гаргахад юуны өмнө үнэн хэрэгтээ үр дүнгүй эмийг илүү үр дүнтэй хэмээн хэрэглэж буй өвчтэй хүн хохирно.

II төрлийн алдаа эмийг үйлдвэрлэгч компанийн хувьд эрсдэлтэй: аль нэг эм нь илүү үр дүнтэй байхыг хоёр эм ялгаагүй гэсэн дүгнэлт хийх энэ тохиолдолд үнэхээр илүү байсан эмийг сайн гэж хүлээн зөвшөөрөлгүйгээр эм үйлдвэрлэгч компанийд хохирол

учруулна. II төрлийн алдаанд үндэслэн судалгааны хүч (power) гэсэн ойлголт гарч ирдэг.

Судалгааны хүч гэдэг нь II төрлийн алдаатай холбоотой хэмжээ юм (хэрэв  $\beta=0,2$  бол судалгааны хүч=0,8 байна, өөрөөр хэлбэл судалгааны хүч=1- $\beta$ ). Хэрэв бэлдмэлүүдийн хооронд үнэхээр ялгаа байгаа бол тэр нь статистик дүгнэлтээр батлагдана.

Статистик нэр томъёонд I төрлийн алдааг статистик ач холбогдлын түвшин гэж нэрлэдэг ба хувиар илэрхийлж “r” үсгээр тэмдэглэдэг. Харьцуулсан судалгааны үр дүнг бичихдээ “А болон Б бэлдмэлээр эмчилсэн бүлгүүдэд үр ашиг нь 87% ба 67% ( $p=0,042$ ) байгаа” гэдэг нь А ба Б бэлдмэлүүд үнэн магадтайгаар ялгаатай байна, судлаачид алдсан байх магадлал маш бага буюу 4,2% (анагаах ухаанд ийм байж болно) байна гэсэн үг юм.

Антураныг судлах судалгааг төлөвлөхдөө дээр өгүүлсэнчлэн антуран болон плацебогийн хооронд 5% ялгаа үнэхээр байгаа бол тэр нь статистик ач холбогдолтой ( $p<0,05$ ) байх магадлал багаар бодоход 90% байх ёстой. Үүний тулд судлагдаж буй бүлэг бүрт 578 хүн хамруулах ёстой.

Зөв дүгнэлт гарахад дээр дурьдсан статистик үндэслэлүүд, статистик анализ хийх төлөвлөгөөний хамт судалгааны протоколд тусгагдаж, дагаж мөрдөгдөх шаардлагатай.

#### I ï ï çé

1. Morgan D.D.V. Statistical thinking in clinical trials, Part I. Demystifying Statistics. Applied Clinical Trials, 1999, 8, (2), 32-34.
2. Senn S.J. Falsificationism and clinical trials. Statistical in Medicine, 1991, 10, 1679-1692.
3. Statistical Principles for Clinical Trials. ICH Harmonized Tripartite Guideline. Recommended for Adoption at Step 4 of the ICH Process on 5 February 1998 by the ICH Steering Committee.
4. Pocock S.J. Clinical Trials. A Practical Approach. John Wiley & Sons, 1997.
5. Chambers G.K., Fairbarn M.S. Clinical Trial Design. An introduction to good clinical trial design and the protection of human subjects. Applied Clinical trials, 1998, 7, (9), 60-66.
6. Hulley S.B., Cummings S.R. Designing Clinical Research. An Epidemiologic Approach. Williams & Wilkins. 1988.
7. Senn S.J. Crossover at the crossroads. Applied Clinical Trials, 1995, 4, (4), 24-31.
8. O'Donnell P. The emerging role of statisticians in clinical trials. Applied Clinical Trials, 1995, 4 (6), 48-52.
9. Двойрин В.В. Какие публикации заслуживают доверия практического врача? Международный журнал медицинской практики. 1997, 1, 17-19.
10. Schultz K.F. et al. The methodological quality of randomization as assessed from reports of trials in specialist and general medical journals. Online Journal Clinical Trials, 1995 (doc. №197).
11. Medical Research Council. Streptomycin treatment of pulmonary tuberculosis. British Medical Journal, 1948 (2), 769-782.
12. Woolding W.M. Planning Pharmaceutical Clinical Trials. Basic Statistical Principles. John Wiley & Sons, Inc. 1994.
13. Anturane Reinfarction Trial Research Group. Sulfuripyrazone in the prevention of cardiac death after myocardial infarction. N.Engl.J.Med. 1978, 298, 289-295.

## Í ÀÑÀÍ Ä ÖÐÝÄÑÄÈÉÍ ÖÓØ ÄÈÍ Ú Í ÀÐÅÍ ÖÈÍ ÈÉÍ ÖÀÐÖÌ ÀË a ÅxÍ -- Ä: Í Í Ï ØËÍ Ä Í, YÌ ×ÈËÄÝY

### (Öyâëýëèéí ãí éí )

Ä. È.-éí í ì ðí á, í .í þ óí -éí ýá  
 Yì Ø ÖÈÑ, Áí àäààöü í ñóðäööéü, Öðø äèí ú Yì áyä Ñóäëàëü í Öýí öèí  
 í í ÉÄÉÖÉ ÄÁÍ ÄÖÈEEÉÍ -í ÄÝÑ (ÖYÄEYEEÉÍ Õ Éí )

Ö. Äèëýäö ñàéöäö 1, Ö. Ääí áí èäí ð, Ä í þ óí áyðýé 1, í .í °í öð çðø éí 1, Á. í °í öáàò 1

'Áí àäààö Öäaaí ú Öðýýéý, Yðäýí Ø èí æðéäýý éé Öðå Ääáí ðàò í ðè  
 ²xéí ãýéö yé Äçðäèéí Yðççé í yí áèéí í ýäýé

## ADULT DIFFUSE PHARENCHYMAL LUNG DISEASES (DPLDS): DIAGNOSIS AND TREATMENT

D.Ichinnorov, I .I yunchimeg  
 HSUM, Medical School, Pulmonary Department

[dashtceren@yahoo.com](mailto:dashtceren@yahoo.com), [oyunah@yahoo.com](mailto:oyunah@yahoo.com)

The DPLDs are important, accounting for about 15% of respiratory practice. They comprise a very wide spectrum of pathologies, presentations, and outcomes. There is a serious paucity of evidence about the management of DPLDs, but the morbidity of the DPLDs themselves and the treatments available may be high, with potentially serious consequences therefore for mismanagement. There is concern that DPLDs may be poorly recognized and managed by nonspecialists. Respiratory specialists are the only group with appropriate training and skills to deal with the complexity of the diagnosis and management of these conditions. British Thoracic Society (BTS) Standards of Care Committee set up a sub-committee to formulate recommendations on DPLD management. Purpose of the recommendations: to support improved recognition, diagnosis, assessment, and treatment of patients with DPLD, to raise awareness of the importance of DPLDs, to provide an authoritative current literature review of DPLDs management, to provide practical, evidence and consensus based recommendations that will aid the development of clinical services for patients with DPLD. This article contains the summary of diagnosis and assessment of diffuse parenchymal lung disease, based on BTS recommendations on DPLD management.

Key words: diffuse pharechymal, lung disease, management

Pp. 47-51, Tables 9, Figure 1, References 17

### Äðº í öèé í éëä èò

Уушгины паренхим эдийг тархмалаар гэмтээдэг бүлэг өвчиний нэршилд. Уушгины паренхимиин тархмал өвчин (Diffuse Parenchimal Lung Disease), Уушгины тархмал өвчин (Diffuse Pulmonary Disease), Уушгины завсрын эдийн эмгэг (Interstitial Lung Disease), Цулцангийн эмгэг (Alveolar Filling Disease) зэрэг нэр томъёог хэрэглэсээр иржээ. Эдгээрийн дундаас дэлхий нийтэд Уушгины паренхимиин тархмал өвчин (УПТӨ) гэсэн нэр томъёог илүүтэй хэрэглэж байна.

Уушгины паренхим эдэд цулцангийн эпители, хялгасан судасны эндотели, тэдгээрийн хооронд байрлах завсрын эд, цус болон лимфийн судасны эргэн тойрны эдийг багтаан авч үздэг. Уушгины паренхим эдэд мөн түүнчлэн бронх, бронхиолын эргэн тойрны эд хамаарна.

УПТӨ нь уушгины эмчийн практикт 15% орчим тохиолддог чухал ач холбогдолтой эмгэг юм. Энэ бүлэгт бүтцийн янз бүрийн өөрчлөлтийн улмаас эмнэлзүйн янз бүрийн шинжүүдээр илрэдэг, тавилан нь харилцан адилгүй 200 гаруй өвчинг багтаан авч үздэг. Тэдгээрийн

дотор ховор тохиолддог, шалтгаан нь тодорхойгүй олон эмгэг бий. УПТӨ-ийг оношилж, шалтгааныг нь тогтоож, эмчилж, хянах мэргэжилтэн бол уушгины нарийн мэргэжлийн эмч нар юм. УПТӨ-ийг оношлох боломж сайжирсан хэдий ч эдгээр өвчтөн уушгины нарийн мэргэжлийн эмчид хугацаа алдаж хандсаны улмаас хүндэрдэг. Буруу эсвэл оройтож оношлогдох, эмчилгээ нь оройтох, үр дүнгүй байх зэрэгтэй холбоотой эдгээр өвчнүүд үхэлд хүргэж болно.

### Äí Ö -éé í í ï öëí ä í, yì ÷èëäý

Уушгины паренхимиин тархмал өвчинүүдийн үед эмнэлзүй, лаборатори, рентгенограмм, компьютерт томограмм, бронх-альвеолын лаваж болон морфологийн шинжилгээнд олон нийтлэг шинжүүд гардаг тул нэг бүлэг болгон авч үздэг байна.

### Äí æëäæ

Одоогоор УПТӨ-ий нийтээр хүлээн зөвшөөрсөн ангилал үгүй байна. Их Британий Цээжний нийгэмлэг (British Thoracic Society-BTS)-ээс гаргасан зөвлөмжинд УПТӨ-ийг эмнэлзүйн хувьд:

- Хурц (Хүснэгт 1).
- Хэсэг хугацаанд илэрдэг (илрэл нь хурцавтар байдаг, хүснэгт 2).
- Мэргэжлийн болон орчны таагүй нөлөөнөөс үүссэн (хүснэгт 3), эмнээс үүссэн (Хүснэгт 4).
- Системийн өвчин оношлогдсон өвчтөнд үүссэн (хүснэгт 5).
- Системийн өвчин оношлогдоогүй өвчтөнд үүссэн (хүснэгт 6) гэж ангилсан байдаг.

#### Хүснэгт 1. Ооðöö őyéáyðèéí ÕÍ Õ

Шалтгаан	Жишээ
Халдвэр	Нян (сүрьеэгийн савханцар мөн орно), вирус (жишээ нь улаан бурхан, салхин цэцэг), мөөгэнцэр (жишээ нь аспергиллэз, гистоплазмоз), дархлал дарангуйлагдсан хүмүүст үүссэн халдвэр ( <i>pneumocystis carinii</i> , <i>cryptomegalovirus</i> )
Харшил	Эм (жишээ нь пенициллин), мөөгэнцэр (жишээ нь аспергиллэз), шимэгч (жишээ нь <i>toxocara</i> )
Хор	Эм (жишээ нь эс хордуулах үйлчилгээтэй эмүүд, <i>amiodarone</i> ), хорт хий, утаа
Цусны урсгал алдагдах	Зүүн ховдлын дутагдал, эргэлдэх цусны хэмжээ ихсэх, бөөрний дутагдал
Васкулит, ушгины цус алдарт	Гудласчерьн хам шинж, шалтгаан тодорхойгүй гемосидероз, Бехчетын хам шинж, системийн чонон яр, Вегенерын гранулематоз, Churg-Strauss-н хам шинж
ARDS (acute respiratory distress syndrome)*	Гэмтэл, септицими
Шалтгаан тодорхойгүй	Ушгины шалтгаан тодорхойгүй хатууралт үрэвсэл ( <i>cryptogenic organizing pneumonia</i> ), ушгины шалтгаан тодорхойгүй эозинофили

\*Амьсгалын хурц дистресс хам шинж

#### Хүснэгт 2. Õýñüä öóääöàáí ä èéýðäýä ÕÍ Õ

	Жишээ
1	Ушгины эозинофилт үрэвсэл
2	Васкулит/ушгинд цус хурах
3	Churg-Strauss-н хам шинж
4	Гадаад шалтгаант харшилын альвеолит
5	Ушгины шалтгаан тодорхойгүй хатууралт үрэвсэл ( <i>cryptogenic organizing pneumonia</i> )

#### Хүснэгт 3. I ýðäýæééí öàáäçé í ° ööº ö, i ð-í û áí öéäéí i ï õññýí ÕÍ Õ

Шалтгаан	Үүсэх өвчин
1. Органик бус тоосонцор <ul style="list-style-type: none"> <li>Фиброз үүсгэдэг</li> <li>Фиброз үүсгэдэггүй</li> <li>Гранулематоз/фиброз үүсгэдэг</li> <li>Хавдар үүсгэдэг</li> </ul>	Асбестоз, силикоз, карбокониоз, хунд металл (кобальт), хөнгөн цагааны тоосонцроор үүсгэгдсэн пневмокониоз Сидероз (төмөр), станноз (тугалга), баритоз (барий) Бериллиоз Хүнцэл болон шөрмөсөн чулуугаар (асбестоз) үүсгэгдсэн пневмокониоз

2. Органик тоосонцор (гадаад шалтгаант харшилын альвеолит) <ul style="list-style-type: none"> <li>Нян</li> <li>Мөөгэнцэр</li> <li>Химиин бодис</li> </ul>	Фермчдын уушки (хадлан, хөрс, газар тариалан), багассоз Субероз (үйс), бяслагны үйлдвэрийн ажилчдын уушки, шувуучдын уушки
---	--

#### Хүснэгт 4. ÕÍ Õ -ééá õññýäýä ýí , ÕÍ ðò áí äèñ

Эмийн бүлэг	Эм
Халдварын эсрэг	Нитрофурантойн, сульфасалазин
Үрэвслийн эсрэг	Алтны бэлдмэл, пеницилламин, аспирин
Зүрх судасны	Амиодарон
Хими эмчилгээний	Блеомицин, метотрексат
Системийн чонон яр үүсгэдэг	Гидрапазин
Хориотой эмүүд	Героин, тальк
Бусад	Хүчилтөрөгч, туяа, хамрын тосон дусаалга

#### Хүснэгт 5. Ñèñðàí èéí ° á-í èé õää õññýí ÕÍ Õ

Өвчиний бүлэг	Өвчин
Холбогч эдийн системийн өвчин	Системийн склероз, системийн чонон яр, Шегрене хам шинж, анкилозд хүргэдэг спондиллит, ревматоид артрит, полимиозит, холбогч эдийн хавсарсан өвчин, Бехчетын өвчин
Хорт хавдар	Лимфом, жижиг голомтот үсэрхийлсэн хавдар, хавдрын лимфангит
Васкулит	Вегенерын гранулематоз, Гудласчерьн хам шинж, полиангит
Шалтгаан тодорхой бус	Саркоидоз
Удамшлын өвчин	Tuberose sclerosis, липид хуримтлагдах өвчин, нейрофиброматоз, Hermansky-Pudlak-н хам шинж
Бусад	Гэдэсний үрэвсэлт өвчин, ясны чөмөг шилжүүлэн суулгах мэс заслын дараах байдал, ушгины шалтгаан тодорхойгүй хатууралт үрэвсэл, Лангхансын аварга эст гистиоцитоз, ДОХ-ын халдвартай холбоотой эмгэг, амилоидоз, милиар сүрьеэ, ушгины эозинофили

#### Хүснэгт 6. Ñèñðàí èéí ° á-í èé ñ í ð öéí áäí áé ° á-ðº í á õññýí ÕÍ Õ

	Өвчин, эмгэгүүд
1	Ушгины анхдагч фиброз
2	Ушгины шалтгаан тодорхой бус хатууралт үрэвсэл
3	Цулцангийн протеиноз
4	Архаг аспираци
5	Цулцангийн микролитиаз
6	Лимфангиолейомиоматоз
8	Ушгины эозинофили
9	Саркоидоз
10	Лангхансын аварга эст гистиоцитоз
11	Бронхиолит
12	Ушгины венийн бөглөрөлтөт өвчин
13	Ушгины анхдагч гемосидероз
14	Бронх-альвеолын карцином

#### Í í ð öéí áäí

Áí àí í áç, áí äèò õçéúá

Юуны өмнө өвчин хурц, хэсэг зуурын, эсвэл архаг болохыг тогтоох хэрэгтэй. Цочмог өвчин 3 долоо

хоногоос бага хугацаанд үргэлжилдэг. Мөн урьд өмнө нь авахуулж байсан рентген зургийг үнэлэх хэрэгтэй. Рентген зурагт гарах өөрчлөлтүүд эмнэлзүйн шинжүүдээс өмнө илрэч болох тул энэ тохиолдолд өвчин архаг гэдгийг батална.

Рентген зурагт хэсэг хугацаанд эмгэг шинжүүд илрэч байх нь хүснэгт 2-т заасан эмгэг байгааг батална. Мэргэжлийн болон гадаад орчны таагүй нөлөө, аялал зэргийт тодруулан асуух хэрэгтэй. Шимэгчийн халдварын үед уушгины эозинофили үүсч болох тул аялалд явсан анамнезыг авах хэрэгтэй. Хавдар оношлогдсон, туяа эмчилгээ хийлгэсэн эсэхийг асуух нь зүйтэй. Архаг хэлбэрийн УПТӨ-ий үед хоёр талд жижиг цэврүүт нойтон хэржигнүүр сонсогдох, хаван хөөх эмчилгээ үр дүнтэй байх зэрэг нь зүрхний архаг дутагдал байгааг гэрчилнэ.

Гуурсан хоолойн багтраа, ринит байх нь Churg-Strauss хам шинжийн илрэл байж болно.

ДОХ-ын үед үүсч болох оппортунист халдвар, мөн түүнчлэн хавдар, бусад байдлууд цээжний рентген зураг дээр илэрсэн тархмал сүүдрийн шалтгаан нь байж болно. ДОХ үүсэхэд нөлөөлөх, тухайлбал бисексуаль, гомосексуаль байх, судсанд тария хийлгэсэн, цус, цусан бүтээгдэхүүн хийлгэсэн, зэжид нь ДОХ-ын халдвар илэрсэн байх, хамгаалалтгүй бэлгийн харьцаанд ордог зэрэг хүчин зүйлүүдийг тодруулах хэрэгтэй. Мөн дархлаа дарангуйлагдахад нөлөөлдөг бусад, тухайлбал эрхтэн шилжүүлэн суулгах мэс засалд орсон, дархлал дарангуйлах эм хэрэглэсэн, хавдар, холбогч эдийн системийн өвчин оношлогдсон зэргийг тодруулна.

Шалтгаан тодорхойгүй фиброзон альвеолит, саркоидозын үед удамшлын анамнез байх нь ховор. Лангхансын аварга эст гистиоцитоз, Гудпасчери хам шинжтэй хүмүүсийн ихэнх нь тамхи татдаг анамнестай байхад саркоидоз болон гадаад шалтгаант харшлын альвеолиттай хүмүүс нийт хүн амтай харьцуулахад тамхи бага татсан өгүүлэлтэй байдаг.

Мөн хэрэглэж байсан эмүүдийн талаар сайтар асуух хэрэгтэй.

Эмнэлзүйд ханиах, амьсгаадах зовиураас гадна цээжээр өвдөж болно. Цээжээр өвдөх нь системийн чонон яр өвчин (>50%), ревматоид артритын үед (>25%) гялтан үрэвссэнтэй холбоотой илрэдэг. Үүний зэрэгцээ tuberose sclerosis, нейрофиброматоз, лимфангiolейомиматоз, Лангхансын аварга эст гистиоцитозтай өвчтөнд (40%) пневмоторакс үүссэнтэй холбоотой байж болно.

Цустай цэр гарах нь (цустай цэр гарахгүй ч байж болно) васскулит, уушгинд цус хурахтай холбоотой илрэдэг. Эозинофилт үрэвслийн үед гуурсан хоолойн багтраа олонтаа хавсардаг ба энэ үед амьсгал боогдож бачуурдаг.

Чагнахад хоёр уушгинд шажигнуур сонсогдох нь шалтгаан тодорхойгүй фиброзон альвеолитын 90%-д, холбогч эдийн системийн өвчиний үеийн фиброзон альвеолит, асбестозын 60%-д, саркоидоз, гадаад шалтгаант харшлын альвеолитын 25-аас бага хувьд, Лангхансын аварга эст гистиоцитозын 10%-д тус тус илрэдэг.

Бөмбөрийн цохиурын шинж шалтгаан тодорхойгүй фиброзон альвеолитын 49-66%-д, ревматоид артритын 75%-д, асбестозын 43%-д тус тус тодорхойлогддог.

УПТӨ-ий үед ерөнхий шинжүүд тод илрэх боловч өвөрмөц бус шинжтэй байдаг. Биеийн жин эрс буурах, шалтгаан тодорхой бус суулгах, лимфийн

булчирхайнууд томрох, амны хөндийн кадидоз илрэх, Капошийн сарком гарах нь ДОХ-ын шинжүүд байж болно (Хүснэгт 7).

#### Хүснэгт 7. Аðº í ðèé ø èí æççä áà Öí Öº

Ерөнхий шинжүүд	Эмгэг
Халууралт	Халдвэр, эозинофилт үрэвсэл, эмийн харшил, васскулит, холбогч эдийн системийн өвчнүүд, уушгины шалтгаан тодорхой бус хатууралт үрэвсэл, гадаад шалтгаант харшлын альвеолит, саркоидоз, ДОХ, лимфом, хавдрын лимфангит
Арьсны тууралт	Саркоидоз, холбогч эдийн системийн өвчнүүд, васскулит
Склерит	Саркоидоз, холбогч эдийн системийн өвчнүүд, васскулит
Кератоконъюнктивит	Шегрены хам шинж
Увеит	Саркоидоз, Бехчетын хам шинж, анкилозд хүргэдэг спондиллит
Raynaud-н шинж	Системийн склероз, шалтгаан тодорхойгүй фиброзон альвеолит
Системийн артерийн гипертензи	Холбогч эдийн системийн өвчин, Гудласчери хам шинж, васскулит
Нулимс, шүлсний булчирхайн гэмтэл	Саркоидоз, Шегрены хам шинж
Лимфаденопати	Саркоидоз, лимфом, хавдрын лимфангит, ДОХ
Перикардит	Холбогч эдийн системийн өвчин, хавдрын лимфангит, лимфом, васскулит
Гепатосплениомегали	Саркоидоз, Лангхансын аварга эст гистиоцитоз, холбогч эдийн системийн өвчин, амилоидоз
Артрит	Холбогч эдийн системийн өвчин, васскулит, саркоидоз, Гудласчери хам шинж
Гематури	Васскулит
Амны хөндийн кандидоз	Дархлаа сулрах (юуны өмнө ДОХ)

#### Ëàáî ðàöi ðèéí ø èí æèëäý

Эхний ээлжинд цусны дэлгэрэнгүй шинжилгээ болон шээсний шинжилгээ хийж, цусанд үлдэгдэл азот, электролит, креатинин, элэгний үйл ажиллагаа, аутоантител (antinuclear antigen-ANA, rheumatoid factor-RF) тодорхойлдог. Васскулит байж магадгүй гэж үзвэл ANCA (antineutrophil cytoplasmic antibody), anti-GBM (anti-gliomerular basement membrane antibody) тодорхойлох хэрэгтэй. Саркоидозын 11-18%-д антиотензин хувиргач фермент (АХФ) ихэссэн байдаг. АХФ-ын хэмжээ ихсэх шинжийн мэдрэг чанар 60%, өвөрмөц чанар бага байдаг. Иймд, энэ нь зайлшгүй хийгдэх шинжилгээ биш юм.

Гадаад шалтгаант харшлын альвеолитын үед гадаад орчны аллергены эсрэг антител үүссэн байдгийг (avian proteins, mycopolysporafaeni, thermoactinomyces vulgaris) тодорхойлж болно.

Мөн ДОХ-ын вирусийг илрүүлэх шинжилгээ, саркоидозын үед эхокардиографи, системийн склерозын үед зүрхний цахилгаан бичлэг хийх хэрэгтэй.

#### Äððñéýé ï í í ø èí á í

УПТӨ-ий үед эхний ээлжинд хийгдэх шинжилгээ бол өндөр чанарын рентгенографи юм. Анамнез,

эмнэлзүй, лабораторийн шинжилгээний үр дүн зэргийг харгалzan рентген шинжилгээнд гарах өвөрмөц өөрчлөлтийг үндэслэн зарим, тухайлбал саркоидоз, мэргэжлээс шалтгаалах өвчин, уушгины эозинофили зэрэг өвчний оношийг зөв тогтоо боломжтой. Ихэнх өвчний хувьд цээжний рентген зурагт өвөрмөц бус өөрчлөлтүүд илэрдэг. Цөөн тохиолдолд УПТӨ-ий онош морфологийн шинжилгээнд батлагдсан байхад цээжний рентгенограмм хэвийн байж болно. УПТӨ-ийг оношлоход хамгийн оновчтой киловолтажийн (kVp) дээд хэмжээ нь 125 байдаг.

#### HRCT

Зарим үед цээжний рентгенограмм хэвийн байх тохиолдолд HRCT-д эмгэг өөрчлөлтүүд илэрдэг. HRCT-ийн УПТӨ-ийг илрүүлэх өвөрмөц чанар 94% байхад, цээжний рентгенограммын хувьд энэ үзүүлэлт 80% байна. УПТӨ-ийг үед HRCT-д гарч болох эмгэг өөрчлөлтийг хүснэгт 8-д харууллаа.

**Хүснэгт 8. Øø ñéí û i àðáí ðèi èéí òàðöi àë çàðèi  
º à÷í èé ïåå HRCT-ä èëðóøº àº ði º ö  
ø èí æçä**

Өвчин	HRCT-д илрэх шинжүүд
Шалтгаан тодорхойгүй фиброзон альвеолит	Уушгины зах, доод хэсэгт сүүдэр гарах Зураасан сүүдэр, зөгийн үүрийн шинж нь ихэвчлэн бүүдгэр шилний шинж, гурсан хоолойн тэлэгдлэтий хавсарна
Асбестоз	Шалтгаан тодорхойгүй фиброзон альвеолиттай адил, гол төлөв гялтангийн доор байрласан байна Зураасан-зангилаат сүүдэр гарсан, дэлбэнцэр хоорондын таславч зузаарсан, зөгийн үүрийн шинж илэрсэн байна Гялтан гэмтсэн байх нь олонтаа
Саркоидоз	Эмгэг өөрчлөлт уушгины талбайн дээд, дунд хэсэгт байрлах хандлагатай Гуурсан хоолой, судасны эргэн тойрон эд, гялтан дор байрлах жижиг зангилаат өөрчлөлтүүд тодорхойлогдоно Хожим нь том хэмжээний нягт сүүдэр үүсч болно Угийн лимфийн булчирхайнүүд томорсон байна
Хавдрын лимфангит	Дэлбэнцэр хоорондын таславч жигд бус зузаарсан Гуурсан хоолойн эргэн тойрны эд зузаарсан Дэлбэн хоорондын таславч зузаарсан Уушгины макробутэц алдагдаагүй байна
Гадаад шалтгаант харшлын альвеолит	Бүүдгэр шилний шинж Дэлбэнцрийн төвд байрлах жижиг зангилаат өөрчлөлт Амьсгал гаргах үед гуурсан хоолойн агаар дамжилт саадтай байна Хожуу үед жигд бус зураасан сүүдэр гарах нь фиброзтай холбоотой
Лангхансын аварга эст гистиоцитоз	Зангилаат болон уулинхайт өөрчлөлт Пневмоторакс байж болно
Лимфангиолей-омиоматоз	Уушгины эрүүл эдээр хүрээлгэдсэн нимгэн ханатай хөндийнүүд тодорхойлогддог

#### º à÷í èé èäýâðééä ãi ðöi ééï õ í ý

HRCT-д өвчний идэвхийг тодорхойлж болно. “Бүүдгэр шилний шинж” давамгайлах нь цочмог альвеолитыг (тухайлбал гадаад шалтгаант харшлын альвеолит, уушгины завсрын эдийн дескваматив үрэвслийн үед) илтгэнэ. “Бүүдгэр шилний шинж” илрэхийн зэрэгцээ гуурсан хоолойн тэлэгдэл, зураасан сүүдэр илрэх нь фиброзын шинж юм.

Мөн HRCT өвчний явц, эмчилгээний үр дүнг тодорхойлоход ач холбогдолтой.

HRCT-ийн дүгнэлтийг гаргахдаа эмнэлзүйн болон лабораторийн шинжүүдийг харгалzan үздэг.

#### Øø ãeí û ȝéé àæëëéäàää ãi ðöi ééï õ í ý

Өвчний эхэн үед гадаад амьсгалын үйл ажиллагааны шинжилгээнд эмгэг өөрчлөлт илрэхгүй байж болно. УПТӨ-ийн оношлогоонд гадаад амьсгалын үйл ажиллагааны шинжилгээний оношлогооны ач холбогдол хязгаарлагдмал юм. Ихэвчлэн рестриктив хэлбэрийн агааржилтын дутагдал илэрч, диффузийн багтаамж буурсан байна.

#### Àði í õ-àëüââi ëü í ëàâàæ

Бронх-альвеолын лаваж (БАЛ) нь УПТӨ-ийг оношло, өвчний идэвхи, тавиланг тодорхойлох зорилгоор 20 гаруй жил хэрэглэгдсээр иржээ. Органик бус тоосонцроор үүсгэгдсэн мэргэжлээс шалтгаалах өвчин, оппортунист нянгийн халдварт, хавдар сэжиглэсэн тохиолдолд, эмээр үүсгэгдсэн уушгины өвчин, цулцангийн протеиноз, Лангхансын аварга эст гистиоцитоз зэрэг өвчний үед БАЛ-ын шинжилгээ оношийн ач холбогдолтой байж болно.

ДОХ-ын халдвартын үед, ялангуяа пневмоцистээр үүсгэгдсэн үрэвслийн үед БАЛ нь богино хугацаанд оношийг тодорхойлох (70-90%) ач холбогдолтой. БАЛ-ын шингэнд гранулоцитоз, ялангуяа нейтрофилэз, эозинофили тодорхойлогоо нь фиброзон альвеолит дангаар байгаа эсвэл системийн коллагеноз, асбестоз, амьсгалын цочмог дистресс хам шинж (ARDS) зэрэг эмгэгтэй хамт явагдаж байх тохиолдолд онцлог байдаг. Лимфоцитоз тодорхойлогдох нь гранулематоз өвчин, эмээс үүдэлтэй УПТӨ-ийг үед тохиолддог. Үрэвслийн эсүүд давамгайлах нь өвчний тавиланг тодорхойлох үзүүлэлт юм.

#### ⁹⁹Tc-diethylenetriamine penta-acetate (DTPA)-í ÿëäàðäéð ãi ãi ðöi ééï õ

⁹⁹Tc-DTPA аэрозолийн ялгаралт нь уушгины эпителийн нэвчимхий чанарыг илэрхийлдэг. Фиброзон альвеолит, дерматомиозит, гадаад шалтгаант харшлын альвеолит, саркоидоз, тяяны үрэвсэл, пневмокониоз зэрэг өвчиний үед уушгины паренхимийн үрэвслийн улмаас ⁹⁹Tc-DTPA ялгаралт ихэнэ. Энэ нь үрэвслийг заадаг мэдрэг үзүүлэлт ба энэ үзүүлэлт хэвийн байх тохиолдолд үрэвсэл байхгүй гэж үздэг.

Их Британий цээжний нийгэмлэгээс УПТӨ-ийг оношлох, эмчлэх удирдамжийг боловсруулан гаргасан байна. Энэхүү удирдамжинд УПТӨ-ийг оношлоход эмнэлзүй, лаборатори, рентген, уушгины үйл ажиллагаа болон морфологийн шинжүүдийн ач холбогдлыг нотолгооны түвшингийн (Хүснэгт 9, 10) зэргээр үнэлсэн байдаг.

## Хүснэгт 9. Í î ãëäî í ï û òðâø èí

Түвшин	Нотолгооны хэлбэр
I a	Рандомизацчилагдсан хяналттай судалгааны мета-анализын үр дүнгээр нотлогдсон
I b	Дор хаяж нэг рандомизацчилагдсан хяналттай судалгаагаар нотлогдсон
II a	Дор хаяж нэг зөв зохин байгуулсан рандомизацчилагдаагүй хяналттай судалгаагаар нотлогдсон
II b	Дор хаяж нэг зөв зохион байгуулсан туршилттай судалгаагаар нотлогдсон
III	Зөв зохион байгуулсан харьцуулсан корреляцийн эсвэл тохиолдол-хяналтын судалгаагаар батлагдсан
IV	Нотолгоог экспертын комиссын тайлан (нэр хүндтэй судлаачдын санал ба/эсвэл эмнэлзүйн туршлага)-аас авсан

## Хүснэгт 10. Çº âëº ï æèéí ò¿âø èí

Түвшин	Зөвлөмжийн түвшин
A (түвшин Ia, Ib)	Дор хаяж нэг рандомизацчилагдсан хяналттай судалгаагаар нотлогдсон
B (түвшин IIa, IIb, III)	Зөв зохион байгуулсан харьцуулсан корреляцийн эсвэл тохиолдол-хяналтын судалгаагаар батлагдсан
C (түвшин IV)	Нотолгоог экспертийн комиссын тайлан (нэр хүндтэй судлаачдын санал ба/эсвэл эмнэлзүйн туршлага) аас авсан

Yì í yëççéí ø èí æççä

- Анамнез бүрэн авах нь маш чухал. Ялангуяа холбогч эдийн системийн өвчин, мэргэжлийн таагуй нөлөө, орчны бохирдол, аялал, удамшил, тамхидалт, дархлал дарангуйлагдах шалтгаан (ДОХ, бусад), хэрэглэсэн эм байгаа эсэхийг анхаарах (С).
  - Амьсгалын эрхтэн тогтолцоо, зүрх судасны эрхтэн тогтолцоо, бодит үзлэг, халууралт, зүрх судасны эрхтэн тогтолцоо, арьсны түуралт, нүдний шинжүүд, гепатосplenомегали, артрит, шээсний өөрчлөлт (С).
  - Эхний ээлжинд цусны эсүүд, зозинофилын тоо, гематокрит, ЭТХ, цусны электролит, кальци, улдэгдэл азот, креатинин, элэгний үйл ажиллагаа, автоантителын (antinuclear antigen, Reumatoid factor) титр тодорхойлох хэрэгтэй. Эмнэлзүйд илэрч буй шинжүүдээс хамааран цаашид хийх шинжилгээг (ANCA-antineutrophil cytoplasmic antibody, anti-GBM-glomerular basement membrane antibody, уургууд (precipitins), зүрхний цахилгаан бичлэг, эхокардиографи г.м.) төлөвлөж болно (С).
  - Урьд өмнө нь авахуулсан рентген зураг, эсвэл дүгнэлт ач холбогдолтой байж болно (С).

Ä;ðñëýë î í î ø ëî aî î í û ø èí æ; ;ä

- УПТӨ-тэй хүмүүсийн рентген зураг, компьютерт томограммд илрэх шинжүүдийг уушгины эмч болон радиолог эмч нар хамтран тогтмол хянаж, үнэлж байх (С).
  - Радиолог эмч цээжний рентген зураг дээр УПТӨ байж болзошгүй гэж үзвэл өвчтөнд уушгины эмчид

хандахыг зөвлөх хэрэгтэй (С).

- Эмнэлзүйн шинжүүд болон цээжний рентген зургийг үндэслэн оношийг өндөр магадлалтай тавьсан бол уушгины анхдагч фиброзаас бусад тохиолдолд HRCT хийх шаардлагай байж болно (С).
  - Эмнэлзүйн шинжүүд болон цээжний рентген зургийг үндэслэн оношийг тодорхойлох боломжгүй бол HRCT, биопсийг төлөвлөх нь зүйтэй (С).
  - Цээжний рентгенограмм хэвийн хүмүүст HRCT дээр уушгины паренхим эдийн тархмал өөрчлөлт илэрч болно (В).
  - HRCT-д гарсан уушгины паренхим эдийн тархмал өөрчлөлтийг үндэслэн биопси авах газрыг сонгох нь зүйтэй (В).
  - Шалтгаан тодорхой бус фиброзон альвеолитын үед HRCT нь онош тавихаас гадна өвчний тавилан, үе шатыг тогтоо ач холбогдолтой (В).
  - HRCT-г техникийн зохих түвшинд хийх хэрэгтэй. 7 хоногт дор хаяж нэг удаа phantom ашиглан өндөр чанарын дурслэл өгч буйг шалгаж байвал зохино (C).
  - Боломжтой үед 20 мм-ийн зйттай зүслэг, туяаны бага дозыг ашиглаж байх хэрэгтэй (C).
  - HRCT хийж буй мэргэжилтэн аппарат, шинжилгээний үр ашиг, оношлогооны боломжийг сайн мэддэг байх хэрэгтэй. Дүрслэл оношлогооны тасагт дор хаяж нэг радиолог эмч цээжний рентген зураг, компьютерт томограммын дүгнэлтээр мэргэшсэн байвал зохино (C).
  - DTPA (<sup>99m</sup>Tc-diethylenetriamine penta-acetate) scanning нь УПТӨ-ий оношлогоонд хэрэглэгдэж байгаа боловч одоогоор хүн бүрт хийх шинжилгээнд оруулаагүй байна (C).
  - Ga-scanning нь УПТӨ-ий үед хийхийг зөвлөөгүй боловч уушгины бус саркоидозын оношлогоонд ач холбогдолтой (C).

**Ойр үеийн үзүүлэлтүүдийн төслийн төрөл**

  - Ихэнх өвчтөнд рестриктив хэлбэрийн амьсгалын дутагдал тодорхойлогддог ч уушгины паренхимиийн зарим өвчний үед амьсгалын замын бөглөрлийн шинжүүд илэрдэг. Амьсгалын замын бөглөрлийн шинжүүд байх нь УПТӨ-ийг үүгүйсгэхгүй (B).
  - Хамгийн багаар бодоход спирометри болон уушгины диффузийн багтаамжийг ( $D_{LCO}$ ) тодорхойлох шаардлагатай. Уушгины амьдралын багтаамж (VC) ба  $D_{LCO}$  нь өвчний хүндийн зэрэг, тавилан, эмчилгээний үр дүнг тодорхойлох үндсэн үзүүлэлт юм (B).
  - HRCT, уушгины үйл ажиллагааны сорил хэвийн байгаа өвчтөнд УПТӨ-ийг сэжиглэж байвал уушгины үйл ажиллагааны ачаалалтай сорил хийж болно. Энэ нь амьсгаадалт илэрсэн, УПТӨ-ийг илтгэх тод шалгуур үзүүлэлт байхгүй байгаа өвчтөнд УПТӨ-ийг оношлох, эсвэл үгүйсгэхэд тусалж болно (C).
  - Уушгины үйл ажиллагааны ачаалалтай сорил хийх техникийг боловсронгуй болгож, эмнэлзүйн хамгийн ач холбогдолтой үзүүлэлтийг тогтоох хэрэгтэй (C).

**Адил үеийн үзүүлэлтүүдийн төслийн төрөл**

  - Уушгины хорт хавдар, оппортунист нянгаар үүсгэгдсэн халдвэр, мэргэжлээс шалтгаалах өвчин, цулцангийн протеиноз сэжиглэсэн тохиолдолд бронх-альвеолын лаваж (БАЛ) хийх заалттай (B).
  - УПТӨ-ийг сэжиглэсэн тохиолдолд БАЛ хийх нь зүйтэй (B).
  - БАЛ-ыг хэвлэлд нийтлэгдсэн зөвлөмжийн дагуу

хийнэ (С).

- БАЛ-ын шингэний цитограммын эмнэлзүйн ач холбогдлыг тогтоох хэрэгтэй (С).  
Аёї i ñèéí ø éé æéëýí èé àðåóðá, áðò öééí ýí áýá  
oo ð-éº èó
- УПТӨ-ий үед биопсийн шинжилгээг дүгнэхдээ уушгины эмч, морфолог эмч нар хамтарч ажиллах хэрэгтэй (С).
- Эмнэлзүй, ренттен шинжүүдийн үндсэн дээр УПТӨ-ий шалтгаан оношлогоогүй, өвчтөнг эмчилгээнд оруулах талаар шийдвэр гаргах боломжгүй үед өвчтөнд хориглох заалт угүй бол эдийн шинжилгээ хийнэ (В).
- Жижиг хэмжээний эд онош тавихад хангалттай байх (саркоидоз, хорт хавдар) үед трансбронхиаль уушгины биопси (ТБУБ)-г сонгоно (В).
- Саркоидоз сэжиглэсэн тохиолдолд, ялангуяа ТБУБ авах зохистой газар тодорхойгүй байх үед эндобронхиаль биопси авах нь зүйтэй (С).
- ТБУБ-г дурангийн туршлагатай мэргэжилтэн эсвэл энэ мэргэжилд суралцаж байгаа бол туршлагатай эмчийн хяналтан дор хийнэ (С).
- ТБУБ-ийг хэвлэгдсэн зөвлөмжийн дагуу гүйцэтгэнэ (С).
- ТБУБ-ийг цусны бүлэгнэлт, тромбоцитын тоо хэвийн байх тохиолдолд хийнэ. Нэг уушгиаас 4-6 эд авна (В).
- Морфологийн дүгнэлтийг эмнэлзүйн шинжүүдтэй нь уялдуулан тавина. Гистологийн шинжилгээнд эмгэг өөрчлөлт илрэхгүй байх, эсвэл үрэвсэл, фиброзын өөрчлөлт тодорхойлогдвол онош тодроогүй гэж үзнэ (В).
- Шалтгаан тодорхойгүй фиброзон альвеолит, васкулит, лимфом, лимфангиолейомиоматоз (lymphangioleiomytosis-LAM), Лангханс эст гистиоцитоз (Langhans' cell histiocytosis-LCH)-н үед уушгины нээлттэй биопси (open lung biopsy-OLB), видеоторакоскопийн (video-assisted thoracoscopy-VATS) биопси хийж гистологийн оношийг тогтоох нь зүйтэй (В).
- Уушгины нээлттэй биопси, видеоторакоскопийн биопсийн үр дүн адил. Өвчтөний биеийн байдал харьцангуй сайн байгаа үед хоёрдахь аргыг, аппаратын амьсгалтай байгаа өвчтөнд нэг дэх аргыг тус тус сонгодог (В).
- ТБУБ, уушгины нээлттэй биопси, видеоторакоскопийн биопсийн шинжилгээнд өвөрмөц бус үрэвсэл, эсвэл фиброзын шинжүүд гарч, шалтгаан тодорхой бус фиброзон альвеолитын өвөрмөц шинжүүд тодорхойлогдохгүй бол онош тогтоогдоогүй гэж үзнэ (В).
- HRCT нь уушгины нээлттэй биопси, видеоторакоскопийн биопси авах газрыг сонгоход тусална (В).
- Трансторакаль биопсийг УПТӨ-ий үед хэрэглэхийг зөвлөдөггүй. Харин захын байрлалтай нэвчдэсийн үед энэ шинжилгээг сонгож болно (В).
- Боломжтой бол УПТӨ-тэй хүнээс авсан эдийн шинжилгээг амьсгалын замын эмгэгээр туршлагажсан дадлагатай морфолог эмч харах нь зүйтэй (С).

Зураг 1 дээр харуулсан оношлогооны алгоритмыг УПТӨ-ий оношлогоонд ашиглаж болно.

Их Британий цээжний нийгэмлэгээс гаргасан УПТӨ-ий оношлогоо, эмчилгээний удирдамжид мөн түүнчлэн эмчилгээний аргуудын үр дүнгийн нотолгооны түвшинг

үнэлсэн байна.

Ӵ Ö -éé ýí ðééäý

Ø àéò àäàí ò i àí ððí é áóñô èáðí ç í àéüââí èèò ú í  
ýí ðééäý

- Ахныхы эмчилгээнд преднизолон 0.5 мг/кг+азатиоприн 2-3 мг/кг тунгаар хэрэглэх (В).
- Сарын дараа эмчилгээний үр дүн (Уушгины амьдралын багтаамж/уушгины диффузийн багтаамж (VC/D<sub>LCO</sub>) 10-15% ихэссэн эсвэл буурсан)-г хянах хэрэгтэй
- Преднизолон эмчилгээ эхний 1 сард үр дүнгүй байж болно. Гэвч 3 сараас удаан хугацаанд преднизолон эмчилгээ хийх нь өвчний явцыг тогтвортыхиход нелөөлдөг (С).
- Преднизолон эмчилгээ үр дүнгүй байх, гаж нелөө гарах, хэрэглэх боломжгүй байх тохиолдолд азатиоприныг дангаар нь хэрэглэж болно (С).
- Азатиоприн тохиromжгүй бол циклофосфамидыг 1-2 мг/кг-аар хэрэглэнэ (С).
- Удаан хугацааны преднизолон эмчилгээ: преднизолоныг 40 мг-р эхэлж 7 хоног бүр 5 мг-р 20 мг хүртэл бууруулна (С). Цаашид биеийн байдал тогтвортой байвал сард 5 мг-р бууруулж хоногт 10 мг-р 1 жил уулгана (С). Дор хаяж 3 сар тутамд 1 удаа VC/T<sub>LCO</sub>-г хянаж байх хэрэгтэй (В).
- Богино хугацааны преднизолон эмчилгээ: 7 хоногт 10 мг-р 10 мг/хоногт хүртэл бууруулна (С).
- Преднизолон болон дархлал дарангуйлагдах эмүүд тохиорхгүй бол өөр эмчилгээг сонгоно (С).
- “Бүүдгэр шилний шинж” гарсан үед эхний эзлжинд преднизолоныг дангаар хэрэглэх нь зүйтэй (В). Өвчтөний биеийн байдал хүнд үед метилпреднизолоныг судсандаа тарихаар хэрэглэнэ (С).
- Эхний эмчилгээ үр дүнгүй байх тохиолдолд өвчний эрт үед уушки шилжүүлэн суулгах мэс засал хийнэ (С).

Ñéñöàí èéí ïééäðí ç í àéééí ô èáðí ç í  
àéüââí èéðí í ýí ðééäý


- Эхний эзлжинд циклофосфамидыг преднизолоны бага тунтай хавсан хэрэглэнэ (В).

Ðáàí àö àä àðððéòí í àéééí Ö Ö -éé ýí ðééäý

- Шалтгаан тодорхой бус фиброзон альвеолитын эмчилгээтэй адил (С).
- Шалтгаан тодорхой бус хатууралт үрэвсэл, ревматоид артритын үед преднизолон эмчилгээ үр дунтэй (В).

Óð àéí û ñäðé èäí ç í ýí ðééäý

- Уушкины саркоидоз оношлогоогсон ихэнх өвчтөнд эмчилгээ хийх шаардлагагүй (В).
- Саркоидозын I үед кортикостероид эмчилгээ хийх шаардлага ховор байдаг (В) боловч ханиах, үе меч өвдөх болон бусад эрхтэн гэмтсэн үед кортикостероид хэрэглэнэ (С).
- Цээжний рентгенограммд уушкинд эмгэг өөрчлөлт илэрсэн, өвчтөн зовиургүй байгаа үед эмчилгээг яаралтай эхлэх шаардлагагүй, б сарын туршид ажиглаж болно. Энэ үед ихэнх өвчтөний рентгенограммд сайжрал гардаг, зовиур илэрсэн өвчтөнд кортикостероид эмчилгээ эхэлнэ (В).
- Преднизолоны тун 0.5 мг/кг/хоногт (В). Дээд тунгаар дор хаяж 4 долоо хоног ууж, цаашид аажим буулгасаар барих тунд (ихэвчлэн 5-15 мг/хоногт) хүргэнэ. Энэ тунгаар хэдэн 7 хоног уулгана (С).



Çöödää 1. Ör Ör -eeääí í í ø ëí ð àääí ðèò i .

- \* Хоёр талын угийн лимфаденопати±зангилаат эритем, мэргэжлийн таагүй нөхцөл болон цээжний рентгенограмм дээр өөрчлөлт илэрсэн, уушгиньы эозинофили, зарим эмүүд, үсэрхийлсэн хавдар;
- \*\* Саркоидоз, халдварт, хавдар, уушгиньы хатууралт үрэвсэл;
- \*\*\* Фиброзон альвеолит, Лангхансын аварга эст гистиоцитоз, лимфангиолейомиоматоз;
- \*\*\*\* HRCT-ээр өндөр магадлалтайгаар дараах оношийг тавьж болно: фиброзон альвеолит/асбестоз, лимфээр тархсан хавдар, саркоидоз, гадаад шалтгаант хурцавтар альвеолит, силикоз, лимфангиолейомиоматоз, цулцангийн протеиноз, Лангхансын аварга эст гистиоцитоз.

<sup>1</sup>-бөөмийн эсрэг эсрэгбие, <sup>2</sup>-ревматоид фактор, <sup>3</sup>-уушгиньы амьдралын багтаамж/уушгиньы диффузийн багтаамж, <sup>4</sup>-трансбронхиаль уушгиньи биопси, <sup>5</sup>-бронх-альвеолын лаваж.

Эмчилгээний үр дүнг эмнэлзүй, рентген, гадаад амьсгалын үйл ажиллагааны шинжилгээгээр хянана ( $VC$ ,  $T_{LCO}$ ) (B).

- Ингаляцийн кортикостероидыг эхний ээлжинд сонгохгүй (A). Будесонидыг шинж тэмдэг бага илэрсэн үед эсвэл уух преднизолоны тунг багасгах зорилгоор хавсрсан хэрэглэж болно (C).
- Бусад үрэвслийн эсрэг эмүүд уушгины саркоидозын үед удаан хэрэглэхэд зохимжгүй, гаж нөлөө ихтэй (B). Эмчилгээнд делагил эсвэл метотрексатыг сонгож болно (B).

#### Ààààà ñ àèòààí ò ñàðø ëü í àëüâàí ëèðò í ÿì ðèéäý

Эхний ээлжинд шалтгааны хүчин зүйлүүдээс хол байлагх хэрэгтэй. Хэсэг хугацааны дараа биенийн байдал сайжирдаг. Шинж тэмдэг арилахгүй байгаа, өвчин цочмог эхэлсэн үед преднизолоныг (0.5 мг/кг/хоногт)-г шинж тэмдэг арилтал хэрэглэнэ.

#### Ø àèòààí ñ äî ñòî é áóñ óóø àéí û ñàðòóðàë ððýâñý

Өвчин үүсгэдэг шалтгааныг тогтоох нь тавиланг тодорхойлоход тусална. 2/3 ба түүнээс олон өвчтөнд преднизолон эмчилгээ үр дүнтэй. Преднизолоныг 40 мг/хоногт тунгаар эхэлж 6-12 сарын туршид тунг аажим буулгаж хасна. Цөөн тохиолдолд преднизолон эмчилгээнд үр дүн гаралгүй өвчин болино хугацаанд даамжирч үхэлд хүргэдэг.

#### Ööëöàí ñàéí î ðî ñàéí î çü í ÿì ðèéäý

Өвчтөний 1/3-д өвчин аянаа эдгэрдэг. Шинж тэмдэг болон гадаад амьсгалын үйл ажиллагаа муудах тохиолдолд эмчилгээ хийнэ. Кортикостероид эмчилгээ мөөгэнцрийн халдвараар хүндрэх магадлал өндөр байдаг. Эмчилгээнд бронх-альвеолын лаважийг сонгох нь зүйтэй ба энэ эмчилгээ 20-50% үр дүнтэй.

#### Óóø àéí û ñàéí ñü í ààààðàá ýñò àèñòéí ñèð çü í ÿì ðèéäý

Лангхансын аварга эст гистиоцитоз үүсэхэд тамхидалт нөлөөлдэг. Эхний эмчилгээ бол тамхинаас татгалзах. Тамхинаас татгалзсан өвчтөний шинж тэмдэг арилж болно. Шинж тэмдэг тод илрэх, рентген болон гадаад амьсгалын үйл ажиллагааны шинжилгээнд шинж тэмдэг тод илэрсэн үед преднизолон эмчилгээ хийнэ. Преднизолон эмчилгээний үр дүнд өвчтөний 85%-д рентген шинжилгээнд сайжрал гардаг. Кортикостероид эмчилгээ зохимжгүй бол винбластин хэрэглэнэ. Дан уушки гэтсэн үед 25%-д аянаа эдгэрч, 50%-д тогтвортжуулж, 25%-д даамжирдаг байна.

#### Ëèí ñ àí àéí ñàéí î ñàéí àð çü í ÿì ðèéäý

Төрөх насны эмэгтэйчүүд илүүтэй өвчилдэг ховор өвчин ба даавын тэнцвэрт байдал алдагдсантай холбоотой үүсдэг. Энэ үед оофоректоми, туяа эмчилгээ, прогестерон, tamoxifen эмчилгээ хийдэг. Шинж тэмдэг ипрээгүй лимфангiolейомиоматозтай өвчтөнд дор хаяж нэг жилийн хугацаанд 400-800 мг medroxyprogesterone/ сард булчинд тарих эмчилгээ хийхийг зөвлөсөн байдаг. Мөн medroxyprogesterone 10-20 мг/хоногт уухаар хэрэглэж болно.

#### Óóø àéí û ñàéí ñèéüðèò ööëöàí õ öóñ öóðàò

Шалтгааныг тогтоох нь ямар эмчилгээ хийх хэрэгтэй тодорхойлно. Эмчилгээнд преднизолон, циклофосфамид,

эсвэл азатиоприн хэрэглэдэг.

Дархлааг дарангуйлах эм хэрэглэж байгаа үед тэдгээрийн үед гарч болох гаж нөлөөнөөс болгоомжлох хэрэгтэй. Энэ үед ЦЕШ хийж, элэгний үйл ажиллагааг хянаж, харин cyclophosphamide хэрэглэж байгаа үед гематурийг хянах хэрэгтэй.

Кортикостероид хэрэглэж байгаа үед ясны сийрэгжилт үүсэхээс сэргийлэх зорилгоор bisphosphonate хэрэглэнэ. Саркоидозын үед витамин D болон кальцийн бэлдмэл хэрэглэхгүй байхыг зөвлөдөг. УПТӨ-ий хүнд үед уушги-зүрхний хам шинж үүсдэг байна. Мөн УПТӨ-ий үед удаан хугацааны хүчилтөрөгч эмчилгээ хийх шаардлагатай байдаг.

#### Àø èæàò ñýâéý:

- The Diagnosis, Assessment and Treatment of Diffuse Parenchymal Lung Disease in Adults / Thorax. 1999; 54: 1-28.
- Baum's textbook of Pulmonary Diseases 2004, Section IV, V, VII-IX.
- Fishman's Pulmonary Diseases and Disorders 2003. Part 5-9.
- J.A.Nadel, J.F.Murray Textbook of Respiratory Medicine 2000. Section L.
- Demedts M, Costabel U. ATS/ERS international multidisciplinary consensus classification of the idiopathic interstitial pneumonias. Eur Respir J. 2002;19:794-6.
- Coultas D, Zumwalt R, Black W, and Sobonya R. The epidemiology of interstitial lung diseases Am J. Respir Crit Care Med. 150:967-72.
- Ganesh R, Derek Weycker, John Edelsberg, Williamson Z. Bradford, Oster G. Incidence and Prevalence of Idiopathic Pulmonary Fibrosis. Am J Respir Crit Care Med. 174:810-6.
- Bjoraker J, Ryu J, Edwin M et al. Prognostic significance of histopathological subsets in idiopathic pulmonary fibrosis. Am J Respir Crit Care Med. 1998;157(199-203).
- Vourlekis J, Schwarz M, Chemiak R, et al. The effect of pulmonary fibrosis on survival in patients with hypersensitivity pneumonitis. Am J Med. 116:662-8.
- Vourlekis J, Brown K, Cool C, Young D, et al. Acute interstitial pneumonitis. Case series and review of the literature. Medicine (Baltimore). 2000 Nov;79:369-78.
- Walter N, Collard H, King T. Current Perspectives on the Treatment of Idiopathic Pulmonary Fibrosis Proc Am Thorac Soc. 2006 ;3:330-8.
- Nagai S. Nonspecific interstitial pneumonia: a real clinical entity. Clin Chest Med. 2004;25:705-15.
- Lamblin C, Bergoin C, Saelens T, et al. Interstitial lung diseases in collagen vascular diseases. Eur Respir J. 2001;18:69S-80.
- Cordier J. Cryptogenic organizing pneumonia. Clin Chest Med. 2004;25: 727-38.
- Paramoorthy S, Jones P, Corticosteroid Therapy in Pulmonary Sarcoidosis: A Systematic Review. JAMA. 2002;287:1301-7.
- Baltzan M, Mehta S, Kirkham T, et al. Randomized Trial of Prolonged Chloroquine Therapy in Advanced Pulmonary Sarcoidosis. Am J Respir Crit Care Med. 160:192-7.
- Wyser C, van Schalkwyk E, Alheit B, Bardin P, et al, Treatment of Progressive Pulmonary Sarcoidosis with Cyclosporin A . A Randomized Controlled Trial. Am J Respir Crit Care Med. 156:1371-6

Òàí ñèéüðèò í èéò ñéó ñàéí àéí õ ññò í :  
Àèàààí è-: Á.Öydyí ààø

## 2009 Î Í Ä “Ì Í Ì Ä ËÍ ÈÈÖÉYÄÑÝÍ 1 1 (151)

### Дээжүүлэхийн чадаас

1. Б.Дагвацэрэн, Ч.Чимэдрагчaa. **Оёдай эеэдээгийн ааадаад ооадаадын төслийн тодорхойлалт**, "Монголын анагаах ухаан", 3, x.3
2. "Инди оои ааадаадийн ааадаад ооадаадын төслийн тодорхойлалт", 4, x.3 (А.Аардай ааадаадын төслийн тодорхойлалт)
3. А.Аардай ааадаадын төслийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 1, x.1
4. С.Энхболд. Ооадаадийн төслийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2, x.3

### Нийтийн салбартай төслийн тодорхойлалт

5. И.Ааадаад, А.Нададай ооадаад. NCM –тэй ишигчийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.25-27
6. Н.Амардулам, Б.Бурмаа. 5 дэгдэлтэйгээний тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2, x.25-32
7. А.Аардай ааадаадын төслийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 1, x.2-3
8. А.Аардай ааадаадын төслийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 1, x.4-6
9. А.Аардай ааадаадын төслийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 1, x.7-9
10. А.Аардай ааадаадын төслийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 1, x.9-11
11. А.Аардай ааадаадын төслийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 1, x.13-14
12. Ц.Амгалан, Д.Хишгээ, Г.Чойжамц. АЕИ 1-ийн -5 оодай тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.63-64
13. З.Ариуннаа, Ц.Хайдав, Б.Ууганбаяр, Б.Дагвацэрэн, Л.Галцог. Аадаадийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2, x.42-45
14. З.Ариуннаа, Б.Ууганбаяр, З.Оюун. Аадаадийн тодорхойлалт (Ionicera altaica pall)-ийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.41-43
15. Г.Арьендорж, О.Одээдэлээр, B.S.Paulsen, А.Аардай ааадаад, А.Ооджийн ааадаад. Аоийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.43-46
16. Г.Арьендорж, А.Ооджийн ааадаад. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.60-62
17. Г.Арьендорж, О.Ооджийн ааадаад, А.Аардай ааадаад, А.Ооджийн ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.100-104
18. Г.Ариунболов. "Баевскийн төлөвлөгөөний буюу Монгол-Зөвлөлтийн эрүүлийг хамгаалах салбарын 1928–1934 оны хамтын ажиллагаа. Аадаадийн тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2, x.33-38
19. Г.Аянга, Л.Давааням, Н.Пүрэвжав, Г.Ариунтуул, Д.Агиймаа. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 4, x.17-20
20. А.Аардай ааадаад, В.Үдээдээний тодорхойлалт, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 4, x.24-26
21. А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 4, x.33-35
22. А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.49-58
23. А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 4, x.21-23
24. Д.Баян-Өндөр, М.Намсрай, Н.Баасанжав. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 4, x.30-32
25. А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 1, x.15-20
26. А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.31-32
27. А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад, А.Аардай ааадаад. Тодорхойлалт, "Монголын анагаах ухаан", 1, x.11-12



Ëåêö, Ñ éì , Çº âëº ãºº

83. Д.Адъяахыг, Ж.Цэрэндагва. **Өөдөр аялалтад үзүүлэхийн төслийн ажлыг хөгжүүлэх**. Уланбаатар: Монголын анагаах ухаан, 2009, 3, x.147

84. Т.Алимаа, Ч.Чимэдрагчаа, Н.Төмөрбаатар. **Монголын анагаах ухаан**. Уланбаатар: Монголын анагаах ухаан, 2009, 3, x. 130-132

85. А.Алтанцэцэг, М.Амбага, Л.Хишигжаргал. **Айшигийн төслийн ажлыг хөгжүүлэхийн төслийн ажлыг хөгжүүлэх**. Уланбаатар: Монголын анагаах ухаан, 2009, 3, x.137-139

ì ýä ýyë ýë, ñóðòàë÷èë ãàà —

86. Ч.Алтмаа, Д.Баярмаа. Эёжүүгээ өөдөр өдүй, өобийн үе аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x. 144
87. ААи аадаалтадаа, А.Оюнчирэг, А.И. Борисов. Овогийн үе аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 1, x.45-46
88. А.Аи аадаалтадаа, А.Нэдэлжүүлэг, А.Оюнчирэг, А.И. Борисов. Овогийн үе аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 1, x.45-46
89. ААи аадаалтадаа, А.Нэдэлжүүлэг, А.Оюнчирэг, А.И. Борисов. Овогийн үе аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 1, x.50-51
90. Э.Амарсанаа, Д.Авирамэд, Я.Дугарсүрэн, Ц.Батболд. Овогийн үе аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 4, x.86-88
91. Б.Анхбаяр, Г.Мөнгөнцэцэг. Овогийн үе аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.145-146
92. Ш.Батсайхан, Д.Цэрэндагва, Б.Батчулуун. "Аялалыг ойн үе аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.139-140
93. Ц.Билэгтсайхан, Ц.Гандолгор, Г.Оюунчирэг, Н.Мөнхтүвшин, Б.Мөнхбат. Аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 4, x.88-95
94. А.Аодолт, А.Аи аадаалтадаа, А.Нэдэлжүүлэг, А.И. Борисов. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 1, x.67-71
95. А.Аадаалтадаа, А.Оюнчирэг, А.И. Борисов. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2, x.52-54
96. Didier Patte, Д.Мөнгөнчимэг. Аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2, x.71-74
97. А.Дүүрэнбилэг Умайн хоргуй хавдартай жирэмсэн эмэгтэйчүүдийн дааврын солилцооны онцлог. "Монголын анагаах ухаан", 4, x.82-85
98. З.Зузаан. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.128-129
99. А.Аи аадаалтадаа, А.Нэдэлжүүлэг, А.Оюнчирэг, А.И. Борисов. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 1, x.53-60
100. Д.Ичинноров орчуулсан, Richard S. Irwin, MD., and J. Mark Madison, Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 1, x.61-66
101. Д.Ичинноров (И.Д.Ичинноров) и О.Г.Мелихов (Москва), Е.П.Шаврикова (Саратов). Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 4, x.98-101
102. З.Мэндсайхан, М.Пүрэвжав, Б.Пүрэвсүрэн. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x. 124-125
103. Б.Намбар. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 1, x.41-42
104. Д.Нацагдарж, Г.Туяацэцэг. Аи аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x. 129-130
105. П.Нямдаваа. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2, x.46-48
106. Г.Одонцэцэг. Аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.133-134
107. Д.Отгонтуяа, Д.Урангэрэл. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x. 140-141
108. А.И. Борисов. Овогийн үе аялалыг ойн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 1, x.46-49
109. С.Оюунбилэг. Аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.142-143
110. Ч.Оюунтогос. Овогийн үе аялалыг ойн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2, x.68-70
111. Ж.Өлзийсайхан, Д.Зулгэрэл. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2, x.54-58
112. Б.Саранцэцэг, М.Амбагаа. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x. 122-123
113. Л.Содномцогт. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2, x.49-51
114. С.Сээрсэргдорж, Б.Мягмарсүрэн. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x.135-136
115. Н.Төмөрбаатар. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 3, x. 118-120
116. Н.Төмөрбаатар, Д.Шинэтуяа. Аадаалтадаа өөдөр үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 2009, 3, x. 132-133
117. А.Одэлжүүлэг, А.Аи аадаалтадаа, А.Оюнчирэг. Овогийн үе аялалыг ойн үеээштэй түүхийг суралсан. "Монголын анагаах ухаан", 4, x.79-82

Ø ð̥i æ yðýðöð̥eýe

132. П.Нямдаваа. Ø ëí ý áóëäí ãëéí ó÷ëð. “Монголын анагаах ухаан”, 4, x.106

## 2009 Ì Í Ä ÀÍ ÀÄÀÀÖ ÖÖÀÀÍ Û ÑÀËÁÀÐÒ ÝÐÄÌ ÈÉÍ ÇÝÐÝÃ ÕÀÌ ÁÀÅËÑÀÍ ÝÐÄÝÌ ÒÝÄ



**Ææí öàí àí ì ãééí Áàðàà  
(Ó¤ Ñ° Q° ýéñðåðí àò)**

ХӨСҮТ-ийн тасгийн эрхлэгч, ЭМШУИС-ийн докторант Жанцандоогийн Батаа “Хачигт боррелиозын экологи, тархалтын онцлог, эмнэлзүй, оношлогоо, сэргийлэлт” сэдвээр 2009 оны 01 дүгээр сарын 08-нд Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгаалав.

Монгол улсад хачигт боррелиоз өвчний үүсгэгчийн үндсэн дамжуулагч нь ой тайга ба ойт хээрийн бүсэд амьдрягч ойн хачиг (*I.persulcatus*) байгааг тогтоож, энэ хачгаас ялгаж дүйсэн боррелийн омгууд (үүсгэгч) нь хүнд эмгэгтөрөгч *B.garinii*, *B.afzelii* хэвшинжүүд болохыг тодорхойлсон байна.

Хачигт боррелиозын шалтгаан нь хүмүүс ургамал түүх, мал хариулах, алт олборлох зэргээр байгалийн идэвхтэй голомтонд орж хачигт хазуулснаас халдварт аван өвчилж, манай улсад энэ өвчний мэдрэлийн, арьсны, үений, зүрхний зэрэг эмнэлзүйн үндсэн хэлбэрүүд илэрч, мэдрэлийн хэлбэр давамгайлсан, ужиг явцтай, дунд зэргийн хэлбэр зонхилж байгаа, тус улсын ойн бус нутагт одоогоор хачигт боррелиозын голомт 64, хачигт халдвартын их эрсдэлтэй голомт 17 байгааг тогтоосон байна. Хачигт боррелиозын эмийн сэргийлэлтэд хачигт хазуулсаны дараах эхний 5 хоногт доксициклин гидрохлорид 0,1 эмийг зохих тунгаар хэрэглэх нь үр дүнтэй гэж дүгнэжээ.

-Монгол улсад хачигт боррелиоз (Lyme disease) өвчнийг анх тархвар судлал, эмнэлзүйгээр оношлож, нян судлал, фермент холбоот эсрэг биеийн болон полимеразын гинжин урвалаар баталснаар манай улсын халдварт өвчний тоо нэгээр нэмэгдсэн байна. Молекул биологийн судалгаагаар монголын хачгаас боррелийг ялан дүйж *B.garinii*, *B.afzelii* омгууд болохыг тодорхойлон, 18 хэвшинжийг нь АНУ дахь Genbank санд бүртгүүлжээ.

-Хачигт боррелиозын үүсгэгчийг дамжуулагч ойн хачгийн (*I.persulcatus*) экологи, тархалт, энэ өвчний шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ, сэргийлэх арга зүйг судалж, тандалтын болон оношлогоо, эмчилгээний улсын стандартыг батлуулж, мөрдлөө.



**ÝÍ ÕØ ðèéí Àí àðñàí àà  
(Экстернат, XCYT)**

Э.Амарсанана нь “Хөхний өмөн үүсэхэд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйл” сэдвээр 2009 оны 3 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан байна.

Хөхний өмөнгийн өвчлөл, нас баралтын түвшинг XCYT-ийн мэс заслын тасагт 2001-2005 оны хооронд хөхний өмөн оношоор хэвтэж эмчлүүлсэн 522 өвчтний түүхийн материалд үндэслэн тогтоожээ. Мөн эмэгтэйчүүдийн нэхэн үржихүйн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдэд тулгуурлан хөхний өмөн үүсэхэд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлжээ.

Хөхний өмөнгийн Монгол эмэгтэйчүүдэд BRCA1 генийн 185 дахь байрлалын аденин, гуанины делецийн, BRCA1 генийн 5384 дахь байрлалын цитозины инсерцийн, BRCA2 генийн 6174 дахь байрлалын тимины делецийн мутациудыг Полимеразын Гинжин Урвалын шинжилгээгээр илрүүлсэн байна.



**Äî ðæñðöýí ðééí Áàðñàéöàí  
(Горилогч, ДЭМБ/НДБ)**

ДЭМБ-ын НДБ-ийн Эрүүл мэндийн санхүүжилтийн зөвлөх Д.Баярсайхан “Монгол улсад эрүүл мэндийг хөгжүүлэх арга хэмжээг нийгмийн эрүүл мэндийн даатгалаар дэмжих тухай” сэдвээр 2009 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Япон Улсын Токио хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгааллаа.

Эрүүл мэндийг дэмжиж өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт бус өвчнийг бууруулж хүн амыг эрүүлжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд нийгмийн эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэх үүргийг судалсан бүтээл турвижээ. Энэ бүтээлд Монгол орны нийт 5 бүсийн 4000 мянган хүнийг хамруулж хийсэн материалд тус улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, хүн амын эрүүл мэнд, санхүүгийн байдалтай уялдуулан судалж, улмаар задлан загварчилж олон улсын SimINS-2 үнэлгээний аргаар хөгжлийн 10 жилийн тойм үнэлгээ, дүгнэлтийг гаргасан байна.

Үг бүтээл нь хүн амын эрүүл мэндийн талаар явуулах бодлогын эдийн засаг нийгмийн ач холбогдлыг тодорхойлж эрүүл мэндийн салбарын тогтолцоог сайжруулах онол, практикийн асуудлыг хөнгсөнөөрөө шинэлэг юм. Судалгаанд эрүүл мэндийг хөгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг сайжруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тухайлбал сэргийлэх тарилгын санхүүжилтийн эх үүсвэрийг 2015 он гэхэд Монгол улс эрүүл мэндийн даатгалаар дамжуулан шийдвэрлэх боломжийг үндэслэл тооцоотой дэвшигүүлсэн байна. Энэхүү эрдмийн ажил нь бүхэлдээ эрүүл мэндийг хөгжүүлэх, өвчнөөс сэргийлэх арга хэмжээний эдийн засгийн мөн чанар, эрүүл мэндийн даатгал, даатгалтай иргэд хоорондын харилцаа, үйлчилгээ, үр дүнг сайжруулах, эдийн засгийн үндэслэл, тооцоонд суурилсан бодлогын олон талын ач холбогдолтой бүтээл болжээ.



**× Æððöýí äàðæàðæéí Ø° áæàððæé  
(ЭМШУИС-ийн докторант)**

АУХ-ийн ЭША ×.Ø° áæàððæé “Насанд хүрсэн Монгол хүний зүрхний гол судасны болон хоёр хавтаст хавхлагуудын хэмжээс, бүтцийн онцлог” сэдвээр 2009 оны 3 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан байна.

Судлаач зүрхний хэт авиан шинжилгээгээр

харьцангуй эрүүл 108 хүний гол судасны болон хоёр хавтаст хавхлагуудын хэмжээс, зүрх судасны бус эмгэгээр зуурдаар нас барсан харьцангуй эрүүл 80 цогцсын хавхлагийн хэмжил зүйн үзүүлэлтийг тодорхойлж, хавхлагуудын эдийн бүтцийг судалсан байна.

Монгол хүний зүрхний гол судасны хавхлагийн хавтасны өндөр, чөлөөт болон бэхлэгдсэн ирмэгийн урт, титэм судасны нүхний байрлал, хоёр хавтаст хавхлагийн урд, хойт хавтасны өндөр, үелэл, уулзваруудын хэмжээсийг тогтоожээ. Эдгээр хэмжээс нь Монгол хүнд тохирсон хиймэл хавхлага захиалах, хавхлагийн уламжлалт мэс засал эмчилгээний техник, түүний үр дүнг боловсронгуй болгон сайжруулах удирдамж болгон ашиглах боломжтой.

Монгол хүний зүүн ховдлын урд, хойт хөхлөг булчингийн хэлбэрүүдийг тодорхойлж судалсан нь хавхлаг солих үеийн мэс заслын эмчилгээний тактикийг зөв сонгох үндэслэл болсон байна.

Хавхлагийн бичил бүтцийн шинжилгээгээр гол судасны болон хоёр хавтаст хавхлагийн хавтасны дунд давхарга үндсэн бодисын хуримтлал үүсэх замаар зузаарч нас хамааралт эдийн өөрчлөлт гарч байгааг илрүүлсэн байна.

Хиймэл хавхлагийн хэмжээ сонгох практик зөвлөмж гаргаж, хиймэл хавхлагийн төрөл сонгох алгоритм боловсруулжээ.



### Хөөсний үйлчилгээ

(Нэгдүгээр амаржих газар, их эмч, экстернат)

Нэгдүгээр амаржих газрын эх барих, эмэгтэйчүүдийн эмч Ч.Мядаг “Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бага аарцгийн хэвийн хэмжээг тодорхойлох асуудалд” сэдвээр 2009 оны

3 дугаар сарын 19-ны өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгаалав.

Судалгаанд Улаанбаатар хотын 18-49 насны эмэгтэйчүүдээс санамсаргүй түүврийн аргаар 294 эмэгтэй төлөөлөл болгон сонгож хамруулсан байна. Судалгааг 2006-2008 онд нийслэлийн БЗД-ийн нэгдсэн эмнэлэг, Улсын клиникин төв эмнэлэгийн дүрс оношлогооны тасгийг түшиглэн явуулжээ. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдэд том, бага аарцгийн хэмжээсүүдийг компьютертомограф, Эдээлэх аргаар хэмжиж, антропометрийн аргаар зарим үзүүлэлт, И-эдээлэх ромбо, Соловьевын индексийг тус тус хэмжсэн байна. Энэхүү хэмжээсүүдийг тогтоосноор төрлөгийг зөв төлөвлөх, жирэмслэлт, төрөлтийн хүндрэлээс сэргийлэх, нярайн өвчлөлийг бууруулах ач холбогдолтой болжээ.



### Ингээдээжийн Ааи үйлчилгээ

(ЭМШУИС-ийн харьяа Говь-Алтай аймаг дахь АҮК, докторант)

ЭМШУИС-ийн харьяа Говь-Алтай аймаг дахь АҮК-ийн багш М.Банзаагаяа “Нэмрэгт банздоогийн фармакологи, фитохимиийн зарим судалгаа” сэдвээр 2009 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зээрг хамгааллаа.

Нэмрэгт банздоогийн бэлдмэл хорон чанар багатай, эмчилгээний хүрээ өргөн, удаан хугацаагаар хэрэглэхэд бие махбодид хуримтлагддаггүй, сөрөг нөлөөгүй байна. Нэмрэгт банздоогийн бэлдмэл нь гуурсан хоолой ба гэдэсний гөлгөр булчинг супруулах, үрэвслийн эсрэг, цөс хөөх, цэр ховхлох, хавдрын эсрэг, хавсаргын тогтолцоог идэвхжүүлэх үйлдэлтэй болохыг тогтоосон байна.

Нэмрэгт банздоогийн газрын дээрх хэсгээс ялгасан 4 полисахаридын молекул жин 15500-61000 молекул нэгжийн хооронд байна.

Нэмрэгт банздоогийн газрын дээрх хэсэгт арабиноз, глюкоз, галактоз, манноз зэрэг арабиноглюкоманнаны төрлийн саармаг полисахарид, галактуроны хүчил, глюкурони хүчил зэрэг хүчинилэг полисахарид агуулдаг байх бөгөөд галактуроны хүчил 24(19+3+3) 1→4, галактоз (4) 1→4, глюкоз 8(2+4+2) 1→4 гликозидын холбоогоор холбогдсон бүтэцтэй болохыг энэ ажлын хүрээнд тогтоожээ.

Нэмрэгт банздоогийн газрын дээрх хэсэгт рутин, ситостерол агуулагдаг болохыг анх удаа таньж тодорхойлсон байна. Нэмрэгт банздоо ургамалд 17 амин хүчил агуулагдах бөгөөд үүнээс үл орлогдох амин хүчил 8 агуулагдсан байна. Зэрлэг ба таримал Нэмрэгт банздоогийн химийн найрлага ба фармакологийн үйлдэл ойролцоо байна. Нэмрэгт банздоо ургамлыг нөхөн сэргээж, тарималжуулж болох бүрэн боломжтой гэж үзсэн байна.



### Нийтийн эмчилгээ

(ЭМШУИС-ийн НАСС-ийн Нүүр амны эмчилгээний тэнхим, Экстернат)

ЭМШУИС-ийн НАСС-ийн Нүүр амны эмчилгээний тэнхимийн багш Ж.Үржинлхам “Амны салстын дахилтат афт үрэвслийн эмнэлзүйн онцлог, эмчилгээнд “Ахизунбер” бэлдмэл хэрэглэсэн үр дүн” сэдвээр 2009 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгааллаа.

Улаанбаатар хотын хүн амын дунд амны салстын дахилтат афт үрэвслийн тархалт, эмнэлзүйг судлан, үрэвслийг эмчлэх ургамлын гаралтай эмийн бэлдмэл (Ахизунбер)-ийг бэлтгэх технологийн зарим туршилт явуулж бэлэн бүтээгдэхүүний стандартын үзүүлэлтийг тогтоох урьдчилсан судалгаа хийж, эмийн бэлдмэл (Ахизунбер)-ийн нянгийн өсөлт үржилтэд нөлөөлсөн байдал, бэлдмэлийн шархны эдгэрэлтэд үзүүлэх нөлөөг судлан тогтоосон байна.



Ãýí äýí ãèéí Ñàí æäî ðæ

(ЭНЭШТ, Эх барих эмэгтэйчүүдийн клиникийн захидал, экстернат)

ЭНЭШТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн клиникийн захирал Г.Санждорж “Монгол эмэгтэйчүүдийн шээс задгайрлын мэс засал сүүншлэгийн сартын тогтолцоогүйц

ЗМ-ИМПЕРИИЙН АРГЫН ТӨГӨЛДӨРЖҮҮЛСҮНЬ" СЭДВЭЭР 2009 ОНЫ 5 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР УЛААНБААТАР ХОТНОО АНАГААХ УХААНЫ ДОКТОРЫН ЗЭРЭГХАМГААЛЛАА.

Шээс задгайрлыг мэс заслын аргаар эмчлэх хувилбарт арга боловсруулж, нэвтрүүлснээр шээс задгайрлыг аарцгийн эрхтэний доошлолтын хамт эмчлэх боломжтойг баталсан байна.

Ингэснээр, эх барих эмэгтэйчүүдийн практикт аарцгийн эрхтэний супрал, шээс задгайрал, хошногоны үйл ажиллагааны алдагдалд эх барих эмэгтэйчүүд-уролог-проктолог эмчийн мэргэжлийн хамтын тусламж үзүүлэх суурийг тавьсан. Судалгааны ажлын хүрээнд уродинамик шинжилгээний орчин үеийн дижитал аппарат бухий оношлогооны кабинет нээгдэж, сувилагч-техникич сургагдан ажиллахын зэрэгцээ хэвтүүлэн эмчлэх мэс заслын ортой өрөө, урогинекологич мэргэжлийн эмч нар ажиллаж эхэлсэн. Монгол улсад анх удаа урогинекологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах мэргэжлийн амбулатори-стационарийн тогтолцоо бий болж, олон улсын урогинекологийн мэргэжлийн нийгэмлэгтэй хамтран ажиллаж байна.



Ãí áî æàâû í Äàâàà

(ЭМШУИС,  
Эпидемиолог  
тэнхим, горилогч) НЭМС-ийн  
биостатистикийн

ЭМШУИС, НЭМС-ийн  
Эпидемиологи биостатистикийн  
тэнхимийн багш Г.Даваа “Гэдэсний  
зарим халдвартын хөдлөлзүйн  
онцлог, үүсгэгчийг дамжуулагч ялааг  
зээр 2009 оны 5 дугаар сарын 14-ний  
ны докторын зэрэг хамгааллаа.

Сүүлийн жилүүдэд гэдэсний халдвартын өвчлөл

тогтмол өндөр бөгөөд вируст гепатит А улсын хэмжээнд дэгдэлт хэлбэрээр гарч байгаа тул эдгээр халдвартын эпидемиологийн онцлогийг судлан, урьдчилан сэргийлэх аргыг боловсронгуй болгох шаардлага урган гарч байна. Судалгааны ажлын зорилго нь зонхилон тохиолдож буй гэдэсний зарим халдвартын хөдлөлзүйн онцлог түүнд тасалгааны ялааны үзүүлэх нөлөөг судлан халдварталтыг бууруулах, сэргийлэх арга замыг боловсронгуй болгох зорилгоор судалгаа хийжээ.

Гэдэсний зарим халдвартын хөдлөлзүйн онцлог, хандлагыг тогтоосноор тухайн халдвараас угтуулан сэргийлэх арга хэмжээ боловсруулах, тусламж үйлчилгээний чиглэл, нөөцийг төлөвлөх, зохицуулах боломжтой болсон байна. Гэдэсний халдвартын үүсгэгчийг дамжуулагч ялааны биологийн идэвхийг тодорхойлж, ялааг устгах шавьжгүйтгэлийн бодисыг харьцуулан туршсанаар оновчтой аргыг хэрэглэх боломж бүрдсэн бөгөөд судалгаанаас зөвлөмж гарсан байна.

Í ĐÀ Ê Ò Ë Ê Ç<sup>a</sup> Â Ë<sup>a</sup> Ì Æ

À. Áî äëî ãû í ò¿âø èí ä:

1. Вируст гепатит А-ийн халдварт голомтлон тохиолддог хот, аймгийн төв, дүүрэг, суманд өвчлөл ихэсдэг улирал, өндөр бүртгэгдэх жилүүдийг угтуулан бага наасны хүүхдүүдийн дунд халдварталтын түвшинг тогтоон, урьдчилан сэргийлэх вакцин, гаммаглобулинд хамруулах ажлыг бодлогын түвшинд дэмжин, хэрэгжүүлэх
  2. Цэцэрлэг болон сургуулийн бага, дунд ангийн хүүхдийн сургалтын хөтөлбөрийн “Эрүүл мэндийн боловсрол” сэдвийн хүрээн дэх хичээлүүдийн агуулгыг шинэчлэх, хүүхдүүд зонхилон өртдөг гэдэсний халдвараас сэргийлэх, эрүүл ахуйн дадал олгох сургалтыг тулхүү оруулах асуудлыг БСШУЯ-ны бага боловсролын асуудал эрхэлсэн газарт уламжлах
  3. Вируст гепатит А болон бусад гэдэсний халдварын үед хийх голомтын судалгааны арга аргачлал, голомтонд авах арга хэмжээ, түүнд тавих хяналтыг чанаржуулах, голомтлог байдлыг таслах арга хэмжээг боловсронгуй болгох, эрх зүйн орчин, ашиглаж буй баримтуудыг шинэчлэх, сайжруулах

Á. Àõóé õàäüöëû í çàì û ã òàñëàõòää ÷èæëýñyí  
àõäà õýí æýy:

## 1. Ýõ óóðõàéä ÷èääýñýí :

- Вируст гепатит А болон гэдэсний халдвартын үед өвчтний ойрын хавтагсадад тэдний мөрдөх дэглэм, аргуудын талаар зөвлөмж, аргачлал шинээр боловсруулах
  - Эдгэрэлтийн хяналт, өвчний явцыг (эмнэлэгт хэвтээгүй болон гарсан үед) өрхийн эмч, халдвартын эмчийн удирдлагаар хянах, зөвлөх

## 2. Äàì æèõ çàì û ã òàñëàõ:

- Гэдэсний халдварт өвчний тохиолдол гарсан үед хоол хүнсний сав, хэрэгслэлийг тусд нь угаах, халдвартгүйтгэх
  - Ялгадас, хөтөөвч, бие засах газар зэргийг тогтмол халдвартгүйтгэх
  - Гараа тогтмол халдвартгүйтгэх
  - Хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах
  - Усыг буцалгаж хэрэглэх, ус хадгалах сав, сумгийн тогтмол халдвартгүйтгэх хөвчиншиг

### 3. Өлжүүлэх төмөр замын төслийн төсөл

- Тухайн гэдэсний халдвартын халдвартлах нууц хугацааны дээд үе хүртэл өрхийн болон мэргэжлийн эмчийн хяналтанд байх
  - Гэр бүл, орчинд байгаа өвчтэй хүний эд зүйлс, аяга, сав суулгыг хэрэглэхгүй байх, халдвартгүйтгэх хэрэглэх
  - Урьдчилан сэргийлэх, вакцин, гаммаглобулинд шаардлагатай гэж үзвэл хамрагдах

Â. ßéàáí ú óñóàëé áóþ ó ø àâæñé ðäýëèéã  
áí ëí âñðí í ãóé áí ëäí õ òàëàäð:

- Тасалгааны ялааны устгалд одоогоор хэрэглэж буй шавжгүйтгэлийн химийн бодисын хоруу чанарыг тодорхойлох
  - Ялааны биологийн идэвхжил өндөр байдгийг харгалзан өглөөний цагаар мэдрэг чанар

- өндөртэй бодисыг ашиглан шавжгүйтгэлийг хийх ажлыг зохион байгуулах
- Тасалгааны ялааны тархалт өндөртэй объектод химийн аргаар гадаа болон өрөөн доторх ялааг устгах нь илүү үр дүнтэй аргыг түгээх, гадаа орчинд ялаа баригч торыг тогтмол хэрэглэнээр ялааны нягтралыг хянах боломжтой
  - Халдвартгүйтгэлийн төвүүдэд хэрэглэж буй хор бодисын тэсвэртэй байдлыг хянах, хэрэглэх арга, хэлбэрийг шавжийн хөгжлийн үе шат, идэвхжлээс хамруулан хийх судалгааг өргөжүүлэх



### ААДЫН НАСЖИЛТЫН ӨҮҮСЧИЙН СОСНОВЫЙН ХАЛААНЫ ДААВРЫН БАЛСАН ХҮЧИН ЗҮЙЛСЭН ЭРДЭВЛЭЛ

(ЭМШУИС, аспирант)

ЭМШУИС-ийн БиоАС, Хими-Биохимийн тэнхимийн багш Ж.Мөнхцэцэг “Хүний насжилтын үеийн дааврын болон дархлааны зарим хүчин зүйлийн судалгаа” сэдэвт бүтээлээр 2009 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгааллаа.

Ж.Мөнхцэцэг хүний насжилт, хөгшрөлийн байдлыг дааврын болон дархлааны зарим хүчин зүйлтэй холбон судлах зорилгоор судалгаа хийжээ.

Биологийн насны үнэлгээгээр манай хүмүүст эрэгтэйчүүдэд 60-аас дээш насанд ( $p<0.05$ ), эмэгтэйчүүдэд 45-55 насанд хөгшрөлийн үйл явц хамгийн хурдан ( $p<0.01$ ) явагдаж байна. ДГЭАС нь нас ахижад буурч байгаа ба ( $r=-0.553$ ,  $p=0.001$ ) энэ бууралт нь эрэгтэйчүүдэд илүүтэй явагдаж байна. ДГЭАС нь кортизол, өсөлтийн даавартай харьцуулахад биологийн насжилтад илүү хүчтэй нөлөөлөгч хүчин зүйл байна. Кортизол дааврын хэмжээ нас ахижад ихсэж ДГЭАС-тай урвуу хамааралтай байна. Кортизол ДГЭАС-ын харьцаа нас ахижад ихсэж байгаа нь бөөрний дээд булчирхайн диморфизм ахимаг насанд хүчтэй илэрч бодисын солилцоонд катаболизм давамгайлж байгааг харуулж байна. Харин кортизол дааврын ялгаралт нийэм, сэтгэл зүйн цочрол, стрессийн үед настангуудад идэр насныхнаас илүүтэйгээр ихэсч буй нь ажиглагдсан байна. Насжилтын нэг биомаркер болох Өсөлтийн даавар нь нас ахижад судалгаанд хамрагдагсдад буурч байгаа нь эрэгтэйчүүдэд илүү тод илэрч байв. Өсөлтийн дааврын ялгаралтад бидний тодорхойлсон бусад хүчин зүйлүүдээс ДГЭАС нь эрэгтэйчүүдэд илүү нөлөөтэй байна. Бэлгийн даавар холбогч глобулин нь нас ахижад ихсэж байгаа нь 55-65 насны бүлэгт илүү тод илэрч байна. Эмэгтэйчүүдэд энэ насанд өмнөх насын булгээс 2 дахин нэмэгдэж байгаа нь энэ насын биологийн насжилтын үнэлгээтэй хамааралтай байна. Нас ахижад TNF $\alpha$  үнэн магадтай өөрчлөгдөөгүй, харин IL-6 ихсэж байна. Цитокинууд ДГЭАС-ын хооронд тодорхой хамаарал байхгүй байна. Харин судалгаанд хамрагдагсдад кортизолын дархлаа дараангуйлах идэвхи ДГЭАС-ын дархлаа дэмжих идэвхиэс илүүтэй байгааг тогтоосон байна.

### ДААДЫН НАСЖИЛТЫН ӨҮҮСЧИЙН СОСНОВЫЙН ХАЛААНЫ ДААВРЫН БАЛСАН ХҮЧИН ЗҮЙЛСЭН ЭРДЭВЛЭЛ

(Хавдар Судлалын Үндэсний Төв Горилогч)



Хавдар Судлалын Үндэсний Төвийн их эмч Р.Асай “Хөхний өмөнгийн рентген (маммографи)-ийн асуудалд” сэдэвт бүтээлээр 2009 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны

докторын зэрэг хамгаалсан байна.

Хөхний өмөнгийн рентген-маммографийн үндсэн бутслах шинжүүдийг тогтоох ба Монгол эмэгтэйчүүдийн хөхний зарим нэгэн хэвийн хэмжээг тодруулсан бүтээл юм. Хөхний өмөнгийн үеийн рентген шинжүүдийг тогтоож, ялан оношлогооны шалгтууруудыг буй болгож эмнэлгийн практикт нэвтэрүүлсэн нь хөхний рентген зургийн тайлал бичихэд эмч нарын гарын авалга болсон ба хөхний зураг авах техникийн оновчтой нөхцөлийг тогтооож, хөхний рентген зургийг тусгай зориулалатын ба ердийн рентген аппаратаар авах аргачлалыг боловсруулсан нь уг шинжилгээг хот хөдөөгийн рентген кабинет бүхий бүх эмнэлгүүдэд ашиглах боломжтой юм.



### ДААДЫН НАСЖИЛТЫН ӨҮҮСЧИЙН СОСНОВЫЙН ХАЛААНЫ ДААВРЫН БАЛСАН ХҮЧИН ЗҮЙЛСЭН ЭРДЭВЛЭЛ

(ЭМШУИС, Горилогч)

ЭМШУИС-ийн багш “Чихрийн шижин өвчнийг үүсгэх эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа” сэдэвээр 2009 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан байна.

Хүмүүсийн амьдарч байгаа орчны өөрчлөлт, хотжилт, хооллолт, хөдөлгөөний хомсдол, залуу хүмүүсийн дундах таргалалт зэрэг нь чихрийн шижин өвчинг үүсгэх эрсдлийг улам нэмэгдүүлж байна. Тухайлбал ДЭМБ-ын тооцоолсоор 2025 он гэхэд 150 сая, 2030 онд 335 сая хүн чихрийн шижин өвчнөөр өвчилж шинээр бүртгэгдэх магадлалтайг тогтоожээ. 2006 оны байдааар Монгол улсад 34000 хүн чихрийн шижин өвчтэй гэж бүртгэгдсэн бөгөөд энэ нь ДЭМБ-ын тооцоогоор 2030 он гэхэд 81000 хүн шинээр өвчлөх магадлалтай болж байна.

Судалгааг ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу “Шаталсан судалгааны арга”-ыг ашиглан явуулсан байна. Чихрийн шижин өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаанд 25-64 насны 1104 хүний холбогдох мэдээллийг авч судалжээ.

Судалгаанаас доорх дүгнэлт хийсэн байна:

1. Таргалалт, биеийн жингийн илүүдэл, тамхи таталт тэрчлэн жимс хүнсний ногоо болон нийлмэл нүүрс ус агуулсан хүнсний бүтээгдэхүүнийг 5 нэгжээс бага хэрэглэх зэрэг нь чихрийн шижин өвчин үүсгэх нийтлэг эрсдэлт хүчин зүйлс болж байна.
2. Чихрийн шижин өвчний эрсдэлт хүчин зүйлс нь монголын хот хөдөөгийн хувьд тархалтаараа адилхан байгаа боловч хот суурин газрын хүн амын дунд хөдөлгөөний хомсдол, биеийн жингийн илүүдэл, архи тамхины хэрэглээ өндөр, харин хөдөөгийн хүн амын хувьд жимс, хүнсний ногооны хэрэглээ бага өөх тосны

- хэрэглээ их байгаагаар эрсдлийн онцлог нь ялгагдаж байна.
3. Өлөн үеийн цусан дахь сахарын хэмжээ ихсэх нь чихрийн шижин өвчний эрсдэлт хүчин зүйлс болох төдийгүй тархалтыг тогтоо болон өвчнийг эрт илрүүлэх эмнэл зүйн хамгийн бодитой үзүүлэлт болно.

### Ї ДАЁӨӨÈ Çª ÄË Ì AE

1. Чихрийн шижин түүний эрсдэлт хүчин зүйл, хүндрэлийн талаар хүн амд боловсрол олгох эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа явуулах
2. Чихрийн шижин өвчний эрсдэлт хүчин зүйлстэй хүмүүсийг хяналтанд авах анхдагч сэргийлэлтийн арга хэмжээг авах
3. Чихрийн шижинтэй хүмүүсийг эрт илрүүлж, оношлож, хүндрэлээс сэргийлэх урьдчилан сэргийлэх анхдагч болон хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг авах
4. Архи, тамхины хэрэглээг бууруулах, архи, тамхины хор нөлөө эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөхийн учрыг ойлгуулж хэрэглээг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
5. Хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээг дэмжих, өөх тосыг хэтрүүлэн хэрэглэхийн хор уршигийг ойлгуулж, зөвлөгөө өгөх, боловсрол олгох
6. Хүн ам, олон нийт, байгуулага хамт олны хүрээнд идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих орчин бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
7. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч эмнэлгийн ажилчдын чадавхийг бэхжүүлэх зэрэг болно.



### Ёоâñàí äí ðæééí Áí àëéàí

(ҮКТЭ-ийн ЕМЗК, Экстернат)

ҮКТЭ-ийн ЕМЗК-ийн их эмч, Л.Амгалан “Цээжний гялтангийн цочмог идээт үрэвслэлийн лазер эмчилгээ” сэдэвт бүтээлээр 2009 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зээрг хамгааллаа.

ЦГЦИУ-тэй эмчлүүлэгчид хот хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүдэд хэрэглэж болох эмийн болон мэс засал, лазер туяаг хослон хэрэглэсэн цогц эмчилгээний үр дүнтэй технологийг санаачлав. Тухайн эмгэгтэй эмчлүүлэгчийн эмчилгээнд лазер эмчилгээг оруулснаар эмчилгээний үр дүн эрс сайжирч, эмчлэгдэх хугацаа богиносно.

ЦГЦИУ-тэй эмчлүүлэгчийн эмчилгээний тавилангийн шалгууруудыг боловсруулсан нь тухайн эмгэгтэй эмчлүүлэгчийн эмчилгээний үр дүнг сайжруулах бололцоог олгосон байна.

Цээжний гялтангийн цочмог идээт үрэвслэлтэй эмчлүүлэгчийн эмчилгээний зарчмыг хот, хөдөөгийн төвлөрсөн эмнэлгүүдэд нэвтрүүлэх чиглэлээр зөвлөмж боловсруулсан байна.

#### Практик зөвлөмж:

1. Цээжний гялтангийн хөндийд идээт үрэвсэл явагдаж буй сэжиг бүхий эмчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлмэгцээ, ерөнхий эмнэл зүйн шинжилгээ, цээжний рентген шинжилгээний

хамт, цээжний ХАШ, КТ шинжилгээ зэрэгцүүлж хийх хэрэгтэй. Идээт үрэвсэлт процессын хөдлөл зүйд дүгнэлт өгөхийн тулд фистулографи, КТ, ХАШ-г өвчний явцын дагуу хийх нь зүйтэй. Эдгээр иж бүрэн оношлогооны арга хэмжээ нь бидний саналаар тийм их цаг хугацааг шаардахгүй бөгөөд өгсөн мэдээлэл нь эмчлүүлэгчийн эмчилгээний цаашдын тактикийг боловсруулахад үнэлж баршгүй хувь нэмэртэй.

2. Цээжний гялтангийн хөндийд идээт үрэвслэлийн эмчилгээг эмгэгийн явц болон тархалтаас үл хамааран цээжний гялтангийн хөндийд хатгалт хийх болон гуурс тавьж, цэвэршүүлэхээс эхлэх нь зүйтэй.
3. Цээжний гялтангийн хөндийд идээт үрэвсэлтэй эмчлүүлэгчийн эмчилгээний туйлын дээд үр дүнд хүрэхийн тулд эмчилгээний цогц арга хэмжээнд хэсэг газрын болон судсаар хийх лазер эмчилгээний аргыг хэрэглэдэг болох нь чухал юм. Энэ арга нь үрэвслэлийн архагшихаас найдвартай урьдчилан сэргийлнэ.
4. Цээжний гялтангийн хөндийд идээт үрэвслэлийн оношлогоо, эмчилгээний бидний боловсруулсан бидний алгоритмыг бүтээлчээр хэрэглэснээр өвчний цаг алдалгүй эрт оношлож зөв зохистой эмчилгээ хийх баримжаатай болох тул хот, хөдөөгийн эмнэлэгт ажиллаж байгаа мэс заслын эмч нар ажилдаа мөрдлөгө болгож ажиллах нь зүйтэй юм.
5. Цээжний гялтангийн хөндийд идээт үрэвслэлтэй эмчлүүлэгч ирсэн тохиолдолд хэрэв идээт хөндий зөвлөн наалдаатай, навтраг ихтэй, олон тасалгаатай байвал цаг алдалгүй видеоторакоскопи хийж навтрагыг хуулан цэвэрлэж, хөндийг угааж цэвэрлэн гуурс тавих аргыг эзэмших хэрэгтэй.



### Äí ðæä öi âüí Áàääì ñðöýí

(Шастины Төв Эмнэлэг, Аспирант)

Шастины Төв Эмнэлгийн их эмч, Д.Бадамсүрэн “Элэгний циррозын үеийн цус бүлэгнэлтийн тогтолцооны хямралын асуудал” сэдвээр 2009 оны 5 дугаар сарын 28-нд Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан байна.

Вирусийн болон архины шалтгаантай элэгний цирроз өвчний элэгний эдэд гарах бүтэц зүйн өөрчлөлтийг тогтоож, цус бүлэгнэлтийн тогтолцооны хямрал, түүнд нөлөөлөх эмийн ургамлын үйлчилгээг судлах зорилго тавин ажилласан байна.

Хэвлэлийн тоймд элэгний циррозын эмгэг жам, морфологи өөрчлөлт, цус бүлэгнэлтийн тогтолцооны орчин үеийн ойлголт, ялангуяа циррозын үед гемостазын талаас гардаг өөрчлөлтийн үүсэх эмгэг жам, тэдгээрийг илрүүлэх лаборатори-багажийн шинжилгээнүүдийн талаар, дорно дахини анагаах ухааны онол-арга зүйд элэгний өвчний оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх, цус тогтоо эмийн ургамал-Өвсөн гүргүмийн талаар бичсэн байна.

Элэгний бүтэцийг З бус болгосон таамаглал дэвшиүүлж, түүнийгээ нотлохын тулд вирус, алкоголь,

хавсарсан хэлбэрийн циррозын гэмтлийг морфологийн хувьд судалснаар, вирусийн гаралтай циррозын үед элэгний эсийн гэмтэл хэлтэнцэрийн захын бусээс эхэлдэг бол архины шалтгаантай циррозын үед хэлтэнцэрийн төвийн бусээс эхэлж байгааг тогтоожээ.

Архины шалтгаант элэгний циррозын үед үүдэн тогтолцооны даралт ихсэлт болон дэлүүний үйл ажиллагаа идэвхижих хам шинж хожуу илэрч байгаа ба вирусийн шалтгаант циррозын үед фибриногений хэмжээ багасах, дисфибриногеми илүү илэрч байгааг илрүүлсэн байна.

Өвсөн гүргэм нь протромбины хугацаанд илүү нелөөлж байгаа бөгөөд энэ нь I, II, V, VII, X хүчин зүйлүүд, фибриноген, протромбин, K амин дэмийн дутагдлын үед хэрэглэхэд илүү тохиromжтой буюу үйлчилгээ нь K амин дэмтэй ойролцоо байгааг тогтоожээ.



І а́й ёё́ ёдөе́й - ёдөе́й ёо́я  
("Өнө-Энх" мэдрэлийн хувийн  
эмнэлгийн захирал, докторант)  
“Өнө-энх” мэдрэлийн хувийн  
эмнэлгийн захирал М.Үүрийнтуяа  
“Хэсэгчилсэн эпилепсийн эмчилгээнд  
карбамазепиныг сонгон хэрэглэх  
асуудалд” сэдэвт бүтээлээр 2009  
оны 6 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгааллаа.

Манай оронд анх удаа манай улсын үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн бүртгэлд бүртгэгдсэн карбамазепины хэсэгчилсэн эпилепсийн эмчилгээний үед эмчилгээний тунгийн хяналт хийж, карбамазепины фармакокинетикийн үзүүлэлтийг тодорхойлсон нь эпилепсийн нейрофармакологийн онолын чухал асуудал боллоо.

Хэсэгчилсэн эпилепсийн карбамазепины монотерапи эмчилгээний ёмне ба дараа ЭЭГ-ийн дүрсийн ба спектор задлалын шинжилгээнд илрэх өөрчлөлт, эмгэг сэтгэл судлалын сорилоор өвчтөний танин мэдэхүйн үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг харьцуулан судалсан байна.

Хэсэгчилсэн эпилепсийн үед карбамазепини таталт зогсоо цусны сийвэн дэх тувшруулэг, эмчилгээний тунг тодорхойлсны үндсэн дээр фармакокинетикийн үзүүлэлтийг тооцож, хувь хүн бурийн эмчилгээний тунг тодорхойлсноор эмчилгээний үр дүнг дээшлүүлэх, гаж нөлөө үүсэхээс сэргийлэх, эмийн эмчилгээний тунд хяналт хийх боломжтой болжээ..

ХЭ-ийн эмчилгээний үр дүнг ЭЭГ-ийн дурсийн ба спектор задлалын шинжилгээний аргаар хянаж, өвчний явцыг тодорхойлно. Хэсэгчилсэн эпилепситэй өвчтөнд эмгэг сэтгэл судлалын сорил хийж танин мэдэхүйн хүрээний өөрчлөлтийг илрүүлснээр өвчтөний сэтгэц, нийгмийн сэтгэл зүйн асуудал болон амьдралын мөн чанарыг сайжруулах боломж бурдэнэ.

Эпилепсийн эсрэг эмийн цусны сийвэн дэх түвшрүүлгийг тодорхойлох арга клиникийн практикт нэвтэрснээр эмийн зохистой тунг сонгох, эмчилгээний үр дүнг дээшлүүлэх, эпилепсийн эмчилгээг зөвхөн клиникийн ба ЭЭГ-ийн үзүүлэлтээр төдийгүй, эпилепсийн эсрэг эмийн фармакокинетикийн онцлогоор тодорхойлох боломжтой боллоо.



Äóðàðñ¿ðýí ãèéí Óðàí ÷èì ýã

(ЭМШУИС, докторант)

ЭМШУИС-ийн Био-Анагаахын сургуулийн Эрүүл анатомийн тэнхимийн багш Д.Уранчимэг “Хүний дэлгүүний бүтэц, судасжилт ба дархлааны үргийг туршилтын загвар үүсгэн судалсан дүн” сэдэвт бүтээлээр 2009 оны 6 дугаар сарын ийн “Анагаах ухааны докторын зэрэглэл”-ийн хурлаар Улаанбаатар хотноо докторын зэрэг хамгаалсан байна.

0-74 наасны Монгол хүмүүсийн дэлүүний бичил

бүтэц, эдийн дэд бүтцийн харьцааг насны бүлгээр тодорхойлж, хүний дэлүүний бүрхүүл хальсны цусны бичил эргэлтийн судасжилт, түүний тор үүсэх онцлог, салаалалтын өвөрмөц тогтоцыг тогтоон, нярай хүүхдийн дэлүүний артерийн хана дотор уян мембрангүй болохыг баримтжуулан, хүний дэлүүний артерийн судасны ханын бүтцийг насны бүлгээр судлан, Керногений индексийг тодорхойлсон байна. Түүнчлэн тархины дунд артерийг нь бөглөх мэс засал хийж тархины шигдээсийн загвар үүсгэн агматинаар эмчилсэн хархны дэлүүний бүтцийг судлан бүтэн дэлүүнд агуулагдах дархлаа чадамжтай CD11b+ макрофаг эс, CD8+ эс хордуулагч Тэс, CD4+CD25+ захицуулагч Т эсийг иммуногистохимиин аргаар судлан стереомикроскопоор тоолж эсийн харьцааг илрүүлэн бөгөөд энэ нь тархины шигдээсийн үеийн дархлааны хямрал, түүнд агматин зүгшрүүлэх нөлөөтэй болохыг тодорхойлсон. Энэхүү судалгааны ажил нь Монгол хүний дэлүүний бүтэц, судасжилтын талаарх бодит баримт загвар, элэг, цусны эмгэгүүдийн үед дэлүүг хэсэгчлэн авах, шилжүүлэн суулгахад тулгуур мэдээлэл болохоос гадна туршилтын амьтны тархинд шигдээс үүсгэн дэлүүний дархлааны үйлийн алдагдлыг тодорхойлсон баримт нь тархины шигдээстэй хүний дархлаа дарангуйлагдсаныг хянаж зүгшрүүлэх онолын мэдээлэл, тулгуур баримт болох ач холбогдолтой болжээ.



Öýí äæàâû í ì ° í öòóÿà

(“ì î í î ñ”ÀÓÄÑ, Àñî èðàí ò)

 “Монос”АУДС-ийн багш Ц.Мөнхтуяа “Удвэл навчт тавилгана (*Spiraea aquilegifolia* Pall)-ы фармакологийн судалгаа” сэдэвт бүтээлээр 2009 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Монгол улс, Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зарг хамгзалжээс

Уламжлалт анагаах ухаанд хорхой, шар усны өвчин болон шархыг анагаах үйлдлээр хэрэглэгдэж ирсэн Удвал навчт тавилгана (*Spiraea aquilegifolia* Pall) ургамлын бэлдмэлүүдийн ишеми-гипоксийн эсрэг үйлдлийг туршилтын амьтдад үүсгэсэн цусан хангамж болон хүчилтөрөгчийн дутагдлын хэд хэдэн эмгэг загвар дээр судалж үзэхэд Удвал навчт тавилгана (*Spiraea aquilegifolia* Pall) ургамлын идээшмэл, спиртэн ханд болон уг ургамлаас ялгасан нийлбэр алкалоид нь туршлагын амьтдаас ялгасан цусны улаан эсийн мембранны тэсвэрт чанарыг дээшлүүлэн, цус-ийлдэсний орчинд хэт исэлдэлтийн бүтээгдэхүүнийг багасгах.

ийлдэсний оксидаза сорилын хугацааг уртасгах замаар хэт исэлдэлтийг бууруулах антиоксидант идэвхтэй төдийгүй цусны булэгнэлтийн идэвхийг багасгаж, цусны бичил эргэлтийг сайжруулах үйлдэл үзүүлж байгааг тогтоосон.

Мөн туршилтын амьтдад зохиомлоор үүсгэсэн нормобарийн гипоксийн үед гипоксиг тэсвэрлэх чадвараар Актовегинаас дутахааргүй, Адреналин гидрохлоридоор үүсгэсэн уушигны хурц хавагналтын үед сурфактантын тогтворт чанарыг нэмэгдүүлэх замаар эрхтний гипоксид орох хугацааг уртасгадаг, мөн элэгний эсийн хурц үрэвслийн үед амьтдын амьдрах чадварыг 2-4 дахин дээшлүүлж ишеми-гипоксийн эсрэг үйлдэл үзүүлсэн төдийгүй тархины реперфуз-ишемийн үед УНТ-д агуулагдах биологийн идэвхит бодисын нөлөөгөөр антиоксидант үйлдэлтэй ферментүүдийн идэвхи дээшилж, улмаар тархины эд эсийг хэт исэлдэлтээс хамгаалах антиоксидант үйлдэлтэй нотолсон бөгөөд энэхүү сэдэвт ажлын хүрээнд хүчилтөрөгч, цусан хангамж дутагдлын үед манай оронд ургадаг Удвал навчит тавилгана ургамал нь орчин үеийн анагаах ухааны эмчилгээний практикт хамгийн сүүлийн үед хэрэглэгдэж буй эмийн бэлдмэлүүд (Актовегин, Пирацетам, Тиклид)-тэй үйлдлийн хувьд ойролцоо түвшинд үйлчилж байгаа нь гипоксийн эсрэг үйлдэлтэй шинэ эмийг гарган авах, эмчилгээний практикт нэвтрүүлэх үндэслэлийг бий болгожээ.



### Ööëáóóðû í Ýðäýí ý

(“Цу-Эрдэнэ”  
Докторантурт)

“Цу-Эрдэнэ” эмнэлэгийн их эмч  
“Харилцан адилгүй дасгалжуулалтын  
дараа хархны булчингийн эсд үүсэх  
апоптозд зүүний цэгийн нөлөөлөл”  
2009 оны 7 дугаар сарын 09-ний  
өдөр Бүгд Найрамдах Хятад Ард

Улсын Шанхай хотноо анагаах ухааны докторын зэрэг  
хамгаалсан байна.

Ц.Эрдэнэ өөрийн судалгаагаар зүүний цочролын аргыг харилцан адилгүй дасгалжуулалтын дараа үүсэх хархны булчингийн цуцалтын үед нөлөөлөх байдлыг судалж, энэ нь булчингийн эсийг гэмтэхээс сэргийлж, хөндлөн судалт булчингийн үйл ажиллагааг сайжруулж, булчингийн цуцалтаас үүдэн үүсэх булчингийн гэмтэйлийн-антагонист үйлдэл нь улмаар харилцан адилгүй дасгалжуулалтын дараах булчингийн цуцалт болон булчингийн эсийн апоптоз үүсэхийг зогсоох үйлдэлтэй тогтоосон байна.



### хèì ýäéï ðæééí Áàðòï áðï ô

(ЭМШУИС, Горилогч)

БиоАнагаахын Сургуулийн  
Бичил амь Дархлаа Судлалын тэнхимийн багш Ч.Баттогтох “Монгол эмэгтэйчүүдэд тохиолдож буй умайн хүзүүний өмөн ба хүний папиллома вирусийн хэв шинж, хувилбарын хамаарал” сэдвээр 2009 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгааллаа.

Манай оронд эмэгтэйчүүдийн дунд тохиолдож буй

хавдрын нэгдүгээр байранд умайн хүзүүний өмөн (УХӨ) орж байна. Монгол эмэгтэйчүүдийн дунд тохиолдож буй умайн хүзүүний өмөнгийн үед ХПВ-ийн халдвартын хэв шинжийг тогтоох, өмөнд өртөмтгийг байдлыг вирусийн геномын хувилбар болон эзэн биеийн зарим ургийн генотипийн хэлбэртэй уялдуулан судлах зорилготой судалгааны ажил хийсэн. Судалгааны үр дүнг товчлон авч үзвэл ХПВ-ийн хэв шинжийг илрүүлэхэд ДНХ чип микроаррэйн арга нь ПГУ-аас илүү үр дүнтэй болох нь тогтоогдоо. УХӨ-гийн 54%-д ХПВ-16 зонхилон илэрч, ХПВ-58, 18, 33 хэв шинж дараалан өндөр хувьтай тархсан байна. ХПВ-ийн өмөн үүсгэх өндөр эрсдэлт хэв шинжийн халдвартын нь УХӨ-г хамгийн их хувьтай ( $R^2$  67%) нөхцөлдүүлж байна. Монгол улсад ХПВ-16 хэв шинжийн Европын дэд хэв шинжид хамаарах хувилбарууд тэр дундаа Европын эгэл хувилбар ба E(T350G), E(G94A) хувилбар, ХПВ-33 хэв шинжийн MN17-6-0 хувилбар хамгийн өргөн тархсан байна. Эзэн биеийн глутатион-S-трансфераза эсгэгийн мью ангийн 1-р хувилбарын делецийн генотип УХӨ-д өртөмтгийг байдлыг тодорхой хувиар ( $R^2$ -7.1%) нөхцөлдүүлж байна.

Судалгааны ажлын практик зөвлөмж:

1. Монгол оронд ХПВ-ийн халдвартыг илрүүлэх молекул биологийн оношлогоо болон тандалт судалгааг өргөжүүлэх
2. УХӨ-гөөс урьдчилан сэргийлэх цогц бодлогод ХПВ-ийн халдвартыг илрүүлэх, халдвартай эмэгтэйчүүдийг хянах менежментийг боловсруулах
3. ХПВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх өвөрмөц болон өвөрмөц бус арга хэмжээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусгаж тогтмолжуулах
4. Шинээр эмнэл зүйн практик нэвтрээд байгаа ХПВ-ийн халдвартын эсрэг вакциныг өөрийн орны хэмжээнд нэвтрүүлэх боломж эрэлхийлэх
5. ХПВ-ийн хэв шинжийн тархалтын талаарх мэдээг ДЭМБ-ийн мэдээллийн санд байрлуулах



### Ààø äàâààæéí Î òäí í áàààò

(ÁÄÖ³ Ñ-Ò äí êòí ðäí ò)

БГХӨСҮТ-ийн захирал  
Д.Отгонбаатар "Монгол дахь галзуу өвчний эпидемиологи, эпизоотологийн зарим онцлог" сэдвээр 2009 оны 10 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотноо ЭМШУИС-ийн эрдмийн зөвлөлөөр анагаах ухааны докторын зээрг хамгаалав.

Энэхүү судалгааны ажил нь Монгол орон дахь галзуу өвчний байгалийн голомтын төлөв байдал, эпизоотологи, эпидемиологийн онцлогийг тодорхойлж молекул биологийн түвшинд судлаж нэгдсэн дүгнэлт өгсөн анхны бүтээл болов.

Монголын нутаг дэвсгэрээс илрүүлсэн галзуу өвчний вирусийн геномын хэсгийн нуклеин хүчлийн дарааллыг тодорхойлох судалгааг анх удаа хийж, вирус нь *Lyssavirus*-ийн генийн I хэлбэрийн Евро-Азид өргөн тархсан филогенетикийн “Steppe” бүлэгт хамрагдаж байгааг тогтоожээ. Монголд ялгасан энэхүү лиссавирусийн омгийн N гений нүkleотидийн

бүрэн дараалал (414 bp) нь судлаач Д.Огтобаатар нарын нэрээр EF614254, EF614255, EF614256, EF614257 дугаартайгаар олон улсын генийн сан (Genbank)-д бүртгэгдсэн байна. Энэ нь Монгол улсаас лиссавирусийн нуклеотидийн дарааллыг олон улсын судалгааны эргэлтэнд оруулсан анхны тохиолдол, эрдэм шинжилгээний чухал бүтээл бөгөөд судлаачийн Монголд төдийгүй дэлхийн анагаах ухааны мэдлэгийн санд оруулсан томоохон хувь нэмэр оруулсан байна. Судалгааны ажлын хүрээнд 3 стандарт, 2 арга зүй боловсруулж ОХУ, Франц, Вьетнам, ХБНГУ зэрэг орны эрдэм шинжилгээний академи, хүрээлэнгүүдэд зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурлуудад уг сэдвээр илтгэлт тавьж олон улсын томоохон сэтгүүлүүдэд нийтлүүлсэн нь онол практикийн өндөр ач холбогдолтойг болжээ.

Уг нэг сэдэвт бүтээл нь Монголын анагаах ухааны эпидемиологи-микробиологийн салбарт хүний галзуу өвчний талаар хийгдсэн анхны эрдэм шинжилгээ судалгааны нэгдсэн ажил байна.



**Àí èäí ðæàâû í Õðàí ÷èí ýä**  
(ЭМШУИС, докторант)  
ЭМШУИС-ийн НАСС-ын багш  
Д.Уранчимэг “Монгол хүний эрүүн доорх шүлсний булчирхайн чулуужих өвчний эмнэл зүй, эдийн өөрчлөлт ба чулууны химиин найрлага” сэдвээр 2009 оны 11 дүгээр 12-ны өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны

докторын зэрэг хамгаалсан байна.

Судалгаагаараа шүлсний булчирхайн чулуужих өвчний үед булчирхайд гарах бүтцийн өөрчлөлтүүд, эрүүн доорх шүлсний булчирхайн эсүүдийг ёсгөвөрлөн рибоксинуклейнхүчил (RHN)-ийг ялган, аденоовирусээр (BMP-2) халдвартуулахад ясны генүүд болох коллаген 1, остеокальцин, остеопонтин, шүлтлэг фосфатаз идэвхжэдэг, чулуунд агуулагдах бактерийн төрөл зүйлийг тэдгээрийн ДНХ-ийн дэс дарааллаар тодорхойлж, шүлсний булчирхайн чулууны химиин найрлагын бүтцийг эмнэл зүйтэй нь холбон судалсан байна.



**Äàø çýâýæéí Çáí àäí ï¿ðóý**  
(Говь Алтай аймаг Нэгдсэн  
эмнэлэг, горилогч)

Говь-Алтай аймаг Нэгдсэн эмнэлэгийн Уламжлалт эмнэлгийн тасгийн эрхлэгч, их эмч Д.Зандансүрэн “Синдэрийн бүтэц, найрлага, гадар шарханд үзүүлэх нөлөөллийг судалсан нь” сэдвээр 2009 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улаанбаатар хотноо эмзүйн ухааны докторын зээрэг хамгаалсан байна.

Д.Зандансүрэн Уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэж ирсэн эмт эрдэс синдэрийн найрлага дахь эрдсийн агууламж, химиин найрлагыг тогтоон, ёсчлон номхогж, эмийн бэлдмэл бэлтгэн эмчилгээний нөлөөллийг нь туршин баталгаажуулснаар нэг талаас уг эмт бодисын амьтын шарханд үзүүлж буй нөлөөллийн механизмыг түүний найрлагатай нь холбон тайлбарлах боломжийг нээж гаргасан байна. Түүнчлэн эмчилгээнд хэрэглэх синдэрийн зүйлийг зөв тогтоосноор байгалийн

гаралтай, үйлдэл сайтай эмийн бэлдмэл бэлтгэх боломж бүрдүүлжээ.



### **Æàì ïðàí ààââ Æàââci àà**

(УБЭҮ-ийн Эмнэлэг-Сувилалын алба, докторант)

УБЭҮ-ийн Эмнэлэг-Сувилалын албаны эмч Жамсранжав Жавсмаа “УБЭҮ-ийн ажиллагдын өвчлөл, хөдөлмөрийн нөхцлийн судалгаа” сэдвээр 2009 оны 12 дугаар 10-ны өдөр, Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан байна.

Улын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн ажиллагдын хөдөлмөрийн чадвар түр алдах өвчлөл, тус үйлдвэрийн ажиллагдын мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тархалт, хөдөлмөрийн чадвараа алдсан уурхайчдын нийгэм-эдийн засгийн байдлыг судлан, үйлдвэрийн ажлын байруудын хөдөлмөрийн нөхцлийг тодорхойлон тус үйлдвэрийн ажиллагдын өвчлөлийг бууруулах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах арга замыг тодорхойлон судалгааны үр дүнд практик зөвлөмж гаргасан ба цаашид УБЭҮ болон монгол орны ижил төстэй баяжуулах уул уурхайн үйлдвэрүүдэд судалгааны үр дүн, практик зөвлөмжийг нэвтрүүлэх ач холбогдолтой юм.

### **Í ÐÀÈÖÈÈ Çä ÅÈ à**

**Àæëñ í áàéðí û õº äº ëí ° ðèéí í ° õöëèéä ñàéæðóóëëð òàëàäð**

1. Эрүүл ажлын байр хөтөлбөрийг үйлдвэрийн бүх цехүүдэд хэрэгжүүлэх нь хөдөлмөрийн нөхцөл, ажлын зохион байгуулалт, ажиллагдын зан үйл, эмнэлгийн тусламж үйлчилгээ, гадаад орчны нөлөөлөл зэрэг ажиллагдын ХЧТАӨ, МШӨ-д нөлөөлдөг бүх хүчин зүйлсийг бууруулах цогц арга хэмжээ болох сайн талтай юм.
2. Цутгуурын цех, авто тээврийн байгууллагын хэсэг газрын болон ерөнхий агааржуулалтын үр дүнг тооцож, агааржуулалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх
3. Хүнд даацын тээврийн хэрэгслийн кабини битүүмжлэлийг сайжруулан, хасах даралт үүсгэх нөхцлийг бүрдүүлэх, шинээр авч байгаа хүнд даацын тээврийн хэрэгслийн кабини агааржуулалтын системийн сорох төхөөрөмжийн багтаамжинд хяналт тавих
4. Ажлын байран дахь үйлдвэрлэлийн онцлогт зохицуулан ерөнхий тоосны ЗДХ-г багасган тогтоож, тоостой тэмцэх иж бүрэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үр дүнг тооцох “Ерөнхий тоосны багасгах стандартыг боловсруулах”
5. Ажлын байранд З төрлийн мониторингийг иж бүрнээр нь хийж, шинжилгээний үр дүнг бодлого, шийдвэр гаргахад ашиглах
6. Ажлын байрны агаар дахь зарим химиин бодис ЗДХ-ээс их байгаа АТБ-ын агергатын засварын хэсэг, ЗМҮ-ийн цутгуурын цехүүдэд онцгой анхаарч агаар дахь химиин бодисын уршилтыг бууруулах цогц арга хэмжээ боловсруулж ажиллах ялангуяа агергатын эд ангийг задалсны дараа битүүмжлэл сайтай орчинд ажилласан тос маслыг авч солих, цутгуурын

- цехэд шинээр орж ирж байгаа техник тоног төхөөрөмжийг суурилуулахдаа проект, ажлын талбайн багтаамж, хөдөлмөр хамгааллын асуудлыг цогцоор нь шийдэх, цутгуурын цехийн хэвний хэсэгт хэвийг илрэхийг орчинд гадуур нь будаг ацетоноор шүржих бэхжүүлж хийж байгаа үйл ажиллагааг битүүмжлэл сайтай орчинд хийх технологи нэвтрүүлэхэд анхаарах
7. Баяжуулах үйлдвэрийн бутлуурын шал, кранчны кабины ерөнхий доргион ЗДХ-ээс их байгаа тул доргион шингээгч, зөвлөвч шаланд байрлуулах, кранчдад доргионос хамгаалах бээлий олгох
  8. Гэрэлтүүлэг цутгуурын цех, уулын хэсэг, АТБ, БҮ-ийн хэсгүүдэд бага тодорхойлогдож байгаа тул эдгээр цехийн гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг сайжруулах, гэрлийн лапмын хүчин чадлыг нэмэгдүүлэх
  9. Тухайн жилд хувийн хамгаалах хувцас хэрэгслийн зөв сонголт, тогтмол зөв хэрэглэх байдал зэрэгт хяналт тавьж, үнэлэлт өгч ажиллах
  10. Силикозыг багасгах, устгах үйлдвэрийн түвшингийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Ааёёёааннаа ўдүгээ ὶ ýí äééí ծёүаёёаа  
ñaéæðóööäö öäéäåð**
1. Ажиллагсдад хийгдэх урьдчилсан ба хугацаат үзлэгийн чанар, үр дүнг дээшлүүлэх ялангуяа эрүүл мэндийн үзлэг шинжилгээний дүгнэлтийн 1%-ийг архивт хадгалах, уушгины үйл ажиллагааны сорил хийх, уушгины рентген зургийг ОУХБ-ын Уушкиг тоосжих өвчиний ангилалаар ангилж унших, дүгнэх
  2. Тоос болон химиин бодисын нөлөөнд өртөж байгаа ажилчдын өвчиний болон ажлын түүх, дээрхи шалтгаант өвчиний үед гарах шинж тэмдэг, хам шинжийн талаар ажилчдаас асуумж авч мэргэжлээс шалтгаалах өвчин, ХЧТАӨ-ийг эрт оношлох, үр дүнтэй эмчлэх, урьдчилан сэргийлэхэд ашиглаж байх
  3. МШӨ-ийн улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажиллагсдын нийгмийн хамгаалал, нехөн сэргээх эмчилгээний үр дүнг сайжруулах
  4. ХЧТАӨ, МШӨ-ийг жил бүр үргэлжлүүлэн судалж, өвчлөлийг бууруулах иж бүрэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, эдийн засгийн үр ашгийг тооцож ажиллах
- Ааёёёааннаа ўдүгээ ὶ ýí äééí áí ëí àñðí ё ǐ eä ö öäéäåð**
1. Үйлдвэр дээрээ эрүүл ажлын байр хөтөлбөрөөр дамжуулан ажиллагсдад эрүүл мэндийн боловсрол олгох
  2. Шинээр ажилд орж байгаа хүмүүсийг эрүүл мэндээ хамгаалах чадвартай болгох, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх аргын талаар сургалтанд хамруулж байх
  3. Ажиллагсдад “эрүүл цех”, “архи, тамхигүй хамт олон”, “эрүүл хоололтыг дэмжих” зэрэг кампанит ажлуудыг явуулж, шагнаж урамшуулдаг тогтолцоотой болгох
  4. Ажиллагсдын хувийн хамгаалах хувцас хэрэгслийн зөв сонгох, тогтмол, зөв хэрэглүүлж занших талаар сургалт болон зохион байгуулалтын ажлыг тогтмолжуулах



### Î ðî ðí ðí äééí Î þ ó ÷ëì úá

(Нийслэлийн эрүүл мэндийн газар, горилогч)

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын ажилтан О.Оюунчимэг “Монгол орны зарим бус нутгийн хүн амын дунд Ку халууралтын тархалтын судалгаа” сэдвээр 2009 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотноо анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан байна.

